


ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙГ ХҮНИЙ ЭРХИЙН ӨНЦГӨӨР ХАРАХ НЬ

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн байгууллага, хөгжлийн бэрхшээлтэй хүний асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй хамтран ажилладаг, үйлчилгээ үзүүлдэг хэн бүхэнд зориулав.



Улаанбаатар хот
2022 он

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙГ ХҮНИЙ ЭРХИЙН ӨНЦГӨӨР ХАРАХ НЬ

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн байгууллага, хөгжлийн бэрхшээлтэй хүний асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй хамтран ажилладаг, үйлчилгээ үзүүлдэг хэн бүхэнд зориулав.



Улаанбаатар хот
2022 он

Тус гарын авлагыг Канад Улсын Засгийн газрын санхүүжилттэй Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага (ОУЭЗХБ)-ын хэрэгжүүлж буй “Монгол Улсад жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг бэхжүүлэх нь” (2019-2023) төслийн хүрээнд боловсруулан, хэвлэв.

Төслийн зорилго нь иргэний нийгмийн чадавхийг бэхжүүлснээр жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчдод хууль зүйн туслалцаа үзүүлэх боломжийг нэмэгдүүлж, хохирогч-төвтэй үйлчилгээг хүргэж, олон нийтийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх юм.

Төслийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг www.idlo.int цахим хуудас болон төслийн @IDLOmongol Фэйсбүүк хуудаснаас авна уу.

Боловсруулсан: **Р.Будханд,**
*Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын
Үндэсний холбооны ажилтан, сургагч багш*

Г.Баянзул,
*Боловсролын Судалгааны Үндэсний Хүрээлэнгийн Гадаад
хэлний төвийн эрхлэгч*

Б.Аюуш
Төр Иргэн Түншлэл ТББ-ын тэргүүн, сургагч багш

Зөвлөсөн: **Б.Аюуш**
Жендэр болон хүний эрхийн зөвлөх

Хянасан: **Ц.Оюунбаатар,**
*Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын
Үндэсний холбооны Ерөнхийлөгч*

Хэвлэлд бэлтгэсэн: Г.Баянзул, С. Одончимэг

Хэвлэлийн дизайн: Т.Жархын

Зохиогчийн эрх@ 2022. Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага (IDLO)

Энэ гарын авлагад илэрхийлсэн үзэл бодол, агуулгыг зохиогчид бие даан боловсруулсан бөгөөд Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага болон төслийн санхүүжүүлэгч байгууллагын үзэл бодол, байр суурийг илэрхийлэхгүй болно.

ГАРЧИГ

Товчилсон үгийн жагсаалт	4
Удиртгал	6
БҮЛЭГ 1. ХҮҮХЭД НАС	7
1.1. Ургийн үед эхэд үзүүлэх төрийн үйлчилгээ	8
1.2. Хүүхэд насанд төрөөс үзүүлэх үйлчилгээ	21
1.3. Хүүхдийн эсрэг хүчирхийлэл	63
БҮЛЭГ 2. НАСАНД ХҮРЭГЧ 18 НАСНААС ДЭЭШ	73
2.1. Хүний эрх, жендэрийн тухай ойлголт	73
2.2. Гэр бүлийн хүчирхийлэл	110
ХАВСРАЛТ 1.	120
ХАВСРАЛТ 2.	124
АШИГЛАСАН НОМ, ЭХ СУРВАЛЖ	134

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ЖСХ	Жендэрт суурилсан хүчирхийлэл
ГБХ	Гэр бүлийн хүчирхийлэл
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага
ДОХ	Дархлалын Олдмол Хомсдол
ЭМТ	Эрүүл Мэндийн Төв
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
БОЭТ	Бүсийн Оношилгоо Эмчилгээний Төв
НӨАТ	Нэмүү өртгийн албан татвар
БЗДХ	Бэлгийн Замаар Дамжих Халдвар
ХДХВ	Хүний Дархлал Хомсдлын Вирус
ТҮЦ машин	Төрийн үйлчилгээний цахим машин
АХБ	Азийн хөгжлийн банк
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
ШУТИС	Шинжлэх ухаан технологийн их сургууль
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
МХБИБҮХ	Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үндэсний холбоо
УИХ	Улсын Их Хурал
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ХБХЭК	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн конвенц
ХБХХЕГ	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар
ХБХЭМБНХК	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс

ХБХЭЭХ	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо
ХЗДХС	Хууль зүй дотоод хэргийн сайд
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ХНХС	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд

Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна. Тэдэнд оюун ухаан, өрлөг сэтгэл заяасан бөгөөд өөр хоорондоо ахан дүүгийн ёсоор харилцах ёстой¹.

1. Хүний эрхийн түгээмэл тунхаглал, I дүгээр зүйл, 1946 он.

УДИРТГАЛ

Хүн болж төрнө гэдэг ховорхон тохиох хувь заяа учраас хувь заяандаа эзэн болж амьдрах нь хүн төрөлхтний туйлын хүслэн билээ.

Хорвоод мэндэлсэн хүн болгон ялгаатай байдлаасаа үл хамааран сурах, хөдөлмөрлөх, эрсдэлгүй орчинд сайхан амьдрах, алагчлал хүчирхийллээс ангид байх зэрэг хүний бүхий л эрхийг эдлэх ёстой.

Хүний эрх гэдэг нь төрөлхөөс заяасан бөгөөд хамгийн эгэл утгаараа хүнд өөрт нь байдаг нийгмийн дотор заавал эдлэх боломжийг хэлдэг. Харин энэхүү боломжоо ашиглахад хүний ялгаатай байдал янз бүрээр нөлөөлдөг.

Ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, насанд хүрэгчид өөрт байгаа согогийн онцлогоос шалтгаалан төрөл бүрийн нэмэлт дэмжлэг авч байж, эрхээ эдлэх боломж нь бүрддэг.

МХБИБҮХ-ноос 1997 оноос хойш НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцд Монгол Улс нэгдэн орох асуудлыг шийдвэрлүүлж, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль батлуулж, салбарын 10 гаруй хуулинд хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээг тусгуулж, хуулиа дагасан олон журам гаргуулахын зэрэгцээ нийгмийн хандлагыг өөрчлөх чиглэлээр олон арга хэмжээ авч хэрэгжүүлсэн юм.

Нэг талаас нийгмийн хандлага эерэг болж, эрх зүйн орчин сайжирсан хэдий ч нөгөө талаас иргэдийн эрх зүйн мэдлэг хангалтгүй, тэдний идэвх оролцоо сул байгаагаас болоод хууль нь бүрэн хэрэгжихгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэд маань эрхээ бүрэн дүүрэн эдэлж чадахгүй байсаар байна.

Иргэд тодорхой мэдээлэлтэй, эрх зүйн зохих мэдлэгтэй байж гэмээнэ хүчирхэг иргэн болон төлөвших бөгөөд тэдний оролцоо нь нэмэгдэж, хуулийн хэрэгжилт сайжирна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх зүйн орчин, үйлчилгээний талаар цэгцтэй мэдлэгийг ойлгомжтой байдлаар өгөх зорилгоор энэхүү гарын авлагыг боловсруулсан бөгөөд та бүхний амьдралд тус дэм болно гэж найдаж байна.

Энэхүү гарын авлага боловсруулах, түгээн дэлгэрүүлэхэд гүн туслалцаа үзүүлсэн Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллагын хамт олонд гүн талархал илэрхийлье.

*Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын
Үндэсний холбооны Ерөнхийлөгч
Ц.Оюунбаатар*



БҮЛЭГ 1. ХҮҮХЭД НАС

Ургийн үеэс² 18 хүртэлх насыг хүүхэд нас гэнэ. Хүүхэд бие бялдар, оюун санаа, боловсрол, амьдралын туршлагын хувьд бүрэн гүйцэд төлөвшөөгүй, тусгай хэрэгцээ, хамгаалалт шаардлагатай байдаг учраас хүүхдийн эрхийг тусгайлан авч үзэж хамгаалдаг. Хүүхдийн эдлэх ёстой эрх, эрх чөлөө, төрөөс болон эцэг эхээс нь үзүүлэх ёстой халамж, үйлчилгээний цогцыг хүүхдийн эрх гэж нэрлэж болно.

Хүүхэд байхдаа туулсан амьдралын туршлага нь хүний насан туршийн амжилт бүтээлд нөлөөлдөг. “Хүүхдийн хэрэгцээнд нийцсэн хөгжүүлэх үйлчилгээ, дэмжлэг, хамгаалалтыг хөгжлийн хоцрогдолтой, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, гэр бүлүүдэд цаг алдалгүй хүргэж чадахгүй бол тэдний туулах хүндрэл, бэрхшээл улам гүнзгийрч, насан туршийн уршигт нөлөөлөл үзүүлэн, яваандаа нийгмийн амьдралаас тусгаарлагдахад хүргэдэг”³

Энэхүү гарын авлагын нэгдүгээр бүлэгт эхийн хэвлийд ураг бүрэлдэн бий болсон цагаас эх, хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, нийгмийн халамж, хамгаалал, боловсролын үйлчилгээний талаар танилцуулах болно.

Гарын авлагыг уншиж танилцахад дараах байдлаар хүснэгтлэн ялгасан болно.



2. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолт

3. Нээлттэй нийгэм форум, Бага насны хүүхдийн хөгжил, хөгжлийн бэрхшээл, асуудал дэвшүүлсэн тайлан, 5 дугаар тал, Улаанбаатар, 2015 он

! САНАМЖ

📋 МЭДЭЭЛЭЛ

1.1. Ургийн үед эхэд үзүүлэх төрийн үйлчилгээ

Түлхүүр үг:

- Бага нас
- Жирэмсний хяналт
- Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр, Жирэмсний болон амаржсаны тэтгэмж
- Нөхөн үржихүйн эрх, эрүүл мэнд

Дүрүүд:



- Ээж



- Нийгмийн ажилтан



- Эмч



-Нийгмийн даатгалын байцаагч

Түүх

Би жирэмсэн боллоо. Эрүүл мэндийн үйлчилгээ авах эрхийнхээ дагуу жирэмсний хяналтад орох ёстой учир өрхийн эмнэлэг оров. Өрхийн эмч надтай ярилцаж, олон зөвлөгөө өгөөд анхны үзлэг хийв. Жирэмсний эхний үзлэгээр эмч надаас нийгмийн байдал, ажил хөдөлмөр эрхлэлт, хүчирхийллийн⁴ талаарх мэдээллийг авч, Бэлгийн Замаар Дамжих Халдварт (БЗДХ) өвчнөөс сэргийлэх, болон бусад зөвлөгөө өглөө.



Хэрвээ би:

- Хөгжлийн бэрхшээлтэй,
- Хөдөлмөрийн чадвараа түр алдсан,
- Зүрх судасны өвчтэй,
- Өмнө нь ямар нэг хүндрэлтэй төрсөн,
- Ихэр хүүхэд тээж байгаа,
- Эрхтэн шилжүүлэх мэс засал хийлгэсэн зэрэг жирэмсэн үеийн эрсдэлтэй бол дүүрэг, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн хяналтад байна.

Мөн миний нас, хэд дэх хүүхдээ тээж байгаа зэргээс гадна, нэн ядуу эсвэл хоол тэжээлийн дутагдалтай, архи тамхи, мансууруулах бодис хэрэглэдэг, хүчирхийлэлтэй гэр бүл, орчинд байдаг бол өндөр эрсдэлтэй бүлэгт хамаардаг ажээ.



Жирэмсний хяналтын үед цусны бүлэг, резус үзлэг, ХДХВ, Элэгний В, С вирус, тэмбүү илрүүлэх шинжилгээ, шээсний болон цусны ерөнхий шинжилгээ, үтрээ, умайн хүзүүний наалдцын шинжилгээ, хэт авиан шинжилгээ⁵-г миний зөвлөснөөр заасан хугацаанд хийлгээрэй.



Яагаад ийм олон шинжилгээ хийдэг юм бэ?

4. "Жирэмсэн, төрөх, төрсний дараах үед үзүүлэх тусламж үйлчилгээний журам", Эрүүл мэндийн сайдын тушаал, 2020 оны А\318-р тушаалын 1-р хавсралт

5. "Жирэмсэн эмэгтэйн үзлэг, шинжилгээний товлал", Эрүүл мэндийн сайдын тушаал, 2020 оны А\318-р тушаалын 2-р хавсралт



Хэрэв Хүний Дархлал Хомсдлын Вирус (ХДХВ), халдварт гепатит В вирус, тэмбүүгийн халдвартай бол эхээс урагт эдгээр өвчин дамжихыг таслан зогсоож эмчилнэ. Бас энэ “Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр”-ийг танд өгье. Үүнийг уншиж, ээж болохдоо бэлдээрэй. Тэгээд жирэмсний хяналтад үзүүлэх, амаржих газар төрөхөөр очих, хүүхдээ гэрийн эргэлтийн хяналтанд үзүүлэх, дархлаажуулалтад хамрагдах болон эрүүл мэндийн байгууллагад очихдоо дэвтрээ заавал авч ирэх ёстой шүү.



МЭДЭЭЛЭЛ

Жирэмсний хяналт гэж юу вэ?

Эхийг жирэмсэн байх хугацаанд буюу төрөх хүртэл биеийн эрүүл мэндийн байдал, ургийн өсөлт хөгжилтөд юу, хэрхэн нөлөөлж байгааг илрүүлэх, жирэмсэн үед үзүүлж байгаа тусламж, үзлэг, шинжилгээний дүгнэлт зэрэг эрүүл мэндийн бүхий л тусламж үйлчилгээг цогцоор нь жирэмсний хяналт гэнэ.

Жирэмсний хяналтад орсноор өөрийн эрүүл мэндийн байдлын талаар тодорхой мэдэж, удамшлын болон олдмол, далд шинж тэмдэггүй өвчин эмгэгийг илрүүлэх, жирэмсэн байх болон амаржих үед нөлөөлж болох өвчин эмгэгүүдийг эрт илрүүлж оношлуулан, үүсч болох хүндрэл, ургийн өсөлт хөгжилтөд нөлөөлж болох тодорхой хүчин зүйлсийг мэдэж урьдчилан сэргийлэх боломжийг бүрдүүлдэг ач холбогдолтой юм байна.

1-4 долоо хоногтой жирэмсэн	Ураг 1 сартай	- Цусны ерөнхий шинжилгээ - Цусны бүлэг, резус - ХДХВ илрүүлэх сорил
5-8 долоо хоногтой жирэмсэн	Ураг 2 сартай	- Тэмбүү илрүүлэх сорил - Шээсний ерөнхий шинжилгээ - Элэгний В,С вирус илрүүлэх шинжилгээ
9-12 долоо хоногтой жирэмсэн	Ураг 3 сартай	- Мазокийн шинжилгээ - Хэт авиан шинжилгээ - 9-11 долоо хоногтойд \хоёрол тест, эмчийн заалтаар

13-16 долоо хоногтой жирэмсэн	Ураг 4 сартай	- 11-13 долоо хоногтойд NT харуулах - Шээсэнд нян илрүүлэх
17-20 долоо хоногтой жирэмсэн	Ураг 5 сартай	- 18-22 долоо хоногтойд ургийн бүтцийн хэт авиан шинжилгээ - 13-18 долоо хоногтойд \гурвал тест, эмчийн заалтаар\
21-24 долоо хоногтой жирэмсэн	Ураг 6 сартай	- 20 долоо хоногтойд жирэмсний тэтгэмж
25-28 долоо хоногтой жирэмсэн	Ураг 7 сартай	- Тэмбүүгийн сорил давтана
29-32 долоо хоногтой жирэмсэн	Ураг 8 сартай	- Шээсний ерөнхий шинжилгээ - Мазокийн шинжилгээ - Хэт авиан шинжилгээ - Жирэмсний амралт \32 долоо хоногтойд\
33-36 долоо хоногтой жирэмсэн	Ураг 9 сартай	- 36-37 долоо хоногтойд хэт авиан шинжилгээ

Жирэмслэлт хэвийн ч гэсэн жирэмсний 20 болон 32 долоо хоногтойд сум, дүүрэг, тосгоны Эрүүл Мэндийн Төв (ЭМТ)-ийн эх барих эмэгтэйчүүдийн эмчид үзүүлж зөвлөгөө авна. Шаардлагатай тохиолдолд эмч нар намайг Бүсийн Оношилгоо Эмчилгээний Төв (БОЭТ), төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд үзүүлнэ.



МЭДЭЭЛЭЛ

ДОХ (Дархлалын Олдмол Хомсдол) гэж юу вэ?

ДОХ нь хүний дархлал хомсдолын вирусээр үүсгэгддэг бөгөөд халдвартай эхээс хүүхдэд хөхний сүүгээр хүртэл дамждаг тул эх эмчлүүлэх шаардлагатай.

Гепатит Б гэж юу вэ?

Элгийг гэмтээдэг Гепатит Б вирусээр эхээс урагт жирэмсэн болон төрөх үед халдварладаг. Хүүхдүүдэд энэ халдвар амьдралын турш архагшдаг учир эх хүүхдээ төрүүлэхээс өмнө эмчлүүлэх ёстой.

БЗДХ -тай үед зарим үе шинж тэмдэг илрэхгүй, өөрөө ч анзаарахгүй байх тохиолдол байдаг юм байна. Шинжилгээгээр БЗДХ үүсгэгч илэрвэл бэлгийн хамтрагчаа ч шинжлүүлж зөвхөн эмчийн зөвлөгөөний дагуу хамтдаа, тууштай эмчлүүлнэ. Тэгэхгүй бол БЗДХ нь урагт дамжих, удаан хугацааны дараа үргүйдэл, аарцгийн үрэвсэл, савны гадуурх жирэмслэлт, умайн хүзүүн хавдар зэргийг үүсэхэд нөлөөлдөг ажээ.



МЭДЭЭЛЭЛ

Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр гэж юу вэ?

Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр буюу ягаан дэвтэр бол эх болон хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжлийн байдлыг бүртгэх, хянах, дэмжих, үнэлэх зориулалттай бүртгэл юм.

Эхийн бие махбод, сэтгэл санаа, амьдралын дадал хэвшил, хоол унд, дасгал хөдөлгөөн, хүсэл сонирхол хүүхдийн өсөлт хөгжилтөд нөлөөлдөг учир амралт, хооллолт, хөдөлгөөн гээд бүхий л зүйлийг хэрхэн зохицуулах тухай зөвлөгөөг энд бичсэн. Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтрээс өөрийн эрүүл мэндийн талаарх мэдээллийг уншиж танилцан, эх хүний заавал мэдэж байх зүйлс, ямар тохиолдолд хэнд хандан зөвлөгөө авах, хүүхдийг нярай үеэс нь эхлэн насны онцлогт тохируулан хэрхэн асрах, яаж хооллох тухай зөвлөмж, мэдээллийг авдаг.

Ягаан дэвтрээ хаяж гээхгүй хямгатай авч, асуумжид хариулж хөтөлж явах нь эхийн үүрэг юм байна.



Жирэмсний хяналтад хүчирхийлэл ямар хамаатай юм бол?



Та амар тайван байж, эсэн мэнд амаржихад хэн ч саад болох ёсгүй учраас жирэмсний хяналтад хүчирхийллийн талаар асуулт, судалгаа оруулдаг. Нөхөн үржихүйн эрхийг тань хэн нэгэн зөрчихөөс сэргийлж байна гэсэн үг л дээ.



Нөхөн үржихүйн эрх гэж юуг хэлээд байна?



Ямар ч хүн гэр бүл төлөвлөх, жирэмслэх, төрөлт хоорондын зайгаа шийдвэрлэх, хүүхэд асрах, хүүхэдтэй болох эсэхээ шийдэх, урагт эсвэл нярайд өвчин халдахаас сэргийлэх тусламж, үйлчилгээ авахыг хэлж байгаа юм.



Хүчирхийлэлд өртвөл би хаашаа хандах ёстой вэ?



Та эсэн мэнд амьдрах, аюулгүй байдлаа хамгаалуулах эрхтэй учир гэр орон, сургууль, найз нөхдийн харилцаа, сургуулийн орчин, ажлын байр аюултай санагдаж байвал заавал 102, 107, 108 тусгай дугаарт дуудлага өгөөрэй.



Мэдээлэл өгөхөөр улам аюултай болох юм биш үү?



Таны дуудлага, мэдээллийг нууцалж таныг хуулийн⁶ дагуу хамгаалалтад авна. Хүчирхийллийн улмаас жирэмсний хүндрэл, амьгүй ураг төрөх гэх мэт сөрөг үр дагаврууд гардаг. Эрүүл мэнд, амь насанд аюултай үед Нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байруудад хандаарай. Мөн төрөл садангийн хүмүүсийн хамгаалалтад ороорой. Нууцлалыг задруулсан этгээдэд хуулийн хариуцлага хүлээлгэнэ.

Тажирэмсний хяналтын үзлэгийн үеэр эмч, эмнэлгийн ажилтны зүгээс сэтгэл санаа, бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртөж болзошгүй. Тухайлбал өндрийн тохируулгатай эмэгтэйчүүдийн үзлэгийн ор байхгүй шалтгаанаар үзлэг, шинжилгээ хийхээс зайлсхийх, хөгжлийн бэрхшээлийн онцлогийг харгалзахгүйгээр хүртээмжгүй орчинд бусад хүмүүстэй адил шаардлага тавих, үг хэлээр



6. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, 2013 он.

доромжлох, бэлгийн сэдэлтэй үг хэллэг хэрэглэх зэрэг нь айдастай, сэтгэл түгшээсэн, таагүй мэдрэмж төрүүлж байвал заавал тусламж хүсээрэй. Учир нь хяналтын эмчийн үзлэгт дахин очихгүй байх сэтгэгдэл төрүүлэх нь эсэн мэнд амаржихуйд нөлөөлж болзошгүй. Та нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ авахдаа хүчирхийллээс хамгаалуулах эрхтэй.

Бүх хүн эмнэлгийн болон өөр бусад аливаа хөндлөнгийн оролдлогоос ангид байж, бэлгийн болон нөхөн үржихүйн амьдралаа хянаж, шийдвэр гаргаж, үнэ төлбөргүй мэдээлэл, зөвлөгөө авах эрхтэй. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгахгүйгээр тэдний нөхөн үржихүйн эрхийг бүрэн хангах боломжгүй.

Нөхөн Үржихүйн эрх гэдэг нь хувь хүн, гэр бүл хэдэн хүүхэд төрүүлэхээ чөлөөтэй, хариуцлагатайгаар шийдвэрлэхийн сацуу нөхөн үржихүйн талаар мэдлэг эзэмших, мэдээлэл авах, хүссэн үедээ жирэмсэлж төрөх, нөхөн үржихүйн хамгийн сайн, чанартай тусламж үйлчилгээг авах эрхтэй байхыг хэлнэ.

Жирэмсэн эмэгтэйчүүдийг төрөх үед болон төрсний дараа эх, хүүхдийн эрүүл мэндийн үйлчилгээ, асаргаа сувиллын тусламж үзүүлэхийг хэлнэ. Өөрөөр хэлбэл хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн хүсэл эрмэлзлэлийг үл харгалзан албадан үр хөндүүлж, үр тогтоох чадваргүй болгох, тэдний өмнөөс нөхөн үржихүйн шийдвэр гаргах, эмчилгээ, үйлчилгээ хүртэх эрхийг хязгаарлах, гэр бүл, ажлын байрны хүчирхийлэл, дарамт, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, албадан үр хөндүүлэх, үр тогтоох чадваргүй болгох зэрэг нь хүний эрхийн зөрчил юм.

Хэдийгээр зарим онцгой тохиолдолд жирэмслэлтийг эмнэлгийн аргаар тасалж болох хуулийн заалт байдаг боловч нөхөн үржихүйн эрх нь хүний эрх юм. Иймээс ургийн амьд явах эрхийг хамгаалах, эрхэм чанарыг хүндэтгэн хөндлөнгөөс нөлөөлөх боломжгүй.

Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бэлгийн харилцаанд орох шаардлагагүй, хүүхэд төрүүлэх, гэрлэх боломжгүй, гэр бүл, хүүхдээ тэжээх чадваргүй гэх зэрэг жендэрийн хэвшмэл ойлголт нийгэмд түгээмэл байдаг. Энэ нь тэдний нөхөн үржихүйн талаар мэдээлэл авах, хүчирхийллээс ангид байх, найдвартай, аюулгүй нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах боломжийг нь хязгаарладаг байна.



МЭДЭЭЛЭЛ

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиар жирэмсний 37 долоо хоногоос өмнөх ба төрсний дараах үеийн хавсарсан эмгэгийн эмчилгээг үнэ төлбөргүй үзүүлэх ёстой.

ХБХЭХ-д Эрүүл мэндийн байгууллага хөгжлийн бэрхшээлтэй жирэмсэн эхэд онцлог хэрэгцээ, шаардлагыг хангасан хүртээмжтэй орчин, техник, тоног төхөөрөмжөөр тоноглогдсон орчинд үйлчилгээ үзүүлэх учиртай.



Би эмчийн зөвлөснөөр тогтмол үзүүлж, шинжилгээнүүдэд хамрагдаж байна. Гэхдээ заримдаа хэвлийд байгаа үрдээ санаа зовох юм. Ямар нэг асуудал байгаа эсэхийг тодруулахаар мэргэжлийн эмчтэй нэг зөвлөлдье гэж бодлоо.



Хүүхдэд минь ямар нэг төрлийн асуудал байгаа эсэхийг тодруулмаар байна.



Урьдчилсан шинжилгээнүүд хийлгэж байж мэднэ. Жишээ нь Дауны хам шинж, зүрхний дутагдал гэх зэрэг эрүүл мэндийн асуудал хүүхдэд байж болох юм. Жирэмсний үед олон шинжилгээ хийдгээс цусны болон хэт авиан шинжилгээ нь ураг хромосомын эмгэгтэй эсэхийг оношлох зорилготой. Гэхдээ эдгээр урьдчилсан шинжилгээ нь хүүхдийг Дауны хам шинжтэй байгаа эсэхийг бүрэн тогтоож чаддаггүй. Харин таны нас болон шинжилгээний хариунд үндэслэн ургийн гажиг байж болох магадлалыг гаргаж өгдөг.



Шинжилгээгээр хүүхдэд эрүүл мэндийн асуудалтай гэдэг нь яг гарч ирэх үү?

Урьдчилсан шинжилгээгээр бүгдийг илрүүлж чаддаггүй. Жишээ нь: Хэт авиан шинжилгээгээр зүрхний жижиг цоорхой, тархины зарим эмгэгүүд, хараа сонсголын өөрчлөлт, эд эрхтний үйл ажиллагааны алдагдал зэрэг

илрэхгүй. Шинжилгээний хариу 100 хувийн баталгаа болж чаддаггүй. Шинжилгээний хариу өөрчлөлттэй гарсан тохиолдолд эмч болон мэргэжлийн удам зүйчийн туслалцаатайгаар нарийн шинжилгээ өгөх эсэхээ шийдээрэй.



МЭДЭЭЛЭЛ

Урьдчилсан шинжилгээ (Screening tests) гэж юу вэ?

Хэт авиан (эхo) болон цусны шинжилгээний үзүүлэлтэд үндэслэн тухайн ураг хромосомын эмгэгтэй байх магадлалд үнэлгээ өгөх аргыг урьдчилсан шинжилгээ гэнэ. Дауны хам шинж, бусад хромосомын эмгэгийн эрсдлийг тооцох скрининг шинжилгээ хийнэ.

Нарийн шинжилгээ (Diagnostic tests) гэж юу вэ?

Нарийн шинжилгээ гэдэг нь ураг орчмын шингэн, хүүхдийн болон ихэсийн эс зэргийг шинжилж ургийн гажиг байгаа эсэхийг тодруулах оношилгоог хэлнэ.

Дауны хам шинж гэж юу вэ?

Ураг эхийн хэвлийд бүрэлдэх явцад хүний 46 хос хромосомын 21 дэх хос хромосом нь хос биш 3 болж хуваагдсанаар дауны хам шинж үүсдэг ажээ.

Хүүхэд өөрөө Дауны хам шинжтэй болох сонголтыг хийгээгүй, хийдэггүй. Дауны хам шинж бол жирийн хүүхэдтэй харьцуулахад булчингийн үзүүлэлт сул, тархины хөгжил нь харьцангуй удаан байдаг нэг төрлийн хам шинж болохоос халдварт өвчин биш. Сэтгэл мэдрэлийн ч өвчин биш. Энэ бол гутамшигтай зүйл биш. Дауны хам шинж нь хэн нэгнийг ямар шашин шүтлэг, арьс өнгө, нийгмийн гарал, угсаа, хүйс зэргээс үл хамааран үүсэх зүгээр л хромосомын эмгэг. Өөрөөр хэлбэл хүний ялгаатай байдал. Иймд дауны хам шинжтэй хүүхэдтэй болсон гээд би хүүхдээсээ ичих, түүнийг нуух, ийм хүүхэдтэй болсон нэгнээ элдвээр хэлэх хэрэггүй юм байна.

Энэ талаар Монголын Дауны холбоо (www.dsam.mn), Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо (<https://apdc.mn/>) зэрэг байгууллагад хандан илүү дэлгэрэнгүй мэдээлэл авах боломжтой.

Жирэмсний хяналтад байх үедээ “Нөхөн үржихүйн эрүүл мэнд, нөхөн үржихүйн эрх” гэсэн үгийг анзаарлаа. Энэ талаар эмчээс тодруулж асуух нь зөв гэж бодлоо.



Нөхөн үржихүй нь зөвхөн эмэгтэйчүүдэд хамаатай юу?



Бүх насны бүх хүнд хамаатай. Хүмүүс бие биеэ хайрлан дурлаж, гэр бүл болон хүүхэд төрүүлэх, үр удмаа үлдээх, эцэг эхийн жаргалыг амсах зэрэг нь бүгд бэлгийн амьдралтай холбоотой. Гэр бүл болсноор зөвхөн 2 биенийхээ өмнө төдийгүй ирээдүйн үр хүүхдийнхээ өмнө өндөр үүрэг хариуцлага хүлээдэг. Тиймээс энэ асуудал эрэгтэйчүүдэд ч хамаатай. Мөн хувь хүн нөхөн үржихүйн эрхтнүүдээ хайрлан хамгаалах нь ирээдүйд эрүүл саруул эцэг эх болж, аз жаргалтай, сэтгэл дүүрэн амьдрах нэгэн үндэс болно.



Зөвхөн залуу эмэгтэйчүүдэд холбоотой асуудал гэж бодож болохгүй юм байна. Тийм үү?



Тийм ээ. Хүний амьдралын салшгүй нэг хэсэг нь бэлгийн амьдрал. Хүний бэлгийн хөгжил нь эхийн хэвлийд байхаас эхлэн насан эцэслэх хүртэл үргэлжилж, үүнтэй холбоотойгоор хүний бие сэтгэхүйд олон өөрчлөлт гардаг. Эдгээр өөрчлөлтийг хүн мэдэж байвал өөртөө итгэлтэй амьдрах, элдэв өвчин эмгэгээс сэргийлэх чадвартай болно.



Нөхөн үржихүйн эрүүл мэнд бол өргөн хүрээтэй асуудал байх нь ээ, тийм үү?



Тийм ээ. Нөхөн үржихүйн эрүүл мэндийг зөвхөн нөхөн үржихүйн эрхтэн тогтолцоо нь өвчин эмгэггүй, эрүүл байх, эсвэл зөвхөн жирэмсэн үеийн асуудал гэж үзэж болохгүй. Зөвхөн бие махбодоос гадна сэтгэл санаа, нийгмийн талаар бүрэн төгс эрүүл хувь хүн, гэр бүлийн хос, сэтгэл ханамжтай, аюулгүй бэлгийн амьдралтай, нөхөн үржих чадвартай байж, хэзээ хэдэн хүүхэд төрүүлж өсгөхөө чөлөөтэй шийдвэрлэх гэж ойлгоно.

Нөхөн үржихүйн эрүүл мэнд гэдэгт:

- Гэр бүл төлөвлөлт,
- Эсэн мэнд амаржихуй,
- Өсвөр үеийнхний нөхөн үржихүйн эрүүл мэнд,
- БЗДХ, ХДХВ, ДОХ-оос урьдчилан сэргийлэлт,
- Үр хөндөлт,
- Үргүйдэл,
- Жендэрийн асуудал зэрэг хамаарна.

Жендэрийн асуудал гэдэг нь эрэгтэй, эмэгтэй хүмүүс гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцоно гэсэн үг. Ямар ч хүнийг гэрлэлтийн байдал, хүйсээр ялгаварлаж, хязгаарлаж болохгүй.



МЭДЭЭЛЭЛ

Хөгжлийн бэрхшээлтэй, жирэмсэн эмэгтэйн төрөлтийн хувьд бусад эхчүүдээс арай өөр байж болох юм. Нуруу, нугасны гэмтэлтэй эмэгтэйчүүд хагалгаагаар хүүхдээ төрүүлэх шаардлагатай байж болох ч зарим тохиолдолд өөрөө хүүхдээ төрүүлэх (хүний бие нь эхийн өөрийнх нь оролцоо, туслалцаагүйгээр хүүхдээ дүлж гаргаж чадах зохилдлогоотой тул) боломжтой байдаг. Манай улсын эрүүл мэндийн салбарын хөгжил, нөөц боломжоос үүдээд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн хүртэх эмнэлгийн тусламж үйлчилгээг нарийн тодорхойлоход хүндрэлтэй байна.



Их Британид хийсэн судалгаагаар хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд жирэмсний болон төрсний дараах эмчилгээ үйлчилгээг бусад эхчүүдээс илүү авч байсан байна.

Ихэнх хөгжлийн бэрхшээлтэй ээжүүд асаргаа сувилгаа сайн байсан, хангалттай харж хандаж, зай талбай хүртээмжтэй байсан гэж үзжээ. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн нөхцөл байдал харилцан адилгүй, жишээ нь бие бялдрын бэрхшээлтэй эмэгтэйчүүд

жирэмсний болон төрсний дараах үеийн үйлчилгээг илүү их авч байсан ч төрөлтийн талаар хийх сонголт нь хязгаарлагдмал; мэдрэхүйн бэрхшээлтэй хүмүүсийн байдал нь хөгжлийн бэрхшээлгүй эмэгтэйчүүдээс бага зэрэг ялгаатай байсан ч төрөхөөс өмнө эмч, сувилагчтай илүү олон уулзсан; сэтгэцийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд илүү их үйлчилгээ авч байсан ч бусадтай харилцах, дэмжлэг авах тал дээр асуудалтай тулгарсан; суралцахуйн бэрхшээлтэй болон хавсарсан хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн цөөн хувь нь жирэмсний болон төрсний дараах асаргаа, үйлчилгээ боломжийн сайн байсан гэж хариулжээ.

<https://bmcpregnancychildbirth.biomedcentral.com/articles/10.1186/1471-2393-13-174>

Хөгжлийн бэрхшээлтэй охид эмэгтэйчүүд нь янз бүрийн ялгаварлан гадуурхалт болон хүчирхийлэлд өртдөг. Тусгаарлагдмал байдал болон асрагчаасаа хараат байх явдал нь эдгээр хүмүүсийг янз бүрийн хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолд өртөмтгий болгодог бөгөөд үүнийг дагаад хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүд ХДХВ-ын халдвар, жирэмслэлт, эхийн болон нярайн эндэгдэл зэрэг эрсдэлтэй тулгардаг.

Хөгжлийн бэрхшээлтэй охид эмэгтэйчүүдэд жендэрийн эрх тэгш байдлыг хангахын тулд бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, ерөнхий эрүүл мэнд, холбогдох үйлчилгээний талаарх мэдээлэл нь хүртээмжтэй байх ёстой.

Манай улсад нөхөн үржихүйн эрхийг Эрүүл мэндийн тухай хуулийн 32.1-дэх заалтаар зөрчсөн нь эмгэнэлтэй баримт хэвээр байсаар байна.



Жирэмсний тэтгэмжийг яаж авах вэ?



Та нийтдээ 12 сараас доошгүй хөдөлмөр эрхэлж, сүүлийн 6 сар тасралтгүй нийгмийн даатгалын шимтгэл төлсөн бол, /жирэмсний чөлөө авахаас өмнө/ тэтгэмжийн даатгалын шимтгэл төлөх хугацааг хангасан бол Нийгмийн даатгалын сангаас жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрхтэй.



Ажилгүй бол авч чадахгүй гэсэн үг үү?



Хэрэв та ажилгүй ч сайн дурын даатгал төлдөг бол эмнэлгийн хуудас, нийгмийн даатгалын дэвтрээ оршин суугаа газрынхаа харьяа нийгмийн даатгалын хэлтэст хандан тэтгэмжээ бодуулна.



Жирэмсний тэтгэмжийг яаж авдаг вэ?



Эмнэлгийн хуудсаа ажиллаж буй байгуулагынхаа холбогдох \санхүүгийн ажилтанд өгч тэтгэмжээ бодуулна. Та өөрөө хүсвэл жирэмсний болон амаржсаны тэтгэмжээ ажил олгогчоороо дамжуулалгүй шууд өөрийн дансанд шилжүүлж болдог.



Нийгмийн даатгалын шимтгэлийг төлсөн эсэхээ шалгаж болох уу?



Болно. Qpay, internet bank, online bank, mobile bank зэрэг банкны цахим үйлчилгээ ашиглан шимтгэл төлөх, хянах цахимаар шалгах боломжтой болсон. Хэрэв таны шимтгэлийг төлөөгүй, дутуу төлсөн, буруу тооцсон бол Нийгмийн даатгалын байгууллагын 7777-1289, 328030 утсанд хандан шалгуулж шийдвэрлүүлэх эрхтэй.

Жирэмсний тэтгэмжийг:

- Хүүхдээ тээж байгаа,
- Хүүхдээ 196-гаас доошгүй хоног тээгээд дутуу төрүүлсэн, үр хөндүүлсэн,
- Жирэмслэлтийг эмнэлгийн аргаар тасалсан,
- 196 хоног тээгээгүй боловч амьдрах чадвартай хүүхэд төрүүлсэн бол (тэтгэмжийн даатгалын шимтгэл төлөх хугацааг хангасан даатгуулагч эх) жирэмсний болон амаржсаны тэтгэмж авна.



Амаржих хугацаа дөхөж бичиг баримт, хувийн бэлтгэлээ хангав.

Бичиг баримт:

- Иргэний цахим үнэмлэх
- Өрхийн болон эмэгтэйчүүдийн эмчийн хэвтэх бичиг
- Онош, шинжилгээ, жирэмсний хяналтын явцыг жирэмсний хяналтын эмчээр бүрэн бөглүүлсэн жирэмсний солилцох хуудас
- Хяналтын карт
- Эх хүүхдийн эрүүл мэндийн \ягаан\ дэвтэр
- Цусны бүлэг тодорхойлсон бичиг
- Зарим шинжилгээний хариу \КОВИД зэрэг\

Хувийн бэлтгэл

- Ор хөнжлийн даавуу, солих цайвар өнгийн хувцас, углааш, дотуур хувцас
- Аяга, халбага, саван, сойз, гарын алчуур, ариун цэврийн цаас
- Нярайн живх
- Том хүний живх
- Дэвсдэг живх
- Нойтон салфетка зэрэг

1.2. ХҮҮХЭД НАСАНД ТӨРӨӨС ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

Хүүхдийн эрхийн тухай конвенц, ХБХЭК-д хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бусад хүүхдийн адил эрхтэйг төдийгүй, хоол тэжээлээр дутагдахгүй байх, эрүүл мэндийн үйлчилгээ авах, сурч боловсрох, нийгэмд тэгш оролцох, хүчирхийлэл, үл хайхралтаас ангид байх зэрэг эрхтэй байдгийг онцолсон. Хүүхэд, гэр бүлийн хэрэгцээнд нийцсэн халамж, дэмжлэг үзүүлэхийн тулд эрт илрүүлэг, хүүхдийн хөгжлийг дэмжих төлөвлөгөө, үйлчилгээ, эдгээрийн үнэлгээ зэргийг багтаасан цогц аргачлал шаардлагатай. Үүнийг “Амьдралын мөчлөг” гэдэг. Бид гарын авлагаа энэхүү аргачлалд нийцүүлэн хүүхдийг төрсөн цагаас эхлүүлэн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамж, хамгааллын ямар үйлчилгээг манай улс хэрхэн зохицуулсан байгааг тайлбарласан.

ДҮРҮҮД:



Ээж



Өрхийн эмч



Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан
мэргэжилтэн



Сум, дүүргийн иргэний бүртгэлийн ажилтан



Сум, дүүргийн нийгмийн халамжийн ажилтан



Баг, хорооны нийгмийн ажилтан



ХБХЭМБНХК-ийн гишүүн



Сургуулийн захирал



Багш

Түлхүүр үг:

- Дархлаажуулалт
- Хөгжлийн хоцрогдол
- Хөгжлийн бэрхшээл
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих цогц дэмжлэг,
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс,



ТҮҮХ



Түүх үргэлжилж амьдралын баяр баясгалан болж хүүхэд минь төрлөө.



Хүүтэй болсонд баяр хүргэе. Хүүд нүдний сувилгаа хийж, булчинд К витамин тарьж, биеийн байдлыг үнэлж, хүндрэл байгаа эсэхийг хянаж байна. Хэрэв хүндрэл байвал бид илрүүлж, эмчилнэ.

Төрөлтийн талаар гэрийнхэнд чинь мэдээлсэн. Одоо танд биеийн ерөнхий үзлэг хийгээд, халдвар, цус багадалт, цус алдалт байгаа эсэхийг хянаж байна. Хүүд 24 цагийн дотор эрүүл мэндийн үзлэг хийж, Сүрьеэ (БЦЖ), В Гепатит, Халдварт саагийн 1-р тунгийн дархлаажуулалт (вакцин)-ыг хийнэ.

Хүүхэд минь эрүүл өсөхөд дархлаажуулалтыг сайжруулах нь чухал учир товлосны дагуу 2, 3, 4, 9 сартайд нь 2, 7, 15 настайд нь заавал хийлгэнэ. Хүүхдийн эрүүл мэндийн байдлаас шалтгаалан эмчийн заавраар татгалзаж болох юм байна.

Харин 12 нас хүрэхээр нь коронавирусын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх “Pfizer” компанийн вакциныг хийлгэнэ.



МЭДЭЭЛЭЛ

Дархлаажуулалт гэж юу вэ?

Халдварт өвчнөөс сэргийлэх, түүний тархалтыг хязгаарлах, өвчнийг устгах зорилгоор дархлаажуулах бэлдмэл хэрэглэх арга хэмжээний тогтолцоог халдварт өвчний эсрэг дархлаажуулалт гэнэ.

Дархлаажуулалтын үндэсний товлал гэж юу вэ?

Дархлаажуулалтын үндэсний товлал гэж улс орны хэмжээнд заавал хийх дархлаажуулалтад хамрагдах хүүхдийн нас, цаг хугацааны товыг⁷ хэлнэ. Манай улсад заавал хийгдэх дархлаажуулалтыг хүн амд үнэ төлбөргүй, дархлаажуулалтын үндэсний товлалын дагуу хийдэг юм байна.

Дархлаажуулалтын товыг хавсралт хэсгээс харна уу.

Хүүхдээ зүүгээр хатгах, хүүхэд минь тэр үед айж цочиж уйлах нь надад хэцүү санагдаж байгаа ч би өөрөө гүнзгий амьсгалж, тайван байвал хүүхэд бас тайван байна. Тарилгын үед хүүхдэд өвдөлтийг аль болох бага мэдрүүлэхийн тулд хүүхдээ аль болох хөгжилтэй байлгавал зүгээр. Хөгжилтэй байлгана гэдэг нь нярай үед нь өхөөрдөх, хөхүүлэх бол, хүүхдээ томрохоор нь тоглоом дуугаргаж, тоглуулах, ном уншиж өгч болохоор санагддаг. Тариулсан хэсэг газарт нь өвдөлт намдаах тос түрхэж болох эсэхийг эмчээс асууна гэж бодож байна. Ямар ч байсан дархлаажуулалт нь хүүхдэд аюулгүй, халдварт өвчнөөс сэргийлэх хамгийн үр дүнтэй арга гэдгийг олон судалгаа, баримт нотолдог.



Хүүдээ төрсний гэрчилгээ авах гэж явна. Ямар бичиг баримт бүрдүүлэх вэ?



Сум, дүүргийн иргэний бүртгэлийн ажилтан: Хүүхэд төрснөөс 30 хоногийн дотор эцэг эхийн иргэний үнэмлэх, гэрлэлтийн гэрчилгээ, хүүхэд төрснийг тодорхойлсон эмнэлгийн гэрчилгээ, эрүүл мэндийн ягаан дэвтрийг дүүрэг эсхүл сумын ЗДТГ-т очиж төрсний гэрчилгээг үнэ төлбөргүй авна.

Хүүхдийг эхээр нь овоглож болдог. Гэрлэлтээ батлуулаагүй ч хүүхдээ эцгээр нь овоглох бол эцэг, эх нь тус тусдаа өргөдөл бичдэг. Гол нь хүүхэд төрснийг 30 хоногийн дотор л бүртгүүлэх ёстой юм байна.

7. Монгол улсын хууль, Дархлаажуулалтын тухай, 3-р зүйлийн 3.1.11 дэх заалт

Амаржсны дараа 30 хоногийн дотор амаржсаны эмнэлгийн хуудсаа бичүүлэн байгууллагын санхүүдээ (сайн дураар даатгуулагч эх бол харьяалах аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст) өгөөд амаржсны тэтгэмжээ бодуулж авлаа. Хэрвээ хөдөлмөр эрхэлж байгаад хууль тогтоомжид заасны дагуу хүүхдээ асрах чөлөөтэй байх хугацаанд дахин хүүхэд төрүүлсэн бол жирэмсний болон амаржсаны тэтгэмж авна⁸.



Хүүхэд асарсаны мөнгийг яаж авах вэ?



Баг, хорооны Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн: Та дараах бичиг баримтыг бүрдүүлээд хүүхэд асарсаны мөнгө авна.

Эдгээр нь:

- өргөдөл;
- 1 хувь цээж зураг;
- иргэний үнэмлэх, хуулбарын хамт;
- хүүхэд эсэн мэнд бойжиж байгаа тухай өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмчийн тодорхойлолт;
- хүүхдийн төрсний гэрчилгээ, хуулбарын хамт;
- Хөдөлмөрийн тухай хуулиар хүүхэд асрах чөлөөтэй байгаа бол чөлөө олгосон тухай ажил олгогчийн тушаал, хуулбарын хамт;
- Баг, хорооны Засаг даргын тодорхойлолт



Шинээр төрсөн хүүхдэд Хүүхдийн мөнгө яаж авах вэ?



Шинэ төрсөн хүүхдийнхээ мөнгийг авахын тулд эх, эцэг нь өөрт ойрхон арилжааны банкиг сонгож болох ба тухайн банкинд очиж өргөдлийн маягтыг бөглөн, данс нээлгэж хүүхдийн мөнгөө авах боломжтой. 2022 оны 01 сарын 01-нээс “Хуримтлалтай хүүхэд” бодлого хэрэгжиж эхэлж байгаатай холбогдуулан Засгийн газраас хүүхэд бүрд олгож байгаа 100 мянган төгрөгийг 2022 оны эхний хагас жил 100

8. Монгол улсын хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, 191 дүгээр зүйл

мянган төгрөгийг бүхлээр нь хүүхдийн нэрийн данс дээр хуримтлуулах, эсвэл одоо авч байгаа дансанд шилжүүлж бэлнээр авч болно. Харин 2022 оны II хагас жилд 50 мянган төгрөгийг хуримтлуулах болон 50 мянган төгрөгийг хүлээж авах сонголттой байна.

0-3 нас хүртэлх хүүхэд асарсаны тэтгэмж, ихэр хүүхдийн тэтгэмж, тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхдийн тэтгэмж, өрх толгойлсон эцэг\эхэд олгох мөнгөн тэтгэмж, Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх шаардлагатай өрхөд олгох тэтгэмж зэрэг нийгмийн халамжийн тэтгэмж авах нөхцөл үүссэн бол Халамжийн үйлчилгээнд хамрагдах хүсэлтээ www.ehalamj.mn цахим хуудас, төрийн үйлчилгээний цахим машин "ТҮЦ" машин, гар утасны ebarimt.mn аппликэйшн, emongolia.mn зэрэг цахим системийг ашиглан гаргаж болно.

Харин хүсэлтээ цахимаар гаргах боломжгүй бол сум, хороондоо биечлэн очиж хүсэлтээ гаргадаг бөгөөд сум, хорооны нийгмийн ажилтан төрийн байгууллагын мэдээллийн санд байгаа тухайн иргэнтэй холбоотой мэдээллийг цаасаар авалгүй үйлчилгээ үзүүлнэ.

Хүү бид хоёрыг үзэхээр өрхийн эмч, сувилагч нар ирлээ.



Бид гэрийн эргэлтийн төлөвлөгөөний дагуу хүүхэд 1 сар хүртэл нь сард 4 удаа, 2 сар хүрэхээр сард 2 удаа, цаашдаа 1 нас хүртэл сард 1 удаа, 2 нас хүртэл нь улиралд 1 удаа гэрээр эргэнэ. Бас хүүхдийг нэг нас хүртэл та нар ӨЭМТ-д хүүхдийг аваачиж сар бүр үзлэг хийлгэнэ.


Очихдоо ягаан дэвтрийн хөх хуудсуудад эцэг, эх, асран хамгаалагч нар тэмдэглэл хөтөлж бөглөсөн байх ёстой шүү. Ингэснээр та бид хамтдаа хүүхдийн өвчлөл, биеийн өсөлт хөгжлийн хоцрогдол, хоол тэжээлийн цочмог дутагдлыг илрүүлэх, осол гэмтлээс сэргийлэх болно.



Эхний сараас дэвтрээ ашиглаж сурвал цаашид тогтмол тэмдэглэх дадал зуршилтай болно.

Энэ ягаан дэвтэр бол эхийн хэвлийд бүрэлдэх үеэс эхэлсэн хүүхдийн минь өсөлт хөгжил, хоол тэжээл, хүүхдийн хөгжил, эрүүл мэндийн байдлыг хянаж үнэлэх нэг ёсны түүх юм байна. Хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй бол харьяа өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгийн байнгын хяналтад орж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авна.

МЭДЭЭЛЭЛ



“Тав хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр” бол зөвхөн эмч, эмнэлгийн ажилтанд хамаатай зүйл биш. Өөрөөр хэлбэл хүүхдийн эцэг эх, гэр бүлийнхэн, эмч, цэцэрлэгийн багш, эрүүл мэндийн ажилтнууд хүүхдийн хөгжлийг ажиглаж үнэлж, ямар нэг хоцрогдол байвал түүнийг эрт илрүүлэх чухал бичиг баримт.

Энэ дэвтрийн **ХӨХ** өнгөтэй хуудсанд хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээл, асаргаа, өсөлт хөгжил, хүүхдийн хөгжил, гэр бүлийн сэтгэл зүйн байдал, гэрийн таатай орчин, аюулгүй байдлын талаар эцэг эх өөрсдөө үнэлэн, тухайн хүүхдийн насанд тохирсон гэрийн эргэлтийн өмнөх асуумжийн хуудаст тэмдэглэнэ. Өөрөөр хэлбэр дэвтрээ тогтмол хөтөлвөл хүүхдийн хөгжил ямар нэг байдлаар хоцрогдоход хугацаа алдалгүй эрүүл мэндийн байгууллагад хандаж, зохих эмчилгээ, үйлчилгээ авах учиртай. Гэр бүлд эрүүл мэнд, сэтгэл зүйн талаар асуудал гарвал хаана хандах, хаанаас тусламж авах талаар энэ дэвтэрт эцэг эх, гэр бүлийн гишүүдийн зайлшгүй мэдвэл зохих мэдээлэл зөвлөгөө байдаг.

Эцэг эх, асран халамжлагч биднээс өрх, сум, тосгоны Эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтэн хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн хөх зурвастай хуудас дахь тухайн насанд тохирсон асуумжийн дагуу нэг бүрчлэн асууж, хүүхдийн талаар бидний анзаарч мэдсэн асуудал болон хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн бусад асуудлыг илрүүлнэ. Бид эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн эцэг эхэд зориулсан хөх хуудас

дахь “Хүүхдээ өсгөж бойжуулах, зан төрхийн талаас болон аливаа зүйлийг сурахад санаа зовнисон асуудал байна уу?” гэх асуултад эцэг, эх бидний туршлага, хүүхдэд анзаарагдсан аливаа илрэлүүдийн талаарх ажигласан зүйлсийг чин сэтгэлээсээ, дэлгэрэнгүй хариулт өгөх нь чухал юм байна.



Нярай хүүхдэд заавал хийлгэх шинжилгээ байдаг уу?



Ямар нэгэн төрөлхийн өвчин байвал нярай үед нь илрүүлж, эрт эмчлэхгүй бол хойшид гарах үр дагавар нь асар хортой олон эмгэг байдаг. Тиймээс заавал хийлгэх шинжилгээнд хамрагдаж элдэв эмгэгээс урьдчилан сэргийлдэг. Нярайг төрсний дараах хоёр өдрийн дотор заавал хамруулдаг юм.

Нярайд хийх урьдчилсан шинжилгээ:

Түнхний үений хэт авиа шинжилгээ, хэт авиагаар оношилж байгаа тул хүүхдэд ямар нэгэн өвдөлт, хор байхгүй. Түнхний дутуу хөгжил, төрөлхийн мултралыг эрт илрүүлж эмчлээгүй тохиолдолд насан туршид хөгжлийн бэрхшээлтэй болох эрсдэлтэй.

Нярайн бодисын солилцооны төрөлхийн эмгэгийн тандалт. Хэдийгээр тус эмгэгийн тохиолдлын тоо харилцан адилгүй хэдий ч бодисын солилцооны төрөлхийн зарим эмгэг нь төрснөөс хойш 7-10 хоногт маш хүнд, амь тэнссэн, эргэшгүй өөрчлөлтийг үүсгэдэг. Эрт үед нь илрүүлэн эмчлээгүй тохиолдолд нярайн эндэгдэлд хүргэх эрсдэл өндөр ба хөнгөн хэлбэрийн үед хөгжлийн бэрхшээлтэй болж болзошгүй. Энэ шинжилгээг хийхийн тулд нярайн хөлийн өсгийнөөс хатгаж цус авдаг. Гэхдээ энэ нь ямар нэгэн сөрөг нөлөөгүй.

Сонсголын бэрхшээлийг эрт илрүүлэх тандалт шинжилгээ. Сонсголын бэрхшээл нь нярайд хамгийн элбэг тохиолддог эмгэгийн нэг. Тусгай сонсгол шалгадаг аппарат ашиглаж энэ тандалт шинжилгээг хийдэг. Хэрвээ эрт үед нь сонсголын бууралтыг илрүүлэхгүй бол тодорхой

зовуурь өгдөггүй учраас цэцэрлэг, сургуулийн насанд хүртэл оношлогдохгүй байх магадлалтай.

Дутуу нярайн ретинопати буюу харааны тандалтын шинжилгээ. 34 долоо хоногоос доош тээлтийн настай, 2000 граммаас бага жинтэй төрсөн бол харааны тандалтын шинжилгээ, оношилгоонд хамрагдах шаардлагатай. Нярайн тандалт шинжилгээ нь холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулагддаг боловч сайн дурын үндсэн дээр хийгддэг.

Хүү минь 2, 3, 4 сартайгийн дархлаажуулалтад хамрагдаж, өрхийн эмчийн товлосон хугацаанд үзлэг хийлгэж өсөн торнисоор 9 сар боллоо. Энэ удаагийн үзлэгийг их чухал гэж сонслоо.



9 сартай хүүхдийн үзлэг тийм чухал юм уу?



Маш чухал. Хүүхэд эхийн хэвлийд байхаас эхлэн амьдралын эхний хэдэн жил тархи нь хамгийн эрчимтэй хөгжих чухал үе учраас энэ үзлэгт заавал хамрагдана. Хүүхэд өсөж бойжихын хэрээр танин мэдэхүй, нийгмийн харилцаа, сэтгэл хөдлөл, бие махбод нь хөгжиж байдаг. Жишээ нь 9 сартай хүүхэд бусдын дэмжлэггүйгээр сууж, суганаас нь дэмжиж барихад зогсож чадаж байгаа нь хөдөлгөөн болон танин мэдэхүй нь хөгжиж байна гэсэн үг. Хүүхдэд ямар нэгэн байдлаар хөгжлийн хоцрогдол байгаа эсэхийг 9, 18, 36 сартайгийн энэ үзлэгээр тодруулах гээд байгаа юм.



Хөгжлийн хоцрогдолтойг мэдэх нь ямар ач холбогдолтой вэ?



Хөгжлийн хоцрогдлыг эрт үед илрүүлж чадвал хөгжлийн дэмжлэгийг илүү эрт үзүүлэх боломж бүрдэнэ. Энэ нь хүүхдийн цаашдын амьдралд маш том нөлөө үзүүлдэг учраас бүх хүүхдэд эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг хийдэг.

Хөдөлгөөн, эрүүл мэндийн хувьд асуудалгүй ч зарим үед хөгжлийн хоцрогдол нь зан төрхөөр илэрч болно. Мөн сонсгол, хараа, хэл ярианы бэрхшээл, хоцрогдол нь ихэвчлэн бусад хөгжлийн хоцрогдол бэрхшээлтэй хавсарсан байж ч болно. Бас ямар ч түвшинд илэрч болно. Гэр бүлийн гишүүн архи, тамхи хэрэглэдэг, эцэг, эхгүй, орлогогүй байх, хоол хүнсний хомс байдал, загнаж зодох зэрэг нь хүүхдийн хөгжилд сөргөөр нөлөөлдөг ажээ. Иймд бидний амьжиргаа, харилцаа, амьдралын хэв маяг, гэр бүлийн орчин нөхцөл хүүхдэд маань маш ихээр нөлөөлдөг юм байна.



Хүүхдэд хөгжлийн хоцрогдол эсвэл хөгжлийн бэрхшээл илэрвэл би яах вэ?



Үзлэгийн явцад илэрсэн бүх өөрчлөлтийг тэмдэглэж баримтжуулаад цуглуулсан мэдээлэлдээ дүгнэлт хийнэ. Хүүхдэд асуудал илэрвэл лавлагаа, шатлалын эрүүл мэндийн байгууллагад нарийвчилсан оношилгоо, үнэлгээ, шинжилгээ хийлгэхээр илгээнэ.



Нарийвчилсан үнэлгээ хийж онош тогтоогоод, дараа нь яах вэ?



Хүүхдэд хөгжлийн бэрхшээл, хоцрогдол эсвэл эмгэг байгаа нь илэрвэл хөгжлийн дэмжлэгийн үйлчилгээ шаардлагатай эсэхийг тогтооно.



Хөгжлийн дэмжлэг үйлчилгээ шаардлагатай бол яах вэ?



Тийм бол хүүхдийг ХБХЭМБНХК-т илгээнэ. Тэнд хүүхдийг хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтооно гэсэн үг. Хөгжлийн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөөг гэрийнхэнтэй нь хамтарч боловсруулна.



Бүх хүүхдэд дэмжлэг үзүүлэх үү?



Үгүй ээ. Хөгжлөөр үе тэнгийнхнээс бага зэрэг хоцорсон хүүхдийг хөгжлийн дэмжлэг, сэргээн засах үйлчилгээнд хамруулан тодорхой хугацаанд, эцэг эхтэй нь хамтран ажиллаж ахицыг харж болно .

Зарим хүүхэд төрөлхийн эрүүл мэндийн байдал, согогийн улмаас хөгжлийн бэрхшээлтэй байдаг бол зарим нь гэмтэл бэртэл, өвчин, хоол тэжээлийн дутагдал зэргээс хөгжлийн бэрхшээлтэй болох тохиолдол байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоонд тархины саажилт, нугасны ивэрхий, булчингийн сулрал, нуруу нугасны гэмтэл, Дауны синдром, мөн хараа, сонсгол, бие махбод, харилцааны болон оюун ухааны согог зэрэг эрүүл мэндийн нөхцөл байдалтай хүүхэд багтана.

Зарим хүүхэд нэг төрлийн хөгжлийн бэрхшээлтэй байхад зарим нь хэд хэдэн хавсарсан бэрхшээлтэй байна. Жишээлбэл, тархины саажилттай хүүхэд хөдөлгөөний, харилцааны, оюун ухааны согогтой байх магадлалтай. Хүүхдийн эрүүл мэндийн байдал, согог, орчны болон хувийн хүчин зүйлсийн нарийн ээдрээтэй харилцан үйлчлэлийн нөлөөгөөр хүүхэд бүр хөгжлийн бэрхшээлийг өөр өөрөөр мэдрэн, туулдаг билээ.



МЭДЭЭЛЭЛ

Хөгжлийн хоцрогдол гэж юу вэ?

Хөгжлийн хоцрогдол гэдэг нь бодит юмуу дүйцүүлсэн насныхаа түвшинд тохирсон хөгжлийн үзүүлэлтээс гүйцэтгэлээрээ нэлээд хоцорч яваа хүүхдэд хамаатай ойлголт юм. Хөнгөн, дунд, хүнд түвшний байж болох хөгжлийн хоцрогдлыг хэмжин тогтоохдоо баталгаатай

9. ХНХ-ын сайд, БШУ-ны сайд, ЭМ-ийн сайдын 2021 оны А/220, А/475, А/812 дугаар хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралт, *Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх заавар*

хөгжлийн үнэлгээнүүдийг ашигладаг. Хөгжлийн хоцрогдол нь түр зуурын шинжтэй байж болох ч энэ нь хөгжлийн бэрхшээлтэй болох магадлалтай хүүхдийг илрүүлэхэд ашиглах суурь үзүүлэлт болдог¹⁰.

Хөгжлийн бэрхшээл гэж юу вэ?



“Хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдэгт бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг¹¹ хэлнэ. Хөгжлийн бэрхшээлийг эрүүл мэндийн байдал, хүний амьдарч буй орчин, хувь хүний хүчин зүйлсийн харилцан үйлчлэл гэж үздэг.

Хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөө гэж юу вэ?

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хамгаалж, хүүхэд насыг баялаг бөгөөд өгөөжтэй үе болгоход туслан, нийгмийн идэвх, оролцоотой насанд хүрсэн хүн болж төлөвшихөд нь дэмжлэг үзүүлэхийн тулд юуны өмнө Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ буюу эрт үеийн хөгжүүлэх үйлчилгээ, боловсролын үйлчилгээ зэрэг тусламж дэмжлэг шаардлагатай байдаг. Яг ямар үйлчилгээ, хэрэгсэл, дэмжлэгээр хүүхдийг яаж хөгжүүлэх төлөвлөгөөг Салбар комисс боловсруулна. Энэ хөтөлбөр нь хөгжлөөр хоцрох эрсдэлтэй, эсвэл хөгжлийн хоцрогдолтой, хөгжлийн бэрхшээлтэй болох нь тогтоогдсон бага насны хүүхдийг дэмжин хөгжүүлэх зорилготой. Хүүхдийн өөрийнх нь хөгжил, дасан зохицох болон ачаалал даах чадварыг дэмжих, улам нэмэгдүүлэх, гэр бүлийн чадамжийг нэмэгдүүлэх, гэр бүл, хүүхдийн нийгмийн оролцоог дэмжих зэрэг чиглэлтэй сэргээн засах, засал, туслах тоног төхөөрөмж зэрэг төрөлжсөн үйлчилгээ, тусламж, дэмжлэг, сургалт, зөвлөгөө, цэцэрлэг, хүүхэд харах болон өдөр өнжүүлэх гэх мэт нийтийн үйлчилгээнд хамрагдахад нь туслах, холбон зуучлах зэрэг зорилтот үйл ажиллагаа болно.

10. Нээлттэй нийгэм форум, Бага насны хүүхдийн хөгжил, хөгжлийн бэрхшээл: Асуудал дэвшүүлсэн тайлан, 2015 он, 12 дахь тал

11. Монгол улсын хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт

Манай улсад хөгжлийн бэрхшээлийн хэлбэрийг бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согог нь тухайн иргэнд ямар байдлаар илэрч байгаатай холбоотойгоор харааны, ярианы, сонсголын, хөдөлгөөний, сэтгэцийн, бусад (эдгээрээс бусад болон хавсарсан) гэсэн 6 ангиллаар авч үзэж байна. Үүнд:

- Харааны бэрхшээлтэй - харааны эрхтний гэмтэл, согог, өвчин эмгэгийн улмаас хүний “харах” хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан хүнийг;
- Ярианы бэрхшээлтэй - хэл, ярианы эрхтний гэмтэл, согог, өвчин, эмгэгийн улмаас хүний “ярих” хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан хүнийг;
- Сонсголын бэрхшээлтэй - сонсголын болон хэл, ярианы эрхтний гэмтэл, согог, өвчин эмгэгийн улмаас хүний “сонсох” хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан хүнийг;
- Хөдөлгөөний бэрхшээлтэй - биеийн тодорхой хэсгийг хөдөлгөх чадваргүйн улмаас хүний амьдралын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг гүйцэтгэх чадваргүй хүнийг;
- Сэтгэцийн бэрхшээлтэй - сэтгэцийн эмгэг нь бодох сэтгэх, мэдрэх ухамсарлахуйн болон зан төлвийн өөрчлөлтөөр илрэх бөгөөд үүнийхээ улмаас хүний нийгэмд биеэ авч явах байдал нь өөрчлөгдсөн, гадаад (төрөх үеийн хүндрэлүүдийн үлдэцийн улмаас 0-3 насанд тэнэгрэх) болон дотоод (хромосомын өөрчлөлт, бодисын солилцоо дутмагшил гэх мэт) шалтгааны улмаас ойлгох, сэтгэх, мэдрэх үйл ажиллагаа нь хязгаарлагдсан хүнийг;
- Хавсарсан хэлбэрийн бэрхшээлтэй - нэг хүнд нэгээс дээш төрлийн хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, согог тохиолдсон хүн, Тухайлбал: сэтгэцийн, хөдөлгөөний, ярианы бэрхшээлтэй байж болно гэх мэт;
- Бусад хэлбэрийн бэрхшээлтэй - ямар нэгэн эмгэг болон өвчний улмаас өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх чадвараа алдсан хүнийг, тухайлбал, дотор эрхтний эмгэгүүд хавдар гэх мэт хамруулна.

Ингэж хөгжлийн бэрхшээлийн хэлбэрийг тодорхойлж байгаа нь хүний эрүүл мэнд, бие эрхтний согогт төвлөрсөн гэж шүүмжлэх болсон. Учир нь орчин үед дэлхий нийтээр хөгжлийн бэрхшээл, хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх ойлголт хүний эрхэд суурилсан хандлагаар өөрчлөгдөж байгаа билээ.

Үйл ажиллагаа, Хөгжлийн бэрхшээл, Эрүүл мэндийн олон улсын ангилал:

Хүүхэд залуучуудын хувилбар нэртэй баримт бичигт хөгжлийн бэрхшээлийг цэвэр биологийн юмуу нийгмийн талаас нь харах хандлагаас татгалзаж, харин эрүүл мэндийн байдал, орчин, хувь хүний хүчин зүйлсийн харилцан үйлчлэл гэж үзжээ. Өөрөөр хэлбэл хөгжлийн бэрхшээл зөвхөн хүүхдээс шалтгаалдаггүй. Жишээ нь:

- Биеийн махбодын үйл ажиллагаа юмуу бүтцийн согог (тархины саатайгаас болоод хүүхэд хөлөө хөдөлгөж чадахгүй байна гэж бодъё)
- Үйл хөдлөлийн хязгаарлалт (Хөлөө хөдөлгөж, алхаж чадахгүй учир туслах хэрэгсэл, тэргэнцэр ч юмуу хэрэглэнэ);
- Оролцооны хязгаарлалт (тэргэнцэртэй болсон ч өрхийн эмнэлэг налуу шатгүй байгаа нь хүүхдийг бэрхшээлтэй болгоно гэсэн үг) зэрэг багтана.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн байгууллагууд олон бий. Тэдэнтэй холбогдон дэлгэрэнгүй мэдээлэл авах боломжтой. Орон нутгийн хүмүүс, захиргаа, цахим орчинд ХБХЭЭХ, Монголын Дауны холбоо, Сонсголын бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо, Монголын Аутизмын холбоо, Сонсголгүйн боловсрол гээд олон байгууллагын талаар хайлт хийж олох боломжтой талаар бусдаас лавлаарай.



Хүүхдийнхээ хөгжлийн бэрхшээлийг тогтоолгосны дараа хаана хандах вэ?



ХБХЭМБНХК-ын гишүүн:

Хүүхдийнхээ талаар гарсан комиссын дүгнэлтийг аваад тухайн оршин суугаа аймаг, дүүргийнхээ Засаг даргын тамгын газарт бүртгүүлнэ. Тэнд “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” хуулийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бүртгэн үнэмлэх олгох үүрэгтэй. Энэ үнэмлэх нь хөгжлийн бэрхшээлтэй хүн хууль тогтоомжид заасан эрхээ

эдлэх, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах үндсэн баримт болно.

Мөн та бидний боловсруулсан хүүхдийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн дагуу хүүхдээ хөгжүүлэх талаар анхаарч, тэдэнд шаардлагатай тусламж үйлчилгээнд хамруулах хэрэгтэй.

Хүүхдийн эрүүл мэндийн цогц үзлэг оношлогоог 9 сартай, 18 сар буюу 1 нас 6 сартай, 36 сар буюу 3 настайд өрхийн эмнэлэгт хийлгэнэ. Энэ үзлэгээр хүүхдийн бие бялдар, эрүүл мэнд, танин мэдэхүй, нийгэмшихүйн харилцаанд ямар нэг асуудал байгаа гэж үзвэл Аймгийн нэгдсэн эмнэлэг, Дүүргийн эрүүл мэндийн төв, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Гэмтэл согог судлалын төв зэрэг газруудад нарийвчилсан үзлэг, оношилгоонд хүүхдээ хамруулна.

Тэдгээр эмнэлэг, төвүүдэд төрөлжсөн мэргэжлийн баг үнэлгээ оношилгоо хийж дүгнэлт гарган Салбар комисст илгээнэ. Салбар комисс нь хүүхдийг хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоож хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөө гаргана. Хэрэв хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг тогтоосны дараа хүүхдийн хөгжлийг дэмжих төлөвлөгөөг боловсруулж өгөхгүй бол түүнийг шаардаж хийлгэж авна.



ХБХЭМБНХК-ын гишүүн: Хүүхдийн хөгжлийн үнэлгээ, хөгжүүлэх үйлчилгээний төлөвлөлтөд эцэг эхчүүд та бид хамтарч ажиллана. Үнэлгээний явцад зарим хүүхдийн онош тогтоогддог бол зарим хүүхдийн онош яваандаа тодорхой болох, эсвэл бүр хэзээ ч тогтоогдохгүй байж мэднэ.



Хүүхдийнхээ хөгжлийг дэмжихийн тулд би юу хийх ёстой вэ?

Комисс: Та хүүхдийн хөгжлийн төлөвлөгөөний дагуу боловсрол, нөхөн сэргээлт, заслын үйлчилгээнд хүүхдээ хамруулж эрүүл мэндийн ажилтны зөвлөгөөг дагах ёстой.



Онош тогтоох нь эмчилгээ хийх тохиолдолд, эсвэл нийгмийн халамж, үйлчилгээ авахад чухал. Мөн хүүхдийн онош тогтоогдсноор миний эргэлзээ, тодорхойгүй байдал арилж, хүүхдийнхээ хэрэгцээнд нийцсэн оновчтой үйлчилгээг эрж хайх, хүүхдийнхээ эрхийг илүү сайн ярьж таниулахад надад хэрэгтэй. Гэхдээ хүүхдийг оношийн дагуу “бүлэглэж ангилах” буюу “нэр хаяг зүүх” сөрөг байдал гаргавал хүүхдийн гаргаж чадах амжилт, ахицын талаарх хүлээлт буурах, зарим үйлчилгээнд хамруулахаас татгалзах, хүүхдийн хувийн өвөрмөц мөн чанар, хувьсан өөрчлөгдөж байдаг ур чадварууд нь далдлагдах эрсдэл бий болдог гэдгийг анхаарах нь чухал юм байна.



МЭДЭЭЛЭЛ

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс¹² гэж юу вэ?



Мэргэжлийн оношилгоо, үнэлгээ, чадвар алдалтын талаарх дүгнэлтийг үндэслэн хүүхдийн хөгжлийн хоцрогдол, хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлж, тэдэнд шаардлагатай нийгмийн үйлчилгээнд холбон зуучлах үйл ажиллагаа явуулах зорилготойгоор аймаг, дүүргийн дэргэдэх салбар комисс ажилладаг.

Ингэхдээ хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоож хувийн хэрэг нээж хурлаараа шийдвэр гаргана. Салбар комиссын хурлаар хэлэлцэж байгаа хүүхэд, түүний гэр бүлийн эрэлт хэрэгцээг судалж, хүүхдийг бүх талаас нь цогц үнэлгээ хийгээд цаашид ямар тусламж үйлчилгээнд хамруулах тухай төлөвлөгөө боловсруулж, холбогдох байгууллагад холбон зуучилна.

Эх хүүхдийн ягаан дэвтэр бөглөхөөр хүүхдээ асуудалтай юм болов уу гэж бодогдоод заримдаа бухимдах юм. Эсвэл би сайн эцэг эх байж чадахгүй байна уу. Эдгээр асуудал нь түр зуур байж болох, эсвэл хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй байж болзошгүй юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй болсон гээд сэтгэлээр унах, гутрах, айж, ичихээсээ илүү хүүхэд өөрийгөө хөгжлийн хоцрогдолтой, хөгжлийн бэрхшээлтэй

12.

гэж боддоггүйг санаад хөгжлийн бэрхшээл гэдэг бол зүгээр л хүний ялгаатай байдлын нэг нь гэж хүлээн зөвшөөрөөд хүүхдээ хөгжүүлэхэд комисстой хамтран ажиллах нь зөв юм байна.

Энэ талаар өөрийгөө ч хөгжүүлэх, илүү мэдээлэл авахад туслах байгууллагууд байдаг юм байна. Өмнө дурдсан байгууллагаас гадна төсөл хөтөлбөрүүд нэлээд хэрэгжиж байгаагийн томоохон нь АХБ-ны санхүүжилтээр 2018 оноос Монгол улсад хэрэгжиж эхэлсэн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангаж, үйлчилгээ үзүүлэх төсөл” юм байна. Энэ төслийн хүрээнд Дорнод, Дундговь, Дархан, Архангай, Хөвсгөл, Ховд аймагт “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв”-ийг байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог хангах, тоног төхөөрөмж, туслах хэрэгсэл, эрүүл мэндийн чанар хүртээмжийг сайжруулах, хөдөлмөр эрхлэлтийн боломжийг нэмэгдүүлэх зорилготой ажиллаж байгаа юм.



МЭДЭЭЛЭЛ

Хөгжлийн дэмжлэг, оролцоо, үйлчилгээ гэж юу вэ?

Хүүхдийн амьдрах, өсөж хөгжих, цаашид суралцан, бие даан амьдрах боломжийг нэмэгдүүлэх зорилготойгоор мэргэжлийн үйлчилгээг эцэг эхийн бие даан үзүүлэх үйлчилгээтэй хослуулахыг хөгжлийн дэмжлэг, оролцоо, үйлчилгээ гэнэ. Эдгээр нь хүүхдийн хөгжлийн явцыг эрчимжүүлээд зогсохгүй хүчирхийлэл болон үл хайхралт гарахаас урьдчилан сэргийлж, сургуульд орох бэлтгэлийг хангаж өгдөг зэргээрээ эцэг эх, мэргэжилтнүүдийн ажилд хувь нэмэр болдог¹³.

Салбар комисс төлөвлөгөө боловсруулж хөгжлийн дэмжлэг оролцооны үйлчилгээнд холбон зуучилна. Хөгжлийн дэмжлэгийн үйлчилгээг:

- суурь үйлчилгээ буюу эрүүл мэндийн үйлчилгээ, сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол, нийгмийн үйлчилгээ,
- Зорилтот үйлчилгээ буюу эмчилгээ, сэргээн засалтын үйлчилгээ, хөгжлийн дэмжлэг эрт оролцооны байгууллагад төвлөрсөн болон гэр бүлд суурилсан үйлчилгээ¹⁴ гэж ангилна.

13. Нээлттэй нийгэм форум, Бага насны хүүхдийн хөгжил, хөгжлийн бэрхшээл: Асуудал дэвшүүлсэн тайлан, 2015 он, 19 дэх тал

14. ХНХ-ын сайд, БШУ-ны сайд, ЭМ-ийн сайдын хамтарсан тушаал, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх аргачлал, 2021 оны А/220, А/475, А/812 дугаар

Жишээлбэл: Бага насны хүүхдийг Портеж хөтөлбөрт хамруулахын тулд цэцэрлэг, хүүхэд хөгжлийн төв, болон мэргэшсэн байгууллагад холбон зуучилж болно. Хүний өсөлт, хөгжлийн маш чухал үе болох бага насанд нь хөгжлийн хоцрогдол, хөгжлийн бэрхшээл үүсэхээс сэргийлэх боломж нээлттэй байдаг учраас хүүхдийн хөгжлийг ажиглаж ягаан дэвтэрт тэмдэглэж, 9, 18, 36 сартайгийн цогц үзлэгт бүх хүүхдийг хамруулдаг юм байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувьд энэ бол боломжийн дээд хэмжээ, хурдаар хөгжихөд нь тус болох төрөл бүрийн үйлчилгээ, дэмжлэг авч эхлэх чухал үе бөгөөд энэ үйлчилгээнд багаасаа хамрагдвал хүүхдийн чадварууд нэмэгдэж, улмаар сургуульд элсэн ороод, амжилттай сурах боломж нээгдэнэ.

Хүү минь 1 ой хагастай буюу 18 сартайдаа хүүхдийн хөгжлийн цогц үзлэгт хамрагдахаар боллоо. 9 сартай байхад нь ХБХЭМБНХК бидэнтэй ярилцаж дүгнэлт шийдвэр гаргаж хүүхдийн хөгжлийг дэмжих төлөвлөгөөг боловсруулж ямар үр дүнд хэрхэн хүрэх аргыг тодорхойлсон. ХБХЭМБНХК хөгжлийн дэмжлэгийн үйлчилгээний явцыг тодорхой давтамжтайгаар комиссын хуралд хүүхэд, эцэг, эхийг биечлэн ирүүлж, (биечлэн ирэх боломжгүй тохиолдолд зохих бичиг баримт) хянаж байлаа. Хөл хорионы үед цахим хэлбэрээр ч хянасан. ХБХЭМБНХК-ын шийдвэрийн дагуу хүүхэд хөгжлийн дэмжлэгийн үйлчилгээнд хамрагдаагүй бол гэрийнхэн болон үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай холбогдож зөвлөгөө өгөх, албан бичиг хүргүүлэх зэрэг арга хэмжээ авдаг.



18 сартайгийн үзлэгээс хойш хүүхдийг минь үргэжлүүлэн анхаарах уу?



ХБХЭМБНХК-ын гишүүн: Анхаарна, бид хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг төрсөн үеэс сургуульд орох хүртэлх хугацаанд нь аль болох эрт илрүүлж, 16 хүртэл насанд нь хөгжлийн дэмжлэг, оролцооны үйлчилгээнд хамруулах гэсэн зорилго тавин ажилладаг.



Хүүхдэд маань хөгжлийн бэрхшээлээс үүдэн тусгайлсан сэргээн засах, засал, эмчилгээ, асаргаа үзүүлдэг ч бусад хүүхдийн адилаар л ханиад томуу тусахаас эхлэн өвчинд өртвөл яах вэ?



ХБХЭМБНХК-ын гишүүн: Бусдын л адил эмнэлгээр үйлчлүүлнэ. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн бэрхшээлийн улмаас эрүүл мэндийн хоёрдогч хүндрэл үүсэх эрсдэл өндөр байдаг. Жишээлбэл, тэргэнцэртэй хүүхдийн арьс цоорох аюул бий. Эдгээр асуудлын ихэнх нь нийтийн эрүүл мэндийн үйлчилгээний хүрээнд багтана.

ХБХЭМБНХК-ын зөвлөсөн хөгжлийн дэмжлэгийн үйлчилгээнд хамрагдаагүй бол (байнгын асаргаа шаардлагатай эсэхийг тогтооход баримталдаг эрх зүйн актад дурдсаны дагуу) асаргааны тэтгэмжийг комисс түр зогсоох арга хэмжээ авч болдог ажээ. Тиймээс хүүхдийн дэмжлэгийн үйлчилгээнд тасралтгүй хамрагдаж байх ёстой юм байна.

Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бусад хүүхдүүдийн адил нийгмийн бүхий л үйлчилгээ болох эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалал, халамжид хамрагдах эрхтэй. Эдгээр нь:

- Нөхцөлт мөнгөн тэтгэмж;
- Тусламж, хөнгөлөлт;
- Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ;
- Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ;
- Эрүүл мэндийн үйлчилгээ;
- Боловсролын дэмжих үйлчилгээ.



Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ ердийн цэцэрлэгт өгч болох уу?



Баг, хорооны нийгмийн ажилтан: Болно. Хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хоёр хүртэлх хүүхдийг ердийн цэцэрлэгийн нэг бүлэгт авдаг. Нийслэлийн цэцэрлэгүүд хүүхэд шинээр элсүүлэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дараалал харгалзахгүй элсүүлэх чиглэлийг Засгийн газар өгсөн.



Цэцэрлэг, сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ сургахад ямар нэг тусламж дэмжлэг байдаг уу?



Боловсролыг дэмжих үйлчилгээний хүрээнд сургуулийн өмнөх боловсролын болон ерөнхий боловсролын сургуульд сурч байгаа бол хичээлийн хэрэгсэл, сурах бичиг, дүрэмт хувцасны үнийн хөнгөлөлт¹⁵ үзүүлдэг. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн цэцэрлэг, сургуульд ирж, очих унааны зардлыг хөнгөлөх, эсхүл автобусаар үйлчилнэ¹⁶.



Сургууль, цэцэрлэгт ирж, очих унааны зардлын хөнгөлөлт авахад ямар материал бүрдүүлэх вэ?



Цэцэрлэг, сургуульд хүргэж өгөх болон цэцэрлэг, сургуулиас авч гэрт нь хүргэж өгөх хүний иргэний үнэмлэхийг, хуулбарын хамт, хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг тодорхойлсон эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн эмч нарын хяналтын комиссын шийдвэр, хүүхдийг сургууль, цэцэрлэгт суралцаж буйг тодорхойлсон сургууль, цэцэрлэгийн тодорхойлолт, хэрэв орон нутагт оршин суудаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд аймаг болон сумын төв, нийслэлд суралцахаар ирсэн бол тээврийн зардал төлсөн баримт эсхүл нэхэмжлэх хэрэгтэй шүү.

15. Монгол улсын хууль, *Нийгмийн халамжийн тухай*, 20-р зүйлийн 20.1.1 дэх заалт

16. Монгол улсын хууль, *Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай*, 26-р зүйл, 26.1.5 дахь заалт



МЭДЭЭЛЭЛ

Бага насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих боловсролын үйлчилгээг хаана үзүүлдэг вэ?

Хүүхдийн цэцэрлэг болон хөгжлийн төвүүдэд энэ үйлчилгээг үзүүлдэг. Тухайлбал Аутизмын холбоо, тусгай цэцэрлэгүүд Эрт боловсролын “Портеж” хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Портеж хөтөлбөр нь хүүхэд нэг бүрийн хөгжлийг үнэлэн, хөгжлийн шат дарааллын дагуу ганцаарчилсан дэмжлэг үзүүлдэг. Энэхүү хөтөлбөрийн давуу тал нь эцэг эх нь хүүхэдтэйгээ гэртээ буюу өдөр тутмын амьдралын явцад голлон ажиллаж дэс дараалалтайгаар, тасралтгүйгээр алхам алхмаар хөгжүүлдэг.

Мөн хоёр наснаас сургуульд элсэх нас хүртэл нь хүүхдээ ердийн, тусгай, сувиллын, асрамжийн цэцэрлэгийн аль нэгэнд явуулж болно.

- “Тусгай цэцэрлэг” бол хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асрах, хамгаалах, хүмүүжүүлэх, сургах цогц үйл ажиллагаагаар хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмждэг. Өөрөөр хэлбэл тусгай цэцэрлэгт зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд л хамрагддаг.
- “Сувиллын цэцэрлэг” нь биеийн өсөлт, оюун ухааны хөгжлийн хоцрогдолтой хүүхдийг асрах, хамгаалах, хүмүүжүүлэх, сургах цогц үйл ажиллагаагаар хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмждэг. Өөрөөр хэлбэл сувиллын цэцэрлэгт эмчилгээ сувилгаа шаардлагатай хүүхдэд үйлчилгээ үзүүлнэ.
- “Асрамжийн цэцэрлэг”-т эцэг, эх, асран хамгаалагчгүй болох нь албан ёсоор тогтоогдсон өнчин, хагас өнчин хүүхдийг хамруулдаг.

Хүүхдээ цэцэрлэгт явуулахдаа тусгай мэргэжлийн багш, туслах багш, эмч, сэргээн засалч, нийгмийн ажилтан ажиллахыг хуулинд заасан учраас эцэг эхчүүд бид сургууль, цэцэрлэгийн багш, ажилчид болон хүүхдийг хөгжүүлэх орчинг тодруулж асуух эрхтэй ажээ.



Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ гэж юу вэ? Түүнд хэрхэн хамрагдах вэ?



Баг, хорооны нийгмийн ажилтан: “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ” гэж иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоотойгоор өрх, иргэнд дэмжлэг туслалцаа, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг¹⁷ хэлдэг. Өөрөөр хэлбэл хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээнд нийцсэн үйлчилгээг орон нутаг, эрүүл мэнд, боловсрол, мэргэжлийн боловсрол, нийгмийн үйлчилгээний чиглэлийн төрийн ба төрийн бус байгууллагууд нэг дор цуглан, хүүхэд, тэдний гэр бүлд сонголт хийх эрх мэдлийг олгон ажлаа төлөвлөн хэрэгжүүлдэг.



Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ гэж юу вэ? Түүнд хэн хамрагдах вэ?



Аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын саналыг үндэслэн аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын шийдвэрээр байнгын асаргаатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг “Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ”-нд хамруулдаг. Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ бол асран хамгаалах, харгалзан дэмжих төрөл, садангүй бөгөөд бие даан амьдрах чадваргүй, ганц бие, байнгын эмчилгээ, асаргаа шаардагдах ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэн, түүнчлэн хүнд нөхцөлд байгаа хүүхдийг байрлуулан хоол, хувцас, эмнэлэг, соёл, ахуй, сэтгэл зүй, асаргаа сувилахуйн үйлчилгээ үзүүлэх, тэдний амьдралын хэвийн нөхцөлийг бүрдүүлэх, хууль ёсны эрх ашгийг нь хууль тогтоомжид заасны дагуу хамгаалах үйл ажиллагаа¹⁸ юм.

17. Монгол улсын хууль, *Нийгмийн халамжийн тухай*, 3-р зүйлийн 3.1.10 дахь заалт

18. Монгол улсын хууль, *Нийгмийн халамжийн тухай*, 3-р зүйлийн 3.1.19 дэх заалт

Манай улс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг нийгмийн хамгааллын болон нийгмийн халамжийн тусламж, үйлчилгээнд хамруулж хүүхдээ өсгөн бойжуулах, хөгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, чадвар олгоход төрөөс дэмжлэг үзүүлэхээр хуульчилжээ.

Үүнээс гадна хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тусгай зориулалтын хэрэгсэл, хиймэл эд эрхтэн, тэдгээрийн эд анги, тэргэнцэртэй хүнийг суулгах, буулгах зам, тавцан, өргүүртэй, эсхүл хөгжлийн бэрхшээлтэй хүн өөрөө жолоодох, удирдлага нь зөвхөн гар ажиллагаатай, дээрхийн адил бүрэн тоноглогдон үйлдвэрлэгдсэн, тусгай зориулалтын автомашиныг нэг хүнд нэг удаа гаалийн татвараас, мөн НӨАТ-аас чөлөөлнө.



Манай хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй гэж тогтоогдсон. Би хүүхдээ хараад гэртээ байдаг. Надад асаргааны тэтгэмж олдох болов уу?



“Нийгмийн халамжийн тухай” хуулинд зааснаар эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнийг асарч байгаа бол олгогдоно.



Би хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ байнга асардаг болохоор түлээ нүүрсний хөнгөлөлт олгогдох болов уу?



“Байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, бүрэн хараагүй, бүрэн хэлгүй, дүлий, одой иргэн болон байнгын асаргаа шаардлагатай хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хөгжлийн бэрхшээлтэй хүнд орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад нь жилд нэг удаа мөнгөн тусламж олгох” гэж заасны дагуу та хөнгөлөлт эдэлнэ.



Би ажилдаа буцаж ороод, эрхэлж байсан ажлаа хийж болох болов уу? Надад ямар нэгэн байдлаар хүүхдэдээ цаг гаргах боломж байдаг болов уу?



Жирэмсний болон амаржсаны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй байх үед ажилтны ажлын байрыг хэвээр хадгална гэж Хөдөлмөрийн тухай хуулинд заасан. Мөн гэрээсээ, зайнаас ажиллаж болох тухай зүйл заалт орсон. Эмчийн магадлагаагаар жирэмсэн, хөхүүл хүүхэдтэй эмэгтэй ажилтны ажлын цагийг богиносгож болох бөгөөд амрах, хооллох завсарлагаас гадна хүүхдээ хөхүүлэх, асрахад зориулан зургаан сар хүртэлх насны хүүхэдтэй буюу нэг хүртэлх насны ихэр хүүхэдтэй эхэд хоёр цагийн, зургаан сараас нэг хүртэлх насны, түүнчлэн нэг нас хүрсэн боловч эмнэлгийн дүгнэлтээр зайлшгүй асаргаа шаардагдах хүүхэдтэй эхэд нэг цагийн завсарлага нэмж олгоно. Хүүхэд хөхүүлэх, асрах нэмэлт завсарлагыг ажилласан цагт тооцно.

Би ажилдаа буцаж орох боломжтой бөгөөд хуулинд “Гурав хүртэлх насны хүүхэдтэй, эсхүл 16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилтан өөрөө зөвшөөрөөгүй бол амралтын өдөр ажиллуулах, томилолтоор ажиллуулах, илүү болон уртасгасан цагаар ажиллуулахгүй гэж заажээ.



Би хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ аваад рашаан сувилалд явах шаардлагатай. Надад энэ талаар ямар нэг дэмжлэг байна уу?



Сум, дүүргийн халамжийн ажилтан: Та хүүхдээ аваад дотоодын рашаан сувилалд дараалал харгалзахгүйгээр сувилуулах бөгөөд ирж очих унааны, ор хоногийн зардлыг эрүүл мэндийн даатгалтай иргэний энгийн өрөөний тарифаар тус тус тооцон доор дурдсан хувиар жилд нэг удаа нөхөн олгоно²¹. Ингэхдээ:

- хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд 100 хувь;
- хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асран халамжилж яваа нэг иргэнд 50 хувь;

19. Монгол улсын хууль, *Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай*, 26-р зүйлийн 26.1.1 дэх заалт

20. Монгол улсын хууль, *Хөдөлмөрийн тухай*, 140 дүгээр зүйлийн 140.1 дэх заалт

21. Монгол улсын хууль, *Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай*, 26-р зүйлийн 26.1.7 дахь заалт



Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ усан эмчилгээнд явуулахад хөнгөлөлт байдаг уу?



Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд эмнэлгийн магадлагаагаар дотоодод усан эмчилгээ хийлгэсэн бол эмчилгээний төлбөрийн 70 хувийг нөхөн олгоно²².

Өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлэх хүсэлтээ баг, хороондоо гаргавал өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлж, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэн болон тэдний асран хамгаалагчийг нийгмийн халамжийн үйлчилгээ, тусламжид хамруулах юм байна.



Манай хүүхэд 2 жилийн өмнө протез хийлгэсэн. Одоо багадаж байгаа учир дахин хийлгэх шаардлагатай болсон. Дахин хийлгэж болох уу?



Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 26.1.2-д "18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дотоодод хийлгэсэн протезын үнийг эдэлгээний хугацаа дууссан болон тухайн хүүхдийн өсөлтийн улмаас бие эрхтэнд нь таарахгүй болсон тохиолдолд тухай бүр 100 хувь нөхөн олгох" гэсэн заалт бий.



Протез, орпотед хийлгэх, тусгай хэрэгсэл авахдаа ямар материал бүрдүүлэх вэ?



Тусгай маягтын дагуу бичсэн өргөдөл бөглөөд протез, орпотед хийлгэх болон тусгай хэрэгсэл шаардлагатай тухай нарийн мэргэжлийн эмчийн тодорхойлолтыг хүүхдийн төрсний гэрчилгээг хуулбарын хамт, мөн протез, ортепед, тусгай хэрэгслийн төлбөр төлсөн баримт эсхүл нэхэмжлэлийг авч ирнэ.

22. Монгол улсын хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, 26-р зүйлийн 26.1.13 дахь заалт

Хүү минь өсөж 36 сартайгийн үзлэгт хамрагдаж салбар комиссын төлөвлөгөөний дагуу бид хүүхдийнхээ хөгжлийг дэмжихээр ажиллаж байна. 9 сартайгийн үзлэг хүүхдийн хөдөлгөөн, булчингийн хөгжлийг түлхүү анхаарч хөгжлийн төлөвлөлтийг боловсруулсан. 18 сартайгийн үзлэг харилцаа, хэл яриа, хөдөлгөөний хоцрогдол бэрхшээлийг илрүүлж сэргээн засах, хэл ярианы хөгжлийн дэмжлэг үзүүлэхэд анхаарсан. Ер нь аль ч үзлэг хүүхдийн хөдөлгөөн, хэл яриа, танин мэдэхүйн хөгжлийн үзүүлэлтүүдийг хэмжсэн бөгөөд 36 сартайгийн үзлэг ягаан дэвтрээ бөглөж хэвшсэн, комиссын төлөвлөлтийн дагуу хүүхдийн хөгжлийг дэмжиж, түүнийгээ бичиж тэмдэглэж явсан болохоор хялбар санагдлаа. Гол нь эцэг эх бид мэдээллээ үнэн зөв өгөөд, салбар комиссын хуралд оролцож хөгжлийн төлөвлөлтийг хамтран боловсруулж, үүргээ биелүүлэх ёстой.



Заримдаа хүүхдийг минь бусад хүмүүс шоолж, гадуурхах вий гэж бодох юм. Ямар үйлчилгээ авч хөгжиж байгаа нь хүүхдийн минь түүх ч гэсэн зөвхөн миний л хүүхдэд хамаатай учир олон хүнд түүнийг нь мэдүүлмээргүй байна.



ХБХЭМБНХК-ын гишүүн: Бид хүүхдийн өөртөө итгэх итгэлийг хөгжүүлж бусадтай харилцах, хамтран ажиллах, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох оролцоог дэмжихийн тулд нийтийн үйлчилгээнд аль болох тэгш хамруулахыг зорьдог. Тэгш хамруулна гэдэг нь хүний эрхэм чанар, давтагдашгүй, ялгаатай байдал, сонирхол, өвөрмөц хэрэгцээг хүндэтгэн хүүхдийн хувийн нууцыг хадгалах, хамгаалах зэргээр мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг баримтлан хүүхдийн эрхийг дээдлэн ажиллахыг хэлдэг. Тиймээс та хөгжлийн бэрхшээлгүй хүүхэдтэй цуг эмнэлэг, сургуулиар хүүхдээ үйлчлүүлэхдээ санаа зовох хэрэггүй. Бусад эцэг эх, хүүхдүүд хүний ялгаатай байдлыг мэдрүүлж байгаа нэг үйлдэл гэж хүлээж авах нь зүйтэй.



Баярлалаа. Нээрээ л би өөрөө хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ нуугаад нийгмээс тусгаарлаад байвал хүүхэд минь бусадтай харилцаж, нийгэмших асуудал нь орхигдох юм байна.



ХБХЭМБНХК-ын гишүүн: Та зөв бодож байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд эрх мэдэлгүй өсөж, нийгмээс тусгаарлагдаад байвал өөрийгөө хамгаалах, хүчирхийллийг бусдад мэдээлэх талаар ямар ч ойлголтгүй хүн болно. Улмаар хүчирхийлэл, мөлжлөг, үл хайхралтад өртөж байгаагаа ч мэдэхгүй, хүүхдийн хөгжлийн хоцрогдол бэрхшээл улам газар авч, том болсон хойно нь зан харилцааны асуудал, хүндрэл хэлбэрээр илрэх магадлалтай. Хүүхэд бага насандаа халдварт болон бусад өвчин, эмгэгээс гадна бас хүчирхийлэл, дарлал, мөлжлөг, үл хайхралтад өртөх өндөр эрсдэлд байдаг.



МЭДЭЭЛЭЛ

Эрүүл мэндийн үйлчилгээн дэх хүүхэд хамгаалал

Эмч, эрүүл мэндийн ажилтан хүүхдэд тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ гэр бүл, хувийн нууцад хамаарах мэдээллийг хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд байгууллага, албан тушаалтан, хувь хүнд мэдээлэхийг хориглодог.

Мөн ажил, үүргээ гүйцэтгэх явцдаа эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин нь алдагдсан, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчгүй, эсхүл гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хүүхдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хуульд заасны дагуу үзүүлнэ.

Хүүхдийн талаар таамагласан, мэдсэн зүйлээ хүүхдийн асуудал эрхэлсэн орон нутгийн ажилтан, албан тушаалтан, эсхүл цагдаагийн байгууллагын албан хаагчид заавал мэдээлэх ёстойг Хүүхэд хамгааллын тухай хуулинд заасан.

Эрүүл мэнд, сургуулийн өмнөх боловсрол, нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээнд бид хамрагддаг. 16 нас хүртэл нь ХБХЭМБНХ-ын комисс анхаарч ажиллах юм байна. Сургуульд элсэх, суралцах асуудалд ч анхаарна гэсэн үг. Гэхдээ 6 нас хүрэхээр нь сургуульд шууд л оруулдаг юм болов уу? Ер нь сургуульд элсэхийн өмнөх нас буюу 5 настайд нь эцэг эх бид юуг анхаарах ёстой юм бэ?



Манай хүүхэд ирэх жил сургуульд орно. Ямар сургуульд яаж бүртгүүлж, элсэж орох вэ?



ХБХЭМБНХК-ын гишүүн: Бүх хүүхдийг 5 насанд цэцэрлэгт заавал хамруулдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сургуульд элсэх тухай асуудалд засаг дарга болон Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл гол үүрэгтэй. Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлд Засаг даргын ажлын алба, Боловсролын газар, салбар комиссын боловсрол болон эрүүл мэнд хариуцсан гишүүн, сургуулийн удирдлага эцэг эх, асран хамгаалагчийн төлөөлөл ажилладаг. Хүүхдийг судлан хэлэлцэж шаардагдах эрүүл мэнд, нийгмийн халамж, сэргээн засалтын гэх мэт нэмэлт дэмжлэг, боловсролд хамрагдахад шаардлагатай тохирох хэрэглэгдэхүүнийг тодорхойлж холбогдох үйлчилгээнд хамруулах зохицуулалт хийдэг.



Энэ хүмүүс хүүхдийн минь хаана сурахыг шийднэ гэсэн үг үү?



ХБХЭМБНХК-ын гишүүн: Үгүй ээ. Та хүүхдийнхээ эрүүл мэндийн байдал, хөгжлийн онцлогийг харгалзаад хамран сургах тойргийн ЕБС-д тэгш хамран сургах, тусгай сургуульд сургах гэсэн 2 сонголтын нэгийг хийж болно.



Сургууль манай хүүхдийг авахад бэлэн юм болов уу даа?



ХБХЭМБНХК-ын гишүүн: Сургууль шинээр элсэж буй хүүхдийн бүртгэл, судалгаанд үндэслэн тохирох хэрэглэгдэхүүнийг баяжуулах, нөхөн хангалт, орчин бүрдүүлэх зэрэг ажлыг хичээлийн жил эхлэхээс өмнө зохион байгуулдаг. Ингэхийн тулд засаг дарга, Дэмжих зөвлөлийн шийдвэр хэрэгтэй байдаг учраас гол үүрэгтэй гэж хэлээд байна.



МЭДЭЭЛЭЛ

Ердийн сургуульд тэгш хамрагдах гэж юу вэ?

6 настай хүүхдийг элсүүлэн боловсролын стандартаар тогтоосон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагыг ерөнхий боловсролын сургууль гэнэ. Аймаг, нийслэлийн боловсролын газрын даргын тушаалаар хамран сургах тойргийг тогтоодог бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд энэхүү тойргийнхоо сургуульд, стандартаар тогтоосон боловсролыг бусад хүүхдийн адил эзэмшихийн тулд шаардлагатай орчин нөхцөл, тохирох хэрэглэгдэхүүнээр хангагдах эрхтэй. Үүнийг тэгш хамран сургах боловсрол гэж ойлгоно.

Тусгай сургууль гэж юу вэ?

Ерөнхий боловсролын тусгай сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сэргээн засах, чийрэгжүүлэх, бие даалгах үйлчилгээ үзүүлж, бага, суурь, бүрэн дунд боловсрол, мэргэжил эзэмшүүлэх сургалтын байгууллагыг хэлнэ. Тусгай сургуулийн хамран сургах тойрог тогтоох, элсэлт зохион байгуулах журмыг БШУЯ баталдаг.

Манай улсын хувьд ердийн сургууль, тусгай сургууль гэсэн 2 сонголт байна. Хүүхдээ ямар сургуулийг сонгон элсүүлэх вэ? Энэ тухай шийдвэр гаргахад хугацаа хэрэгтэй санагдах юм. Хуулиар бол хамран сургах тойргийн дагуу бүх сургууль бүх хүүхдийг элсүүлэх, бүх суралцагчдын эрдэм боловсрол эзэмших боломжоор ханган ажиллах үүрэгтэй учраас манай хүүхдээс татгалзах ёсгүй. Хэрэв татгалзвал, яагаад сургуульдаа элсүүлэхгүй байгаа үндэслэлээ бичгээр гаргаж өгөхийг шаардана. Энэ бичиг бол хаана, хэнд ч үзүүлж хүүхдийнхээ эрхийг хамгаалах чухал нотлох баримт болно.

Манай улсын хэмжээнд нийт 6 тусгай сургууль байдаг. Эдгээр нь:

- Хэл яриа болон сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдийн 29-р тусгай сургууль
- Харааны бэрхшээлтэй хүүхдүүдийн 116-р сургууль
- Оюуны бэрхшээлтэй хүүхдийн 55-р сургууль
- Оюуны бэрхшээлтэй хүүхдийн 25-р сургууль
- Оюуны бэрхшээлтэй хүүхдийн 63-р сургууль
- Оюуны бэрхшээлтэй хүүхдийн 70-р сургууль

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сургуульд суралцах эрхээ өөрөө эдэлнэ, сурч боловсрох эрх нь эцэг эх, асран хамгаалагчийн мэдэж шийдэх эрх биш гэж НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хорооны “Тэгш хамруулсан боловсрол эзэмших эрхийн талаарх 2016 оны 4-р Ерөнхий зөвлөмж”-д заасныг бодож тунгаах л хэрэгтэй.

Цэцэрлэгээс сургуульд ороод зарим хүүхэд хичээлд явахдаа дургүй болчихдог. Манай хүүхэд тэгэх вий гэж бодогдоод байна. Сургуульд ороход бэлтгэх бүлэг гэж хичээллүүлдэг байсан шиг тийм анги танхим, сургалт байвал зүгээр санагдах юм.



Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд цэцэрлэгээс сургуульд ороход бэлтгэл бүлэг хичээллүүлдэг үү? Хүүхдээ багштай нь эртхэн танилцуулж дасгамаар байна?



Захирал: Яг бэлтгэл бүлэг нээж хичээллүүлэхгүй ч хүүхэд сургалтын үйл ажиллагаанд дасан зохицох, сургуулийн өмнөх боловсролоос ерөнхий боловсролын сургуульд, бага боловсролоос суурь боловсрол руу шилжин суралцах үед туслалцаа үзүүлэх эрх зүйн зохицуулалт байдаг. 5 сард бүртгэл хийгээд анги хуваарилахаар та багштай нь уулзаарай. Намар хүртэл хүүхдээ сургуульд дасан зохицох ажиллагааг хамтдаа зохион байгуулж болно.



Хүүхдэд сэргээн засах, засан сайжруулах дэмжлэг үзүүлэх боломж сургуульд байдаг уу?



Шаардлагатай тохиолдолд сэтгэл зүйч, хэл засалч, тусгай хэрэгцээт боловсролын багш зэрэг мэргэжлийн байгууллага, мэргэжилтний туслалцааг цаг тухайд нь авахад бид холбон зуучилна. Эдгээр нь хүүхэдтэй ганцаарчлан хичээллэх, бие бялдар, хөдөлгөөний эвслийг сайжруулах, сэргээх дасгал хөдөлгөөн хийх, сэтгэл хөдлөлөө удирдах чадварыг хөгжүүлэх, хүүхдийн сөрөг зан үйлийг засах, хүүхдийн нүүрний хувирал, дохио зангаа, дуу хоолойг анхааралтай ажиглан харилцах чадварыг хөгжүүлэх, тайвшруулах, хүүхэд, тэдний эцэг эх, асран хамгаалагчид

сэтгэл зүй, заслын асуудлаар зөвлөгөө өгөх, арга зүйн дэмжлэг үзүүлэх, тухайн хүүхдийн анги удирдсан багштай хамтран хүүхдэд тохиолдож буй бэрхшээлийг хамтдаа шийдэж урамшуулах, идэвхжүүлэх ажлыг зохион байгуулах, хүүхдээс хүүхдэд, үе тэнгийн туслагч хөдөлгөөн өрнүүлэх зэрэг арга хэмжээ авна.



Хашааны хаалганаасаа эхлээд л ямар ч хүүхэд сургуульдаа чөлөөтэй явж, орж, гарах, бие засах гээд асуудал тулгарвал яах вэ?



Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сургуулийн өдөр тутмын амьдралд оролцоход нь учрах саад тотгорыг арилгаж, хүндрэл бэрхшээлийг багасгаж төлөвлөж, төсөвлөдөг болсон.

Зарим гэр бүл зайнаас сургах /хувилбарт, явуулын/, гэрийн сургалтаар /албан бус, насан туршдаа суралцахуй/ хүүхдээ сургах хүсэлтэй. Эцсийн шийдвэр гаргахаасаа өмнө сургуулиудаар зочилж сургуулийн/ хичээлийн байр, орчин нөхцөлтэй танилцаж, захирал, багш нартай нь ярилцаж үзье. Захирал бол багш нар, хамт олондоо нөлөө бүхий шийдвэр гаргагч учраас хөгжлийн бэрхшээлтэй, хөгжлийн ялгаатай онцлогтой хүүхдүүдийг хэрхэн тэгш хамруулан сургаж байгаа талаар ойлголтыг нь анзаарч мэдрэх нь чухал санагдаж байна.



МЭДЭЭЛЭЛ

Сэргээн засалт гэж юу вэ?



Сэргээн засах гэж хөгжлийн бэрхшээлтэй хүний алдагдсан ба хязгаарлагдсан үйлдлийг сэргээх болон хүний бие даасан байдал, бусдаас хамааралгүй байдлыг боломжит дээд хэмжээнд хүргэхийг хэлнэ. Сэргээн засах үйлчилгээ нь хөдөлгөөн засал, хөдөлмөр засал, хэл засал, сэтгэл засал зэрэг хэлбэрүүдтэй. Өөрөөр хэлбэл хүүхэд тодорхой ур чадвар, чадавх,

мэдлэг эзэмшихэд нь туслах зорилготой үйл явцыг хэлнэ. Сэргээн засах үйлчилгээнүүд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд шаардлагатай өвөрмөц, тусгай мэдлэг, арга хэрэгсэлээр хангаж өгөхөд чиглэдэг ажээ. Шаардлагатай үйлчилгээг авч чадахгүй бол хүүхэд сургуульд сурах, цаашдаа бие даан амьдрахад нь хүндрэлтэй болох учраас энэ үйлчилгээнээс хүүхдээ орхигдуулж болохгүй.



Хүүхдээ хамран сургах тойргийн сургуульд өгмөөр байгаа ч сургуульдаа өдөр бүр заавал очиж чадахгүй байна.



Танхимын сургалтад тогтмол хамрагдах боломжгүй хүүхдийг гэр бүлийн орчинд суурилан боловсролын үйлчилгээг хувилбарт сургалт, явуулын багшийн үйлчилгээгээр хүргэж болно.



Хувилбарт сургалтаар чанартай боловсрол эзэмшиж чадах уу?



Хувилбарт сургалт зохион байгуулах явуулын багшийг сургууль эсхүл насан туршийн боловсролын төвийн захирал томилж, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг баталдаг. Хувилбарт сургалтад яамнаас баталсан хөтөлбөрийг баримтлах бөгөөд хүүхдийн онцлог хэрэгцээнд үндэслэн өөртөө үйлчлэх, амьдрах чадварт суралцах энгийн чадвар дадал эзэмшүүлэх агуулгыг төлөвлөн эцэг эх та бүхний дэмжлэгтэйгээр хэрэгжүүлнэ.



Хувилбарт сургалтад гэрээр сургахаар хүүхэд маань найз нөхөд хамт олонгүй байх нь ээ дээ?



Хүүхдийг нийгмийн харилцаанд оролцуулах, нийгэмшүүлэх зорилгоор 14 хоногт 1-ээс доошгүй удаа харьяалах анги бүлгийн үйл ажиллагаанд оролцуулах, хүүхэд хөгжлийн танхимд ирүүлж үе тэнгийнхний дунд жижиг бүлгээр ажиллуулах арга хэмжээ зохион байгуулах, хүүхдийн

эрүүл мэндийн байдал, хүүхдийн сонирхол, хэрэгцээнээс хамааруулан танхимын сургалтад богиносгосон цагаар эцэг эх асран хамгаалагчийн хамт хамруулах, ахуйн чиг баримжаа олгох, амьдрах чадварт сургах, сургалтын байгууллагын үйл ажиллагаатай танилцуулах арга хэмжээ зохион байгуулдаг учир найз нөхөдтэй байж чадна.



Хөл хорио гэх зэрэг шалтгаан гарсан үед хувилбарт сургалтаас орхигдох юм биш биз?



Ямар нэг байдлаар хүүхэд сургууль дээр ирж амжихгүй нөхцөл байдал үүсвэл сургуулийн хэмжээнд зохион байгуулагдах хүүхэд хөгжлийн аливаа үйл ажиллагаанд цахимаар оролцуулна.



Хувилбарт сургалт хүүхдийг тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүнээр хангадаг уу?



Хүүхдийн хэрэгцээнд үндэслэн суралцахад шаардагдах тохирох хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж, туслах хэрэгслийн багцыг яамны баталсан журмын дагуу хувилбарт сургууль зохион байгуулах сургууль, насан туршийн боловсролын төв хийнэ.

Сургуультай олон жилийн турш хамтран ажиллах учраас хүүхдийнхээ хөгжлийн бэрхшээл, юуг сайн чаддаг, чаддаггүй гээд хөгжлийнх нь талаар шууд, илэн далангүй ярилцъя гэж бодож байна. Нууж хааж, ичиж зовоод худлаа мэдээлэл өгвөл багш, сургууль ажиллах арга эвээ олохгүй. Бас бусад эцэг эх, асран хамгаалагч нартай ярилцаж өөрийгөө болон хүүхдээ сайтар ойлгуулъя.

Бид хүүхдийнхээ тусгай хэрэгцээ, сурах онцлог нөхцөлийг харгалзсаны үндсэн дээр шийдвэр гаргаж болох ч хүүхэд өөрөө сургуулиа сонгох эрхтэйг мартаж болохгүй. Тэгш хамруулсан нийгмийг бүтээхэд миний энэ бүх үйлдэл хэцүү мэт санагдаж байгаа ч бусад хүүхэд, гэр бүлд сайн үлгэр дуурайл, хувь нэмэр болж чадна гэдэгт би итгэдэг.



Хамран сургах тойргоороо хүүхэд маань танай сургуульд элсэн суралцах юм байна. Манай хүүхэд ямар нэг ялгаварлан гадуурхалтгүйгээр сурч чадах уу? Бусад хүүхэд шоолох юм биш биз?



Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бусад хүүхдийн хамт суралцах эрхтэй. Бид хүүхдийг тань орохоос өмнө багш, бусад хүүхэд тэдний эцэг эхчүүд, багш ажилчдадаа бүх хүүхэд хамтдаа тэгш хамрагдан суралцах эрх, хамтдаа суралцахын давуу талыг ойлгуулах сургалт, сурталчилгаа, мэдээлэл өгөх арга хэмжээ зохион байгуулах болно. Ингэхээр сөрөг хандлага гаргахгүй гэж бодож байна.



Сургалт мэдээлэл хангалттай үр дүнд хүрэх болов уу?



Мөн сургуулийн дотоод журам, дүрэмдээ энэ талаар оруулна. Багшийн ёс зүйн дүрэм, мөн холбогдох баримт бичгүүдэд ийм зөрчил гаргахад хүлээлгэх хариуцлага гээд зохицуулалт байдаг. Мөн сургуулийн дүрэм, дотоод журамд тодорхой заалтууд бий.



Би хүүхдийнхээ онцлогт тохирсон арга хэлбэрээр сургаж болох уу? Ном, сурах бичиг, гарын авлага, материал, тусгай хэрэглээний сургалтын тоног төхөөрөмж зэргийг нь хэн, яаж хангадаг юм бол?



Энэ талаар сургууль дээрх дэмжлэгийн баг хуралдаж, тантай хамтран хүүхдэд зориулсан хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулна. Дэмжлэгийн баг хуралдаа таныг урих болно.

**МЭДЭЭЛЭЛ****Насан туршийн боловсролын төв гэж юу вэ?**

Насан туршийн боловсрол бол хүний амьдралын туршид шаардагдах мэдлэг, чадвар, ойлголт, зан чанарыг олгох, улмаар түүнийгээ ямар ч орчин нөхцөлд өөртөө итгэлтэй, урам зоригтой бүтээлчээр хэрэглэж чадах чадамжийг суулгах замаар хувь хүнийг нийгэмд идэвхтэй байр суурь эзлэхэд нь дэмжлэг үзүүлж, чадваржуулж байдаг тасралтгүй, дэм үйл ажиллагаа юм.

- “Насан туршийн боловсрол” гэж бүх насны иргэд боловсролын албан болон албан бус хэлбэрээр ёс суртахуун, гоо зүй, иргэн, гэр бүл, шинжлэх ухаан, амьдрах ухааны боловсролыг тасралтгүй эзэмших үйл ажиллагааг хэлдэг.
- Албан боловсрол бол нарийн зохион байгуулалттай, улсын бүртгэлтэй албан ёсны сургалтын байгууллагад улсаас баталсан сургалтын хөтөлбөрөөр шат дараалан суралцаж, олж авсан мэдлэг чадвараа улсаас хүлээн зөвшөөрсөн гэрчилгээ, дипломоор баталгаажуулах үйл ажиллагаа юм.

Албан бус боловсрол бол албан ёсны тогтолцооноос гадуур тодорхой зорилготой, тодорхой арга зүй хэрэглэн мэдлэг чадвар олгох үйл ажиллагаа юм.

Хувилбарт сургалт гэж юу вэ?

- “Хувилбарт сургалт” гэж үндсэн сургалтад хамрагдаж чадахгүй байгаа хүүхдэд боловсрол эзэмшүүлэх сургалтын үйл ажиллагааг хэлнэ.

Явуулын багшийн сургалт гэж юу вэ?

- Явуулын багшийн сургалт гэж хувилбарт сургалтын үйл ажиллагаа бөгөөд боловсролын стандартыг баримтлан гэр бүлд түшиглэж, хүүхдэд боловсрол эзэмшүүлэх сургалтын зохион байгуулалттай үйл ажиллагааг хэлнэ. Явуулын багш сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх, хүүхдийн хэл яриа, танин мэдэхүй, харилцаа, амьдрах ухаан, бие бялдрыг хөгжүүлэх ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний дагуу төлөвлөсөн сургалтын үйл ажиллагаа явуулах, нэмэлт хичээл давтлага өгөх зохион байгуулах, хүүхдийн ахиц, өөрчлөлтийг тооцон, сурах үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийн талаар тодорхойлох, дасгал даалгавар боловсруулах үүрэгтэй.

Багш нар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг минь алдаж будилах, эсвэл сайн ойлгохгүй байх үед загнаж үгүйсгэхгүй, тухайн нөхцөл байдлыг нь ойлгож, хүүхэдтэй минь үргэлж харилцаж ханддаг бол сургуулийн хүүхдүүд нэгэндээ тусалж, хоорондоо нөхөрлөж амжилттай сурч чадна. Энэ тухай хууль, тушаал журамдаа зааж өгсөн нь сайхан санагдаж байна.

Сургууль дээр дэмжлэгийн баг хүүхдийг минь амжилттай суралцахад чухал үүрэгтэй юм байна. Дэмжлэгийн багийн хуралд би өөрөө оролцож хүүхдийнхээ тухай илэн далангүй ярилцах ёстойг ойлголоо. Өөрөөр хэлбэл хүүхдийн амжилттай суралцахад сургууль, багш, эцэг эх бид хамтран ажиллах ёстой.



Дэмжлэгийн багийн хуралд оролцохдоо би юу бүрдүүлэх вэ?



Бид хүүхдийн эрүүл мэнд болон орчин нөхцөл, тохирох хэрэглэгдэхүүнийг судлана. Хэрэв та хүүхдээ ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллүүлэх бол хүсэлт гаргана.



Зөвхөн ангийн багшаас гадна сургуулийн бусад ажилчид, эцэг эх, хүүхдүүд миний хүүхдийн талаар тодорхой мэдээлэлтэй болж хүүхдийг минь ойлгож, тусалж дэмжих үү?



Манай баг хэлэлцүүлэг хийх, сургалт зохион байгуулах, мэдээллээр хангах зэрэг ажил зохион байгуулж багш нар, эцэг эхчүүд, суралцагчдын хөгжлийн бэрхшээлийн талаар мэдлэг ойлголтыг дээшлүүлнэ. Ингэснээр сурах орчин нөхцөл таатай болох болно.



Хүүхдээ яаж сургавал илүү үр дүнд хүрэх бол? Хувилбарт сургалтад хамрагдаж болох уу? Эсвэл ангидаа яваад байсан нь дээр үү?



Явуулын багшийн сургалтад хамрагдах бол ээлжит хичээлийн үргэлжлэх хугацааг хүүхдийн онцлог хэрэгцээ, эрүүл мэндийн байдлыг харгалзан сургалтыг 7 хоногт 2-3 удаа 40-80 минутаар тогтоож болно. Тэгш хамран сургалт бол энгийн хүүхдүүдтэй хамт сурч хөгжих, харилцаж нийгэмшихээс ихээхэн үршим хүртдэг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд наад захын стандарт бүхий сургалтын орчин байх ёстой учраас та хүүхдээ бусад хүүхдүүдтэй хамт сургахыг ямагт эрмэлзээрэй, бид тусалж дэмжих болно.



МЭДЭЭЛЭЛ

Боловсролын салбар буюу сургууль, хүүхэд хөгжлийн төв дээр хүүхдийг хэрхэн хамгаалах ёстой вэ?

- Сургууль бүхэн хүүхэд хамгааллын бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж, мөрдөж ажиллана.
- Сургууль, албан тушаалтан, багш, ажилтан эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар таамагласан, мэдсэн, илрүүлсэн тохиолдолд холбогдох ажилтанд заавал мэдээлнэ.
- Суралцаж байгаа хүүхэд бүрийг тухайн орчинд бие махбодын шийтгэл, сэтгэл зүйн болон үе тэнгийнхний дарамт, үл хайхрах байдал, гэмт хэрэг, зөрчил, хорт зуршилд өртөхгүй байх нөхцөлийг бүрдүүлнэ. Ингэхдээ:
 - багш, ажилтан хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга зүйг эзэмших;
 - хүүхдийг эрсдэлт нөхцөлд байгаа эсэхийг үнэлэх, судлах, зөвлөгөө өгөх;
 - хүүхдүүдийн нөхөрсөг бус харилцаа, маргаан, зөрчлийг эвлэрүүлэх, зохицуулах, гэр бүлд нь мэдэгдэх зэргээр урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах;
 - хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд хохирол учруулж болохуйц үйл ажиллагаа, арга хэмжээнд хүүхдийг оролцуулахгүй байх;
 - Хүүхдийг согтуурах, мансуурах, донтох байдалд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг авах.

Хүү минь сурагч болж амьдралын шинэ хуудсаа эхлүүлсэн. Сургууль дээрх Дэмжлэгийн багтай хамтран ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэж байна. Сургууль завсардахгүй суралцаж байгаагаа хүүгээ харахаар сургууль тохирох хэрэглэгдэхүүнээр сайн хангаж дээ гэж би боддог.

МЭДЭЭЛЭЛ

Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө гэж юу вэ?



Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө гэдэг нь хүүхэд бүрийн хөгжлийн онцлог, хэрэгцээнд нийцсэн арга зүй, дэмжлэгийг үзүүлэх хэрэглэгдэхүүн бөгөөд тухайн хүүхдэд чанартай боловсрол олгох нөхцөл боломжийг бүрдүүлэх арга зам юм.

Зарим хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн танин мэдэхүй, хөдөлгөөний хөгжил үе тэнгийн хүүхдүүдтэй нь харьцуулахад харьцангуй удаан байх тохиолдол байдаг учраас тэдэнтэй нэг ижил агуулгаар суралцах, анги, хамт олноороо хийх үйл ажиллагаанд оролцоход бэрхшээл учирдаг. Энэхүү шалтгааны улмаас ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулж, хүүхэд бүрийн хөгжлийн онцлог, хэрэгцээнд нийцсэн арга зүй, дэмжлэг үзүүлж, тухайн хүүхдийг хөгжүүлэх боломжтой.

Өөрөөр хэлбэл хичээлээ төлөвлөхдөө агуулгаас илүүтэйгээр хүүхдийн чадавх, сэдэл, тэмүүлэлд анхаарч зохих дэмжлэг бүхий хүртээмжтэй орчинг бүрдүүлснээр боловсролын орчинд тусгаарлан сургах байдлыг эцэслэхийг зорьдог.

Тохирох хэрэглэгдэхүүн гэж юу вэ?

Тохирох хэрэглэгдэхүүн гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын адил хүний үндсэн эрх, эрх чөлөөг тэгш эдлэхэд зориулсан нэн хэрэгцээтэй тоног төхөөрөмж, материал, хэрэгсэл, программ хангамж, орчин нөхцөл, үйлчилгээг хэлнэ. Өөрөөр хэлбэл хүүхэд сургуульд бусад хүүхэдтэй адил суралцахад нь үүссэн саад бэрхшээлийг нь арилгахын тулд тохирох хэрэглэгдэхүүнээр хангах ёстой. Энэ нь суралцагч бүр

24. Монгол улсын хууль, *Хүүхэд хамгааллын тухай*, 6 дугаар зүйл

25. Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын тушаал, *Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө"-ний үлгэрчилсэн загвар*, 2018 он, А\155 дугаар тушаал

26. Монгол улсын хууль, *Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай*, 4 дүгээр зүйл, 4.1.3 дахь заалт

суралцах өөрийн онцлог хэв маягтай гэдгийг хүлээн зөвшөөрч, суралцах уян хатан арга зам боловсруулах, анги танхимд оролцоог хангахуйц орчин бий болгох, суралцагчдаас өндөр хүлээлттэй байхын зэрэгцээ олон арга замаар хүлээлтээ биелүүлэх боломжийг олгох, багш нар өөрийн зааж байгаа хичээлээ эргэцүүлж, арга зүйгээ өөрчилж зааж сургаснаар боловсролын үр дүнд анхаарах зэргийг багтаадаг.

Тайвшруулах, сургалтаас үүдсэн стрессийг бууруулах зэрэг дэмжих үйлчилгээ, хөтөлбөр зэрэг цогцоороо байхад анхаарах хэрэгтэй.

Тохирох хэрэглэгдэхүүнээр хангаснаар миний хүү боловсролын тогтолцоонд таарах биш, харин ч хүүхдэд минь таарсан хариу үйлдлийг сургууль, багш үзүүлнэ гэсэн үг. Ийм байдалтайгаар хүү минь амжилттай суралцаж, анги дэвших шалгалтдаа амжилт үзүүлж байна. Учир нь ганцаарчилсан сургалтын хөтөлбөрийг хүүхдийн шаардлагад нийцэхээр боловсруулан, төлөвлөж, хэрэгжүүлсэн. Шалгалтын үеэр л гэхэд хүүгийн ахиц дэвшлийг уян хатан, олон хэлбэрээр үнэлдэг.



Хүүхдээ сургуулийн бүхий л арга хэмжээнд хамруулж баймаар байх юм?



Сургуулийн номын сан хаалга, босгоо ямар ч хүн нэвтэрч орохоор саадгүй болгосон. Манай сургууль брайл үсэгтэй болон сонсдог номтой. Хүүхэд биеэр очих боломжгүй бол гэрээр ном олгодог. Хүүхэд хүсэл сонирхлынхоо дагуу уралдаан тэмцээн, хөгжлийн хөтөлбөр, дугуйлан секц, бүлэг клубт хамрагдах, хөгжлийн төв, ордонд суралцах хэлбэрээр хөгжих эрхээ хаана ч эдэлж болно.

Та тухайн газрын хүртээмжтэй байдал, хүүхдийг хөгжүүлэх арга зүй эзэмшсэн багштай эсэхийг тодруулан асууж болно. Орчин, үйлчилгээ нь бүх хүүхдэд ээлтэй байгууллагууд нэмэгдэж байгаа гэдэгт итгэлтэй байна.



Хүүхэд зөвхөн хичээл гэхээс гадна хүний сайн сайхан зан чанарыг эзэмшихэд чиглэсэн ямар үйл ажиллагаа танай сургуульд байгаа вэ?



Урлаг, спорт гээд ер нь хичээлээс гадна хүний амьдралын сайн сайхныг мэдрэх, найз нөхөдтэй болох, сэтгэл хөдлөлөө илэрхийлж чөлөөт цагийг сайхан өнгөрүүлэхэд бид бусад хүүхэдтэй хамт бүх арга хэмжээг зохион байгуулдаг. Манай сургуульд хүүхдийн эрхийг хамгаалагч сайн дурынхан, сурагчийн зөвлөлийн гишүүд гээд оролцоо манлайлалтай сурагч олон.

Аймаг нийслэл, сум дүүргийн засаг даргын бүрэн эрхийнхээ хүрээнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсвийн төсөлд тусган биеийн тамир, спортын байгууламжийн 10-аас доошгүй хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт тохируулан тоноглоно. Эдгээрээс хүүхэд маань оюун ухаан, бие бялдар, авьяас чадвараа хөгжүүлэн ямар дугуйлан, секцэд явахаа сонгон хөнгөлөлттэйгээр үйлчлүүлж болох нь. Үүнээс гадна хүүхэд өөртөө хамааралтай аливаа асуудалд шийдвэр гаргаж, үнэлж, өөрт ногдох эд хөрөнгийг өмчлөх, өвлөх, ажил үйлчилгээ хийвэл хөлс, урамшуулал авах эрхтэй.



Боловсролыг дэмжих үйлчилгээний хүрээнд ямар дэмжлэг үзүүлэх вэ?



Сум дүүргийн халамжийн ажилтан: Нийгмийн халамжийн тухай хуулинд зааснаар ерөнхий боловсролын сургуульд сурч байгаа бол хичээлийн хэрэгсэл, сурах бичиг, дүрэмт хувцасны үнийн хөнгөлөлт эдэлнэ.



Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ зусланд амруулахад хөнгөлөлт байдаг уу?



Хөнгөлөлт байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нь хүүхдийн зусланд амарвал эрхийн бичгийн 50 хувийг жилд нэг удаа олгох²⁸ бөгөөд дараах материалыг бүрдүүлж хөнгөлөлтөд хамрагдаарай.

- Аймаг дүүргийн нэгдсэн эмнэлгийн мэргэжлийн эмч нарын хяналтын комиссын шийдвэр
- Эрхийн бичгийн үнэ төлсөн баримт эсхүл нэхэмжлэх

28. Монгол улсын хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, 26 дугаар зүйл 26.1.12-дахь заалт



Үүнээс гадна байнга живх хэрэглэдэг болохоор дэмжлэг авмаар байна?



Аарцаг эрхтний үйл ажиллагаа алдагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүнд эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр зайлшгүй шаардлагатай асаргаа сувилгаа, ариун цэвэр-эрүүл ахуйн материалын дэмжлэг үзүүлэх²⁹-ээр хуульчилсан.



Ер нь тусгай гутал нь багадаад таарахгүй болсон бол яах ёстой вэ?



Тусгай гутал хийлгэснээс хойш 3 жил болоогүй бол дахин хийлгэх боломжгүй.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дотоодод хийлгэсэн болон худалдан авсан ортопед, тэргэнцэр зэрэг тусгай хэрэгслийн үнийг гурван жил тутам нэг удаа 100 хувь нөхөн олгодог юм байна³⁰.



Хүү минь төгсөж мэргэжлээ сонгох цаг болжээ. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв (МСҮТ) эсвэл их дээд сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд элсэн суралцах боломжтой байдаг болов уу?



Захирал: МСҮТ-д суурь боловсрол эзэмшсэн буюу 9-р анги төгсөөд элсэж болно. МСҮТ нь үйлдвэрлэлийн харьяалалтай сургалтын төв, хөдөлмөр эрхлэлтийн сургалтын төв, тусгай хэрэгцээт боловсролын сургалтын байгууллага зэрэг хэв шинжтэй байж болохыг хуульчилсан. Их дээд сургуульд элсэхийн тулд ЕБС-даа цаашид үргэжлүүлэн сурч 12-р ангиа төгсөх шаардлагатай. Элсэлтийн шалгалтыг хөгжлийн бэрхшээлтэй хүнд нээлттэй, хүртээмжтэй, онцлог хэрэгцээ, шаардлагыг нь хангасан орчин, нөхцөлд авдаг.

29. Монгол улсын хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, 26дугаар зүйл 26.1.16-дахь заалт

30. Монгол улсын хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, 26 дугаар зүйл, 26.1.4 дэх заалт



МСҮТ, их дээд сургуулиуд ЕБС-д сурч байсан шиг тохирох хэрэглэгдэхүүнээр хангах болов уу? Эсвэл тусгай МСҮТ, тусгай дээд сургууль гэж байдаг юм уу?



Багш: Жил бүр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг элсүүлж хөгжлийн бэрхшээлтэй оюутанд үйлчлэх ажилтан ажиллуулах арга хэмжээг авах тухай Засгийн газрын тогтоол 2020 онд гарсан. Энэ нь МСҮТ, их дээд сургууль мөн л ЕБС шиг хөгжлийн бэрхшээлтэй суралцагчаа тохирох хэрэглэгдэхүүнээр хангана гэсэн үг.

Жишээлбэл тухайн жилийн шинээр элсэгчдийн судалгаанд үндэслэн тохирох хэрэглэгдэхүүнийг баяжуулах, нөхөн хангалт хийж лекц, семинар, дадлага ажлын үндсэн болон нэмэлт материал, сурах бичгийг хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид хүртээмжтэй, шаардлагатай тохиолдолд аудио, видео, цахим, брайл хэлбэрт шилжүүлэх зэрэг ажлыг хичээлийн жил эхлэхээс өмнө зохион байгуулна. Өөрөөр хэлбэл МСҮТ-ийн барилга, ариун цэврийн өрөө, сургалтын үйл явц хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байх, тохирох хэрэглэгдэхүүн болох шалгалтын цагийг уртасгах, дохионы орчуулга, сургалтын хэрэглэгдэхүүнийг тохируулах зэрэг арга хэмжээ авна.



Сургалтын төлбөрөөс гадна ингэж тохирох хэрэглэгдэхүүн бэлдсэн гээд баахан төлбөр нэмэгдэх нь ээ дээ?



Үгүй ээ. Тохирох хэрэглэгдэхүүн бүхий сургалтын орчин бүрдүүлэхтэй холбоотой гарах зардлыг тухайн байгууллага хариуцна. Төлбөр гэснээс нээрэн, элсэлтийн шалгалтад тэнцэж, дотоод, гадаадын их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсролын байгууллагад суралцах эрхтэй болсон хөгжлийн бэрхшээлтэй хүний бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалтын зардлыг, хөдөлмөрийн чадвараа алдсан гишүүнтэй өрхийн нэг суралцагчийн сургалтын төлбөрийг боловсролын зээлийн сан хариуцна³².

31. Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаал, *Бүх шатны сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирох хэрэглэгдэхүүн, сургалтын орчин бүрдүүлэх журам*, 2020 оны А/184 дүгээр тушаалын 3.8 дахь заалт

32. Монгол улсын хууль, *Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай*, 15дугаар зүйл, 15.6 дахь заалт

33. Монгол улсын хууль, *Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай*, 15дугаар зүйл, 15.1.8 дахь заалт



Тэгээд төгсөөд ажил олдох юм болов уу даа?



МСҮТ ч тэр, их дээд сургууль ч тэр хөгжлийн бэрхшээлтэй оюутныг ажил олгогчдод танилцуулах, ажилд зуучлах үйл ажиллагааг зохион байгуулах³³ ёстой.

Хүү минь 16 нас хүрч Монгол улсын иргэний үнэмлэхээ авлаа. Үүнтэй зэрэгцээд эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс хөгжлийн бэрхшээлийн шалтгаан, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг тогтоож эхэлсэн бөгөөд 18 нас хүрснээр шинэ түүх эхлэв.

1.3. ХҮҮХДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЭЛ

Түлхүүр үг:

- Хүүхдийн эсрэг хүчирхийлэл,
- Сургуулийн орчин дахь хүчирхийлэл, дээрэлхэлт,
- Цахим дарамт



МЭДЭЭЛЭЛ

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл гэж юу вэ?

Хүүхэд бүр аливаа хүчирхийллээс ангид аюулгүй орчинд өсч хөгжих эрхтэй³⁴.

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл гэдэг нь санаатай эсвэл санамсаргүйгээр

- хүүхдийн амь нас,
- эрүүл мэнд,
- хөгжил,
- бие махбод,
- сэтгэл санаанд хор хохирол учруулах, үл хайхрах, бэлгийн зүй бус үйлдэл болон бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамт учруулах үйлдэл юм.



Хүүхдийн эсрэг хүчирхийллийн хэлбэрүүд нь:

- үл хайхрах,
- сэтгэл санааны дарамт,
- бие махбодын хүчирхийлэл,
- бэлгийн хүчирхийлэл зэрэг болно.



Хоол хүнс, хувцас, орон байр, эмнэлгийн тусламж, боловсрол эзэмших зэрэг хүүхдийн үндсэн хэрэгцээг хангаж чадахгүй байхыг **үл хайхрах** хүчирхийлэл гэнэ.


Сэтгэл санааны дарамтад нэр хоч өгөх, элдэвлэх, гадуурхах, үг хэлээр доромжлох, дорд үзэх, хараах, бусадтай харьцуулах, байнга хяналт тавих, айлган сүрдүүлэх, гутаах зэрэг үйлдлүүд орно.

Хүүхдийг өөрийн эрхшээлдээ байлгах, давамгайл байдал тогтоох, шийтгэх зорилгоор хэн нэгэн этгээд хүч хэрэглэн хүүхдийн **бие махбодод халдахыг** бие махбодын хүчирхийлэл гэнэ.

Бэлгийн хүчирхийлэл нь хүч хэрэглэхээс гадна хууран мэхлэх, итгэл эвдэх, дарамт шахалт үзүүлэх, айлган сүрдүүлэх аргаар хүчиндэх болон хүчиндэхээр завдахыг хэлнэ.

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл

- гэр бүл,
- боловсролын орчин буюу цэцэрлэг, сургууль,
- дотуур байр,
- халамж, асрамжийн газар,
- ажлын байр,
- хорих газар,
- гудамж талбай,
- олон нийтийн газар,
- цахим орчинд түгээмэл үйлдэгддэг.



34. НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенци, 1989 он.



Хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдсэнийг мэдсэн хэн боловч төрийн албан хаагч, төрийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж байгаа ТББ-ын ажилтан гэр бүлийн хүчирхийллийн талаар заавал мэдээлэх үүрэгтэй. Иймээс хүүхдийн эсрэг хүчирхийллийн дуудлага мэдээллийг дараах утсанд заавал МЭДЭЭЛЭЭРЭЙ.

102

Цагдаагийн
мэдээлэл,
шуурхай
удирдлагын
төв

107

ГБХ-ийн дуудлага
хүлээн авах, зөвлөгөө,
мэдээлэл өгөх
Орон нутгаас шууд
холбогдох боломжтой.
102 дугаарт холбож
өгнө.

108

Хүүхдийн
тусламжийн утас
ГБХЗХГ-ын
харьяанд
ажилладаг.
Үйлчилгээнд
холбож өгнө.




Хүү минь энэ дугаарыг тогтоож ав. Ямар нэгэн байдлаар чамд тусламж хэрэгтэй үед ийшээ шууд залга. Яг л гэр бүлийнхэн, эсвэл түргэн тусламж, онцгойгийн дуудлага шиг, чамайг хамгаалж, туслах дугаар юм шүү. Чамайг үл хайхарч, дарамталж, мөлжлөг, хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэх 108 утсыг сурталчилсан дуу хүртэл байдаг.



35. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 2016 он.

Мөн тик тогд нэвтэрсэн энэ дохиог сураад ав, хүчирхийлэлд өртсөн үед ярих боломжгүй үед хэрэглэ.



Бид гэртээ болон сургууль цэцэрлэг, хүүхэд хөгжлийн төвд гээд ер нь хаана ч хүүхдийг өсгөн хүмүүжүүлэх боловсрол олгох, асран хамгаалахдаа хүчирхийллээс ангид хүмүүжлийн арга хэрэглэх ёстой. Сонин хэвлэл, радио телевиз, цахим сүлжээгээр хүүхдийн минь хувийн нууцад халдаж зураг авах, дуу, дүрс, бичлэгийг тарааж, гутаасан хэн боловч хуулийн дагуу арга хэмжээ авахуулна. Хүүхдийг эрсдэлт байдалд орохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсны дараа худалдаа үйлчилгээ, жагсаал цуглаан, замын хөдөлгөөн, уралдаан, шалгалт, тэмцээн зэрэг олон нийтийг хамарсан арга хэмжээг байгууллагууд зохионо. Хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд хохирол учруулахуйц эрсдэлтэй санагдвал тухайн арга хэмжээнд би хүүхдээ оролцуулахгүй.

МЭДЭЭЛЭЛ

Хүүхэд эрүүл өсч бойжих, аюулгүй орчинд амьдарч, аливаа хүчирхийллээс ангид байх эрхтэй. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бие махбод, бэлгийн болон сэтгэл зүйн хүчирхийлэл, мөлжлөгт бусад хүүхдээс илүү их өртөмхий байгааг судлаачид тогтоожээ.

Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхэдтэй холбоотой эрх, үүргээ урвуулан ашиглах, хүүхдийг үл хайхрах, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэр, аливаа гэмт хэрэг, зөрчлөөс хамгаалах арга хэмжээг авах үүрэгтэй. Өөрөөр хэлбэл хүүхдийг эрүүл, аюулгүй орчинд өсч хөгжүүлж, ийм нөхцлийг бүрдүүлэхийн тулд хуульд заасны дагуу эвлэлдэн нэгдэх, шаардлага, өргөдөл, гомдол, мэдээлэл гаргаж,

түүнийг шийдвэрлүүлнэ. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээсээ ичих, нуух, тоохгүй орхих, гэрээс гаргахгүй тусгаарлах, эрх мэдэл өгөхгүй байх нь ялгаварлан гадуурхалт бөгөөд ийм зохисгүй үйлдэл гаргавал хүүхдээ хүчирхийллийн хохирогч болгож эцэг эхийн **харилцаагаа зогсоох**, таслах зэргээр арга хэмжээ авахуулах хуулийн заалт байдаг. Тиймээс эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, хамаатан садан, багш сурган хүмүүжүүлэгч нь хүүхдийг өсгөн хүмүүжүүлэх, боловсрол олгох, асран хамгаалахдаа хүчирхийллээс ангид хүмүүжлийн арга хэрэглэнэ.



Мэдээлэл

Сургуулийн орчин дахь хүчирхийлэл, дээрэлхэлт, цахим дарамт гэж юу вэ?

Сургууль бүх хүүхдэд аюулгүй байх ёстой. Өөрөөр хэлбэл сургуулийн барилга байгууламж, номын сан, анги танхим, бие засах газар, гадна талбай, аваарийн гарц ямар ч хүүхэд нэвтрэхэд саадгүй, сургалтын хөтөлбөр, сурах бичиг, хичээлийн бусад хэрэглэгдэхүүнүүд хүүхэд



бүрийн онцлогт тохирсон, сургуулийн дүрэм журам, хүмүүсийн харилцаа, хандлага нь ямар ч хүнд хүндэтгэлтэй байна гэсэн үг.

Гэтэл сургуулийн болон цахим орчинд үе тэнгийнхний дарамт, дээрэлхэлт, хүчирхийлэл шоглох, заналхийлэх, цохих, тохуурхах, эд зүйлийг нь хулгайлах, нуух, хэн нэгнийхээ талаар цуу яриа тарааж тухайн хүүхдийг нийгмээс тусгаарлагдахад нөлөөлөх явдал гарсаар байна. Хүчирхийлэлд өртсөн хүүхэд сэтгэл санааны хувьд хүнд байдалд орж, хичээлдээ явах хүсэлгүй болох, хорт зуршилд автах, гадуур сэлгүүцэх, сургууль завсардахад хүрдэг. Эдгээр хүүхдийн сэтгэцийн эрүүл мэнд болон насан туршийнх нь амьдралд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.

Сургуулийн орчин дахь хүчирхийлэл, дээрэлхэлт гэдэг нь:

Бусдыг бие махбод, сэтгэл санааны хувьд зовоох зорилгоор ганцаараа болон бүлэглэн давтамжтайгаар үйлдэх дарамтыг хэлнэ. Дээрэлхэлт нь биеэр болон цахим хэлбэрээр илэрч болно.

Хэн дээрэлхэлтийн хохирогч болох эрсдэлтэй вэ?

- Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрхийн хүүхдүүд,
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд,
- Гэмт хэрэгт холбогдсон хүүхдүүд,
- Үндэсний цөөнх хүүхдүүд,
- Хүчирхийлэлд өртсөн хүүхдүүд
- Шилжин суурьшихаар ирсэн хүүхдүүд
- Охид, хөвгүүд, хэн ч байж болно



Дээрэлхэлтийн хэлбэрүүд:

Хэл яриа, үг хэллэгийн дээрэлхэлт, дарамт

- Гадаад дүр төрх, хэлсэн зүйлийг нь шоглох, дооглох, давтаж хэлэх
- Хараалын үгээр доромжлох
- Гэмтэл учруулна гэж сүрдүүлэх
- Бэлгийн дарамтын шинжтэй үг, хэллэг хэлэх

Бие махбодын дээрэлхэлт

- Цохих, өшиглөх, түлхэх, чимхэх, зодох
- Нулимах
- Түлхэх/дэгээдэж/бүдрүүлж унагаах
- Бусдын эд зүйлсийг булааж авах, эвдэх
- Бүдүүлэг дохио, зангаа харуулах

Харилцааны дээрэлхэлт

- Санаатайгаар гадуурхах
- Бусад хүүхдэд битгий найзлаарай гэж хэлэх, ятгах
- Бусдын талаар цуу яриа тараах
- Олны өмнө бусдыг ичгэвтэр байдалд оруулах

Гадуурхалт

- Найз нөхдийн харилцаанаас хасах, ганцаардуулах
- Интернэт, нийгмийн сүлжээнд сөрөг пост нэргүй тавих
- Цуу үг, хов тараах
- Хувийн мэдээллийг нь олон нийтэд дэлгэх

Дээрэлхэлтийн бусад үйлдлүүд:

Эд зүйлсийг хулгайлах, нуух, эвдэх, устгах, алгадах, өдөж уурлуулах, хочлох, элэглэн шоолох, айлгах, дарамтлах, өдөж хатгах, ганцаардуулах, мөнгө олж ирэхийг шаардах, мөнгө эд зүйл, хоол хүнсийг нь авахаар айлгах, булаах, нэр хүндийг гутаасан утга агуулгатай бичиг, зураг, дүрслэл хийх, үйл хөдлөл, дохио зангаа үзүүлэх гэх мэт

Хаана үйлдэгдэж байна вэ?

Сургуулийн тоглоомын талбай, гадна талбай, хувцас солих өрөө, 00 өрөө, коридор, шатны хонгил, сургуулийн автобус, урлаг, спортын арга хэмжээний үеэр, завсарлага, ангийн ээлж солигдох үеэр, сургуулийн орчин дахь үйлчилгээний газрууд болон ойролцоох орон сууцны байруудын орц, шатны хонгилд гэх мэт.

Дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх арга зам

Үе тэнгийн дарамт, дээрэлхэлт бол зөвхөн тухайн сургуулийн сурагчдын асуудал биш, сургуульд ажиллаж буй бүх хүнд хамаатай асуудал юм. Иймээс сургууль дээрх болон сургуулийн орчин дахь үе тэнгийн дарамт, дээрэлхэлтийн асуудалтай тэмцэхэд сургалтын менежер, нийгмийн ажилтан, анги удирдсан багш, эцэг эхийн зөвлөл/сургуулийн эцэг эх, асран хамгаалагч, багшийн холбоо, сурагчдын зөвлөл, сургуулийн аж ахуй, үйлчилгээний албаны ажилчдын хамтын оролцоо, хяналт чухал үүрэгтэй.

Хэдийгээр сургуулийн орчин дахь үе тэнгийн дээрэлхэлтийн үйлдэл нь хүчирхийллийн шинжтэй ч хуульчлаагүй, журамлаагүй байна. Уг үйлдлээс урьдчилан сэргийлэх, мөн таслан зогсоох шаардлагатай.

Хэрвээ үе тэнгийн дээрэлхэлтэд өртсөн тохиолдолд сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйчид заавал хандаарай.



Цахим дарамт

Цахим дарамт нь дээрэлхэлтийн нэг төрөлд ордог.

Цахим дарамт гэж мессеж бичих, олон нийтийн сүлжээний платформууд, аппликейшн, тоглоомын платформуудаар дамжуулан хэн нэгний хувийн болон нууц мэдээллийг ил болгох, үгээр дайрахыг хэлдэг.

Цахим платформууд гэж юуг хэлэх вэ?

- Facebook, Instagram, Snapchat, TikTok болон бусад олон нийтийн сүлжээнүүд
- Утас, таблетны мессеж болон мессеж бичих зориулалттай бусад аппууд
- Онлайн форум, чат өрөөний аппууд (Reddit)
- И-мэйл
- Тоглоомын платформууд

Цахим дарамтад өртсөн хүүхдэд илрэх сөрөг үр дагаврууд:

Бие махбодын:

- сэтгэцийн эмгэгээс үүдэлтэй нойргүйдэлт, толгой, ходоод, гэдэс өвдөх, толгой эргэх, орондоо шээх

Сэтгэл зүйн:

- стресстэх,
- сэтгэл гутрал, сэтгэл түгшилтийн эмгэг, айдастай болох
- өөрийгөө гэмтээх

Хувь хүний:

- бие даах чадваргүй болох
- түрэмгий зан авиртай болох
- хичээлийн хоцрогдол үүсэх, хичээлдээ дургүй болж, үзэн ядах
- нийгмийн харилцаанд орохоос зайлсхийж, өөрийгөө тусгаарлах

Ихэнх хүүхдүүд дарамтлуулж байгаагаа гэр бүлээсээ нуудаг. Тиймээс эцэг, эхчүүд хүүхдээ сайтар анзаарах, анхаарах хэрэгтэй. Хэрвээ таны хүүхдэд хичээлдээ явахаасаа дургүйцсэн, хоолны дуршил нь буурсан, мөн хар дарах, уйлах, тайван бус байх, урьдынхаасаа илүү их давтамжтайгаар мөнгө асуух, найзуудгүй эсвэл найзууд нь цөөрөх зэрэг шинж тэмдгүүд илэрвэл сургууль дээрээ таагүй, аюултай орчинд байгааг илэрхийлэх болно.

Хүүхдэдээ цахим дарамтын талаар тайлбарлаж өгөхөөс эхний алхамаа эхлээрэй. Таны хүүхэд хүний дохио, зангааг уншиж, тайлж чадахгүй, хийж байгаа үйлдэл нь бусдад хэрхэн нөлөөлж байгааг мэдэхгүй байх боломжтой. Мөн арьсны өнгө, шашин шүтлэг, харагдах

байдал, тусгай хэрэгцээ, хүйс болон эдийн засгийн нөхцөл байдал нь хүнийг ялгаварлах, дээрэлхэх шалтгаан биш, харин ч ялгаатай байдлыг хүндэтгэх хэрэгтэй гэдгийг ойлгуулаарай.

Хэрэв чи сургуулийн орчин дахь дээрэлхэлт, цахим дарамтад өртвөл дараах аргуудыг хэрэгжүүлээрэй.

Эдгээр аргууд нь дээрэлхүүлж байх үед тусална

- Нуруугаа эгцлэн зогсоод дээрэлхэж буй хүүхдийнхээ нүд рүү харан тухайн үйлдлийг зогсоохыг тайван өнгөөр, ойлгомжтой байдлаар хэлэх хэрэгтэй. Хэрэв чи хошин шогийн сайн мэдрэмжтэй, чамайг дээрэлхэж буй хүүхэд ойлгох чадвартай гэж бодвол түүнийг инээлгэх нь мөн асуудлыг шийдэхэд тусална.
- Хэрэв үг дуугарахад тохиромжгүй, аюултай орчин үүссэн бол холдож явахыг зөвлөж байна. Харин эргүүлэн сэргэлдэж, зодолдож, уураа гаргаж эсвэл уйлах нь байдлыг улам дордуулна.

Эдгээр аргууд нь чамайг цаашид аюулгүй байхад тусална

- Мэдрэмжээ зөвхөн өөртөө бүү хадгал, өөрийн итгэдэг том хүнтэйгээ ярилц. Ингэснээр чи зөвхөн ганцаараа биш гэдгээ ойлгох болно.
- Том хүн байхгүй орчинд дээрэлхэлт, дарамт үүсэх магадлал өндөр гэдгийг санаарай.

Эдгээр аргууд чамайг цахим дарамтаас хамгаалах болно

- Олон нийтийн сүлжээнд юу нийтлэхээ урьтаж сайн бодоорой. Өөрийгөө болон бусдыг ичгэвтэр байдалд оруулах, хувийн нууцтай холбоотой зүйл бүү нийтэл.
- Бусад хүүхдүүдээс интернэтэд ашигладаг нууц үгээ үргэлж нууцал. Чиний хамгийн сайн найз чамайг яаж ч ятгаж байсан нууц үгээ хэлэхээс найрсгаар татгалзах нь гарч болох аюулаас сэргийлнэ.
- Цахим орчинд хүүхдүүдийн дунд эрэлттэй байгаа зүйлсийн талаар эцэг, эхдээ ярьж өгөөрэй. Учир нь нас, сонирхлын ялгаанаас болж эцэг, эхчүүд тэр бүр хүүхдүүдэд тулгарч буй аюулыг олж хардаггүй.

БҮЛЭГ 2. НАСАНД ХҮРЭГЧ 18 НАСНААС ДЭЭШ



2.1. ХҮНИЙ ЭРХ, ЖЕНДЭРИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ

Хүний эрх нь хүний төрөлхийн заяагдмал хэрэгцээнээс эх үндэстэй бөгөөд хүн бүр нэр төртэй амьдрах ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй хүн бусадтай адил тэгшээр эрхээ бүрэн дүүрэн, баталгаатай эдлэх боломжтой.

Мөн Монгол Улсын Үндсэн хуулинд иргэний баталгаатай эдлэх 18 үндсэн эрх, эрх чөлөөг заасан байдаг^[1].

Эрхээ мэдэх ямар ач холбогдолтой вэ?

- Эрхээ бүрэн дүүрэн эдлэх,
- Эрхээ зөрчигдөхөөс хамгаалах,
- Төрөөс эрхээ эдлэх баталгаа бүрдүүлэхийг шаардах,
- Эрхээ зөрчигдөж буйг мэдэх,
- Зөрчигдсөн эрхээ сэргээлгэх,
- Нийгмийн амьдралд идэвхтэй оролцох,
- Төрийн бодлого шийдвэр, хууль эрх зүйн орчныг сайжруулахад оролцох боломжтой юм.

Монгол Улсын төр иргэнийхээ эрхийг хангах, хамгаалах, хүндэтгэх, биелүүлэх үүрэг хүлээдэг. Төрөөс нэн тэргүүнд хэрэгжүүлэх үүрэг бол ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийг хэрэгжүүлэх явдал юм.

Жендэр гэж улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдан тогтсон, түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт, үзэл хандлагыг хэлнэ³⁶.

36. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, 4 дүгээр зүйл

Жендэр судлалын үндсэн ойлголтуудын нэг нь жендэрийн тэгш байдал юм. Жендэрийн тэгш байдал гэдэг нь хэн байхаас үл хамаарч хүйсээр ялгаварлан гадуурхахгүй байхыг хэлдэг. Хэрвээ жендэрийн тэгш байдал хангагдвал дараах эрхүүдийг баталгаатай, бүрэн дүүрэн эдлэх боломж бүрдэнэ. Үүнд:

- Ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх
- Гэрлэх, эс гэрлэх, гэрлэлтээ цуцлуулах эсэхээ өөрөө шийдвэрлэх эрх
- Сонгох, сонгогдох, сонгуульд оролцох, мэдээлэл авах, хууль шүүхийн өмнө тэгш байх, үзэл бодлоо илэрхийлэх, итгэл үнэмшилтэй байх зэрэг иргэний болон улс төрийн эрхээ эдлэх
- Боловсрол эзэмших, эмнэлэг, эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ авах, хөдөлмөрлөх, хөдөлмөрөө адил тэгш үнэлүүлэх, нийгмийн үр шимээс тэгш хүртэх
- Улс төрийн алба хаших эрх зэрэг болно.

Монгол Улсын төр, төрийн байгууллага, албан тушаалтнууд иргэнийхээ өмнө жендэрийн эрх тэгш байдлыг хангах, бодлого шийдвэртээ тусгах, хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг.

Гэвч хөгжлийн бэрхшээлтэй хүн хуулиар олгогдсон эрхээ эдлэхэд жендэрийн ялгаварлан гадуурхалт, хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар нийгэмд уламжлагдан тогтсон хэвшмэл ойлголтуудтай нүүр тулсаар л байна.

Бид хүний эрх, жендэрийн талаар мэдлэгтэй байж, зан үйлдээ дадуулан суулгаснаар бусдын эрхийг хүндэтгэж, өөрийн эрхийг хамгаалах боломж бүрдэх юм.

Түлхүүр үг:

- | | |
|--|--|
| • Хүртээмж | • Шүүх ажиллагаанд хүртээмжтэй оролцох эрх |
| • Түгээмэл загвар | • Хувийн нууц, нэгдмэл байдал |
| • Тохирох хэрэглэгдэхүүн | • Гэрлэлт |
| • Үгхэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах эрх чөлөө | • Үр хүүхэдтэй байх эрх |
| • Нийгмийн болон улс төрийн амьдралд оролцох эрх | • Хүчирхийлэл, |
| • Хууль зүйн туслалцаа авах эрх | • Гэрч хохирогчийг хамгаалах байр |
| | • Гэр бүлийн хүчирхийлэл |

- Чөлөөтэй зорчих эрх болон нийтийн тээвэр
- Соёл, Спортын арга хэмжээнд оролцох эрх
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний соёл, урлагийн үйл ажиллагааг дэмжих
- Амьд явах, ажиллах амьдрах орчин, нөхцөлийг сайжруулах арга хэмжээ
- Гамшгийн үеийн хамгаалалт
- Эрүүл мэндийн үйлчилгээ авах эрх
- Сэргээлт, нөхөн сэргээх үйлчилгээ авах эрх
- Нийгмийн халамж, нийгмийн хамгаалал
- Хөдөлмөрлөх эрх
- Амьдарч буй орчиндоо бие даан, нэр төртэй амьдрах эрх
- Нас барах, оршуулгын тэтгэмж

Шинэ түүх эхлэв.

Өмнөх бүлэгт ээж минь миний тухай өгүүлж байсан. 18 нас хүрч буй би одоо түүхийг өөрөө бичиж байна.

ДҮРҮҮД:



Би



Номин



18 насанд хүрч амьдралын минь шинэ үе эхэлж байна. Иймээс би өөрийнхөө ямар эрхтэйг өөрөө мэдэх аянд гарч эхэлж байна. Энэ аянд гарахад миний хөтчөөр Номин ажиллаж надад зөвлөгөө өгнө.



Чамтай хамт аянд гарч байгаадаа баяртай байна.



Хүн болж төрсөн ч хөгжлийн бэрхшээлтэй гээд би бусдаас арай өөр, эсвэл бага эрхтэй байдаг уу?



Үгүй ээ. Хүн болж төрсөн хэн бүхэн адил эрх эдэлнэ. Чи төрөлхийн л эрхтэй, тэр эрхээ хаана ч эдэлнэ. Эрхийг чинь хэн ч салгаж чадахгүй. Хэн нэгэн миний эрхийг зөрчиж, эрхээ эдлэхэд чинь саад болсон ч эрхээ шаардах эрхтэй. Хүний эрх бүгд нийлж цогцоороо үйлчлэх ёстой.



Олон л хууль дүрэм гарлаа. Тэгсэн ч гэсэн би эрхээ бусдаас арай л доогуур эдлээд байх шиг санагдах юм...



Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх нь бусдынхаас огт ялгаагүй. Гэвч эрхээ бусадтай адил эдлэхэд чинь хүмүүсийн хандлага, нийгэмд тогтсон буруу ойлголт, эсвэл бүр мэддэггүйгээс болоод гаргасан шийдвэр, тэдний хэрэгжилт хангалтгүй болохоор чи эрхээ бүрэн дүүрэн эдэлж, үр ашгийг нь хүртэж чадахгүй байна.



Хүртэх гэснээс надад хүртээмжийн тухай мэдээлэл өгөөч?



Өөрт нь хүртээмжгүй бол хэн ч эрхээ эдэлж чадахгүй учир хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай ярихад хүртээмжийн асуудал маш чухал. Өөрөөр хэлбэл хүртээмж муугаас болж хэн ч гэсэн эрхээ цогцоор нь, бүрэн дүүрэн эдлэхэд саад тотгор үүсэх нь тодорхой. Тиймээс хүртээмжийн тухай яриа чиний эрхийн тухай ярих бүрт гарч ирэх байх.



Тэгэхээр хүртээмж гэдэг нь барилга байгууламж, тоног төхөөрөмж, тээвэр харилцаа гээд цаашилбал өдөр тутмын амьдралд хэрэгтэй мэдээллээ олж авахад холбоотой гэсэн үг үү?



Тийм ээ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд хөгжлийн бэрхшээлгүй иргэдийн ашигладаг барилга байгууламж, тоног төхөөрөмжийг ижил тэгш нөхцөлөөр хэрэглэх эрх болон мэдээллийг чөлөөтэй олж авах эрхийг тус тус эдэлнэ гэсэн үг. Энэ нь чиний сайн сайхан байдлыг дэмжиж байгаагийн илрэл юм.



МЭДЭЭЛЭЛ

Хүртээмж гэж юу вэ?

Хүртээмж гэдэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бие даан амьдрах, амьдралын бүхий л хүрээнд бүрэн дүүрэн оролцох боломжийг бий болгох зорилгоор хөдөө орон нутаг, хот суурин газрын хаана ч бусад хүмүүстэй адил үйлчилгээг хүртэх явдал юм. Тухайлбал: барилга байшин, зам, тээвэр болон сургууль, орон сууцны байр, эмнэлгийн газар, ажлын байр зэрэг бүх төрлийн доторх болон гаднах байгууламж, мэдээлэл, харилцаа холбооны болон бусад төрлийн үйлчилгээ зэрэг.

Хүртээмжийг хязгаарладаг саад тотгорууд

- **Биет саад:** Хүний гараар бүтээн бий болгосон сааднуудыг хэлэх бөгөөд налуу шатгүй байх, налуу шат хийсэн ч тэр нь огцом байх, гэрэлтүүлэг муу байх, гудамж зам талбай, барилга байгууламж дотор зорчих, нэвтрэхэд тэмтэрч мэдрэгдэхгүй байх, хурц өнгөөр ялгарсан тэмдэглэгээгүй байх, ойлгомжтой зураглал тэмдэглэгээ хийхгүй байх, товчлуур\кноп-ыг өндөрт хийх, хаалга нээх хаахад их хүч зарцуулахаар хийх зэрэг
- **Мэдээллийн саад:** жижиг үсэгтэй, эсвэл ялгарал муутай хэвлэмэл хуудас, веб хуудас, мэргэжлийн үг хэллэгтэй болон урт үргэлжилсэн үг, тайлбар, дохионы орчуулга эсвэл аудио тайлбаргүй ТВ-ийн нэвтрүүлэг зэрэг
- **Институцын бэрхшээл:** Хөдөлмөрийн тухай хуулиар тохируулгатай ажлын байраар хангах тухай зүйл заалт ороогүй нь хөгжлийн бэрхшээлтэй хүн үйлчилгээний туслах ажилтнаар ажиллах төдийгөөр хөгжих, хөдөлмөрлөх эрх нь хязгаарлагдана.
- **Хандлагаас үүдэлтэй бэрхшээл:** Эсгий урлал хийснээр хөгжлийн бэрхшээлтэй хүн ажилтай орлоготой болно гэж байгаа нь хөгжлийн бэрхшээлийн талаар дутуу ойлголттой учраас өөр ажлын байр бэлтгэх талаар бодохгүй. Эсвэл налуу шат огцом байлаа гээд тэргэнцэртэй гарахад юу нь хэцүү гэх хайхрамжгүй хандлага гээд цаашилбал тоног төхөөрөмж, програм хангамжийг хүртээмжгүй хийх зэрэг бэрхшээлүүд

Хаана ч гэсэн хүртээмжийг цогцоор нь шийдэхгүй бол зарим саад тотгороос болж би хэд хэдэн эрхээ эдэлж чадахгүй юм байна. Жишээлбэл сонгууль хэзээ, хаана болох талаарх мэдээлэл надад хүртээмжгүй бол би сонгуульд оролцож чадахгүй. Түүнчлэн тухайн сонгуульд хэн, хаанаас нэр дэвшиж ямар мөрийн хөтөлбөрийг санал болгож байгааг, яг надад тохирсон хэлбэрээр авч байж би саналаа өгөх ёстой. Саналаа өгч сонгох эрхээ эдэлж чадаагүйгээс болж намайг төлөөлөх эрх мэдэлтэн миний эрх ашигт нийцсэн шийдвэрийг гаргаж чадахгүй.

Ямар эрхийн талаар ярьж байгаагаас үл хамааран хүртээмжийн асуудлыг заавал багтааж харах ёстой бөгөөд ингэхдээ зарим нэг хүнд бус харин бүхий л төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байх талаас нь харах ёстой³⁷.

МЭДЭЭЛЭЛ

Хүртээмжийг нэмэгдүүлэх арга зам

- “Түгээмэл загвар” гэж нэмэлт тохиргоо, тусгай загвар шаардахгүйгээр бүх хүн ашиглахад тохиромжтой, энгийн бүтээгдэхүүн, программ, орчин болон үйлчилгээний хэв маягийг³⁸ хэлдэг. Хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд бүхий л төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, орчин нөхцөлийг бүх хүн хэрэглэж болохыг анхаарна гэсэн үг. Түгээмэл загвар нь хувь хүний хэрэгцээг бүрэн хангаж хүртээмжийг нэмэгдүүлэх арга зам болж чаддаггүй.
- Тохирох хэрэглэгдэхүүн: Энэ нь хувь хүнд зориулсан бөгөөд тодорхой хүмүүсийн тодорхой хэрэгцээг хангах зорилгоор тусгай зохицуулалт, тохируулга, нийцүүлэг, өөрчлөлт хийхийг хэлнэ.

Хүртээмжийг нэмэгдүүлэхэд төр засаг, байгууллагууд дараах ерөнхий үүргийг хүлээнэ.

- Хүндэтгэх үүрэг: хүртээмжийг хязгаарлах, саад тотгор учруулах аливаа үйлдэл, соёл, практикийг ашиглахаас татгалзах
- Хамгаалах үүрэг: хүртээмжийг хязгаарласан саад тотгорыг арилгах, байгааг нь арилгахад анхаарах
- Хэрэгжүүлэх үүрэг: хүртээмжийг хангахад чиглэсэн бүх арга хэмжээ авах

37. Ненси Флауэрс, Жоел Бальф нар, Хүний эрхийн төлөө, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах үйл ажиллагаа, нөлөөлөл гарын авлага, Нээлттэй нийгэм форум,он 43 дахь тал

38. Монгол улсын хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, 4-р зүйлийн 4.1.4 дэх заалт

Түгээмэл загвар нь бүх хэрэглэгчдэд ижилхэн ханддаг бол тохирох хэрэглэгдэхүүн нь тодорхой хэрэглэгчдэд тусгайлан зориулсан арга хэмжээ юм байна.

Жишээлбэл: Аймаг нийслэлийн Засаг дарга нийтийн тээврийн хэрэгслээр зорчиж байгаа хараагүй хүнд зориулж буудлыг зарлах, сонсголын бэрхшээлтэй иргэнд зориулж буудал бүрд нэр, хаяг, чиглэлийг бичмэл болон зурган хэлбэрээр байрлуулах, өөрчлөх шийдвэр³⁹-ийг гаргах нь хүртээмжийг нэмэгдүүлэх зорилготой. Мөн нийтийн тээврийн хэрэгслийн 10-аас доошгүй хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тээвэрлэхэд зориулагдсан байхаар хуульчилсан бөгөөд үүнийг хэрэгжүүлэхгүй бол Засгийн газраас тогтоосон хэмжээ, журмын дагуу жил бүр төлбөр төлнө гэсэн нь хүртээмжийг хангахад чиглэсэн арга хэмжээний нэг ажээ.



Мэдээллүүд надад хүртээмжгүй байна. Мөн би өөрийн үзэл бодол, итгэл үнэмшлээ илэрхийлэх арга алга. Надад үг хэлэх эрх чөлөө байдаг уу?



Хүн бүрд үзэл бодолтой байх эрх чөлөө, үг хэлэх эрх чөлөө бий. Өөрийн үзэл бодолтой байх эрх чөлөө гэдгийг чи юу дуртайгаа бодох, яаж бодохоо хэнээр ч заалгахгүй гэж ойлго. Харин үг хэлэх эрх чөлөө нь үзэл бодолтой байх эрхээс хариуцлага дагуулж, зарим үед төрийн хязгаарлалтад өртдөгөөрөө ялгаатай.



Тодорхой тайлбарлаад өгөөч?



Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь мэдээлэл солилцох, санал бодлоо илэрхийлэх, итгэл үнэмшлээ боловсруулахад шаардлагатай мэдээллийг олж авахад хэрэгтэй. Мэдээлэл солилцох, үзэл бодлоо илэрхийлэхдээ үзэн ядалтыг дэвэргэх, бусдын нэр хүндэд халдах, худал мэдээлэл тараах зэргээр бусдад гэм хор учруулж болзошгүй. Иймээс нийгмийн аюулгүй байдал, дэг журам, эрүүл мэнд, ёс суртахуун мөн бусдын суурь эрх, эрх чөлөөг хамгаалах үүднээс эдгээр эрхэд төрөөс хязгаарлалт тавихыг зөвшөөрдөг⁴⁰.

39. Монгол улсын хууль, Автотээврийн тухай, 7 дугаар зүйл, 7.4 дэх заалт

40. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, 19 дүгээр зүйл

Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг эдлэхэд хүртээмжийн асуудал мөн л гарч ирэх нь. Тухайлбал мэдээллийн сувгууд хүртээмжтэй хэлбэрээр мэдээлэл өгөхөөс гадна миний хэрэгцээг ойлгож, санал бодлыг минь сонсвол улам л сайжрах байх даа. Сонсголгүй хүмүүст дохионы хэл ашиглахыг зөвшөөрөх нь үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хүндэтгэж байгаа хэрэг. Гэтэл хурал цуглааны талаар бидэнд мэдээлэл хүртээмжгүй байдгаас гадна тэдгээр хурал арга хэмжээнд оролцоход бидний үгийг сонсож, үзэл бодлыг хүндэтгэдэг билүү? Байгууллагууд веб хуудсаа хүртээмжтэй болгон засварлаж үг үсгийг нь томруулдаг, сонсдог, ойлгомжтой энгийн үг хэллэгтэй, зургаар илэрхийлдэг болговол бидний энэ эрхийг хамгаалж байна гэж үзнэ.

Мөн ном, сурах бичиг, сонин сэтгүүл, төрийн байгууллагын шийдвэр, албан бичиг, барааны шошго зэрэг бүх төрлийн хэвлэмэл материалыг бар кодтой хэвлэх ёстой. Цахим хуудас болон телевизийн мэдээ, мэдээлэл, танин мэдэхүйн болон өргөн нэвтрүүлгийг дохионы хэлний хэлмэрчтэй, текст унших боломжтой байдлаар нэвтрүүлэх хэрэгтэй.

Төрийн болон нийтийн үйлчилгээний байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүнд дохионы хэлний хэлмэрч, орчуулагч, бичигч, уншигч, хөтчийн үйлчилгээ үзүүлэх, сонсголын бэрхшээлтэй хүн цагдаа, эрүүл мэндийн байгууллага, онцгой байдлын албаны тусгай дугаарт текст мессеж, дохионы хэлний хэлмэрчийн зайн дүрс, ярианы тусламжтайгаар хандаж, үйлчилгээ авах боломжтой байх ёстой. Ер нь тэгээд хөгжлийн бэрхшээлтэй хүн энэ эрхээ эдлэх боломжийг хангахад чиглэсэн бүх арга хэмжээг авч байж үг хэлэх үзэл бодлоо илэрхийлэх эрх хангагдана.



МЭДЭЭЛЭЛ

Үзэл бодол, итгэл үнэмшлээ илэрхийлэх, мэдээлэл хүртэх эрх чөлөө гэж юу вэ?

Хөгжлийн бэрхшээлтэй хүн өөрийн сонгосон харилцааны бүх төрлийн хэрэглэгдэхүүнээр дамжуулан үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах, төрөл бүрийн мэдээлэл, үзэл бодлыг хайх, олж авах, түгээх эрхийг үзэл бодол, итгэл үнэмшлээ илэрхийлэх, мэдээлэл хүртэх эрх чөлөө гэнэ.

Өөрөөр хэлбэл нийтэд зориулсан мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй иргэн ашиглах боломжийг бүрдүүлж хөгжлийн бэрхшээлийн янз бүрийн хэлбэрт нийцсэн арга замаар, тухайн цаг хугацаанд нь ямар нэг нэмэлт өртөг, зардалгүйгээр түгээхийг хэлнэ. Албан харилцаанд ч дохионы хэл, брайл үсэг зэргээр хөгжлийн бэрхшээлтэй хүний сонгосон мэдээлэл хүртэх харилцааны бусад арга зам, хэлбэр, хэв маягийг ашиглана гэсэн үг.

Харилцаа гэж хэл яриа, эх бичвэрийн үзүүлэн, брайл болон тактил хэл, том үсгээр хэвлэгдсэн ойлгоход хялбар мультимедиа хэлбэртэй тоног төхөөрөмж, тухайлбал хэвлэмэл төхөөрөмж, аудио тоног төхөөрөмж, ердийн хэл яриа, ярьдаг ном, түүнчлэн эдгээрийг томруулсан болон орлуулсан аргачлал, харилцаа, түүний дотор мэдээлэл харилцааны технологид нэвтрэх бусад хэрэгслийг хэлнэ⁴¹.

- “Хэл яриа” гэдэгт ярианы болон бичгийн хэл, түүнчлэн ярианы бус бусад төрлийн хэлийг хэлэх бөгөөд монгол дохионы хэл бол сонсголгүй хүний эх хэл мөн бөгөөд сонсголгүй хүн дохионы хэлээрээ нийгмийн бүхий л харилцаанд оролцох эрхтэй⁴².
- Брайл бичиг нь хараагүй хүний хэрэглэдэг үндсэн бичиг бөгөөд брайл бичгийг ашиглан мэдээлэл авах, боловсрол эзэмшин нийгмийн харилцаанд оролцох нөхцөл боломжоор хангана⁴³.



Би ер нь сонгуульд оролцох эрхтэй юу?



Эрхтэй. Иргэн бүр аливаа алагчлалгүйгээр болон үндэслэлгүй хязгаарлалтгүйгээр сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналаа нууцаар хурааж, сонгогчид жинхэнэ хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг баталгаажуулсан, тогтмол явагддаг сонгуульд сонгох буюу сонгогдох эрхтэй⁴⁴. Тиймээс ч УИХ, ерөнхийлөгч болон орон нутгийн гээд бүх шатны сонгуульд саналаа бие даан, чөлөөтэй, нууцаар өгнө. Харин энэ нөхцөлийг сонгуулийн ерөнхий хороо бүрдүүлсэн байх ёстой.

41. НҮБын конвенц, *Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай*, 2 дугаар зүйл

42. Монгол улсын хууль, *Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай*, 12 дугаар зүйл, 12.1 дэх заалт

43. Монгол улсын хууль, *Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай*, 13 дугаар зүйл, 13.1 дэх заалт

44.



Сонгуулийн сурталчилгаан дээр бас л хүртээмжийн асуудал байдаг. Үүнийг хэрхэн шийдвэрлэдэг юм бэ?



Бүх шатны сонгуульд оролцогч нам, эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгаа нь хөгжлийн бэрхшээлтэй сонгогчид хүртээмжтэй байх ёстой. Манай улсад харааны бэрхшээлтэй хүмүүст зориулсан сонгуулийн хуудас хэвлүүлэх зэрэг тодорхой ажил хийж, зарим нэр дэвшигч мөрийн хөтөлбөрөө брайл үсгээр хэвлэсэн тохиолдол байдаг. Сонгуулийн ерөнхий хорооны мэдэгдлийг дохионы хэлний орчуулагчтай хүргэж байгаа ч нэр дэвшигч нар энэ тал дээр төдийлөн санаачилгатай ханддаггүй гэж хэлж болно.



Сонгуулийн хэсгийн хороо хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй сонгууль зохион байгуулах талаар мэдлэг мэдээлэлтэй байдаг юм уу?



Сонгуулийн ерөнхий хорооноос хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудтай хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог, хэрэгцээ зэргийг танилцуулсан сургалт зохион байгуулдаг туршлага бий. Сонгогчийн нэрсийн жагсаалтад бүртгүүлэх, санал өгөхдөө туслалцаа авах хүнээ дагуулж ирэх боломжтой байх ёстой.



Хөгжлийн бэрхшээлтэй хүн сонгуульд нэр дэвшиж болох уу?



Болно шүү дээ. Төрийн аливаа албанд томилогдон ажиллахад нь улс төрийн нам, эвсэл, төрийн байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг дэмжих үүрэгтэй бөгөөд энэ талаар дэмжлэг үзүүлэх талаар улс төрийн нам, эвслүүд бодлого, мөрийн хөтөлбөртөө тусгана.

Сэтгэцийн өвчний улмаас өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй, өөрийгөө зөв удирдаж чадахгүй болсон этгээдийг шүүх иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцож⁴⁵ улмаар сонгогчийн нэрийн жагсаалтаас хасдаг.

45. Монгол улсын хууль, Иргэний хууль, 18 дугаар зүйл, 18.2 дахь заалт

Харин байнгын асаргаатай, өөрийн биеэр сонгуулийн хэсгийн хороонд очих боломжгүй хүмүүст сонгуулийн өмнөх өдөр гэрээр нь очиж саналыг нь битүүмжилсэн хайрцагт авдаг. Сонгуульд оролцох гэдгийг сонгогчоор бүртгүүлэх, сонгуулийн талаар мэдээлэл хүлээж авах, сонгуулийн өдөр саналаа өгөх эрхтэй гэж ойлгоно. Энэ бүх үйл ажиллагааг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй болгох үүргийг төр засаг хүлээнэ.

Өөрөөр хэлбэл санал хураах байр нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бүртгүүлэх, саналаа өгөхөд нь саадгүй, дохионы хэлний орчуулагч, тод томруун зурган илэрхийлэлтэй, сонгуулийн хэсгийн хорооныхон хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээний талаар мэддэг байх ёстой.



Надад шүүх прокурор, хууль хяналтын байгууллагаар явж хохирсноо мэдэгдэх шаардлага гарчихлаа. Тэдэнд би өөрийгөө ойлгуулах, намайг тэд ойлгож харилцахын тулд ямар нэгэн арга хэмжээ байдаг юм болов уу?



Шүүх, прокурор, хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байх ёстой. Чамд шаардлагатай хууль зүйн зөвлөгөө, текст уншигч, бичигч, дохионы хэлний хэлмэрч, орчуулагч зэрэг тусламж үйлчилгээгээр үнэ төлбөргүй хангах бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох болон холбогдох мэдээллийг хөгжлийн бэрхшээлийн онцлогт чинь нийцүүлэн ойлгомжтой, хүртээмжтэй хэлбэрээр тайлбарлаж өгөх ёстой.



Ямар нэгэн байдлаар цагдаагийн байгууллагад саатуулагдвал ёс бус харьцаанд өртөх, миний нэр төрийг гутаах явдал гарчихвий гэж айж байна. Байцаалт өгөх үед би айж сандарч, надад байцаалт хүнд тусч, асуултыг сонсохгүй, ойлгохгүй эсвэл би хариу хэлж чадахгүй бол намайг эсэргүүцэл үзүүлж байна гэж ойлгох вий дээ?



Гэм буруутай нь хуулиар нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэгтэн гэж үзэхгүй. Хэрэв яллагдагчаар татагдвал бүрэн тэгш эрхийн үндсэн дээр дараах наад захын баталгаагаар хангагдах эрхтэй.

- Оногдуулж байгаа ялын шинж чанар үндэслэлийг чиний ойлгох хэлээр даруй, нарийвчлан мэдэгдэх,
- Шүүн таслах ажиллагаа явуулж байгаа хэлийг ойлгохгүй буюу тухайн хэлээр ярьдаггүй тохиолдолд орчуулагчийн туслалцааг үнэ төлбөргүй авах,
- Өөрийн эсрэг мэдүүлэг өгөх, бурууг хүлээх тулган шаардалтанд өртөхгүй байх

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч нь монгол хэл мэдэхгүй, эсхүл хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлийн улмаас өөрийн хууль ёсны ашиг сонирхлоо илэрхийлэх чадвар хязгаарлагдмал бол өөрийн эх хэл, эсхүл сайн мэдэх хэл, бичиг, дохио зангаа, тусгай тэмдэгт ашиглан орчуулагч, хэлмэрчийн тусламж авах эрхээр хангагдана. Орчуулагч, хэлмэрч нууцыг задруулахгүй байх үүрэгтэй.

Ямар ч байсан би эрүү шүүлт болон хэрцгий, хүнлэг бус, доромжилсон харьцаа, шийтгэлээс ангид байх эрхтэй бөгөөд надад үзүүлэх хамгаалалтын үйлчилгээ нь нас, хүйс, жендэрийн мэдрэмжтэй туслалцаа, дэмжлэгийг зохистой аргаар, хөгжлийн бэрхшээлийн хэлбэрт зохицсон байхад төр анхаарч цагдаа болон хорих ангийн албан хаагчдыг зохих сургалтад хамруулсан байх ёстой юм байна. Энэ тухай мэдээллийг миний ялгаатай байдалд тохируулж хүртээмжтэй хэлбэрээр хүргэнэ гэсэн үг.



МЭДЭЭЛЭЛ

Шүүхийн шатанд жендэрийн мэдрэмжтэй туслалцаа, дэмжлэг гэж юу вэ?

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн нийгмийн хүйс, ялгаатай байдлаасаа үл хамаарч өөрсдийн онцлог ялгаа, хэрэгцээндээ нийцсэн тусламж, үйлчилгээ авах эрхтэй. Тэдний ялгаатай байдал нь ялгаварлан гадуурхах шалтгаан болохгүй. Тухайлбал шүүх хуралдааны үеэр сонсголын бэрхшээлтэй иргэн дохионы хэлний хэлмэрчээр

46. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, 14 дүгээр бүлэг. 14.2

47. Монгол улсын хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, 13 дугаар зүйл. 2 дахь заалт

хангагдах, харааны бэрхшээлтэй бол мэдээллийг том шифтээр авах, нурууны гэмтэлтэй бол налуу түшлэгтэй сандлаар үйлчлүүлэх гэх мэт.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн хүссэн газраа очиж болдог уу? Тийм нөхцөл боломж байдаг болов уу? Бусад хүмүүстэй адил аялж зугаалж, амьдрах газраа сонгомоор санагддаг.



Би хаашаа ч чөлөөтэй зорчиж, аялж, зугаалж хаана ч очоод амьдарч болох уу?



Хэн бүхэн хөдөө орон нутаг, хот суурин газар гээд улсдаа чөлөөтэй зорчиж, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхтэй. Гадаад улсад аялж жуулчлахаас гадна мөрдөлт мөшгөлтөөс зугтаж эх орноо орхин явах, эх орондоо буцаж очих, харьяаллаа өөрчлөх эрхтэй.



Унаа тээвэр нь хэр хүртээмжтэй байх ёстой юм бол?



Нийтийн тээврийн байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүн нийтийн тээврийн хэрэгслээр чөлөөтэй зорчих нөхцөлийг бүрдүүлсэн байх ёстой. Өөрөөр хэлбэл нийтийн тээвэр хүртээмжтэй байх ёстой. Манай улс галт тэргийг хүртээмжтэй болгох ажлыг эхлүүлсэн. Галт тэргээр аялах бол хүртээмжтэй суудлын галт тэрэг ямар чиглэлд, хэзээ явахыг эхэлж тодруулж асуух нь зүйтэй.



Аялал жуулчлалаар явахад онгоцоор нисэх хэрэг гардаг. Онгоцны буудал хүртээмжтэй байлаа гэж бодъё. Гэтэл нислэгийн үеэр ямар байх бол?



Хөгжлийн бэрхшээлтэй хүний оролцох биеийн тамир, спортын тэмцээн, уралдаан байдаг уу?



Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуус, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн олимп, пара-олимп, дифлимп, тусгай олимп, тивийн наадам, дэлхийн зэрэглэлийн тэмцээнүүд байдаг. Тэдгээрт оролцох, шалгаран явах, эхний байруудад шалгарахад урамшуулал олгодог.



Спортын заал нь хүртээмжтэй, миний онцлог хэрэгцээнд нийцсэн байдаг болов уу?



Биеийн тамир, спортын байгууламж нь хөгжлийн бэрхшээлтэй хүн тэмцээн уралдаан, нийтийн биеийн тамирын арга хэмжээнд оролцох, бэлтгэл сургуулилт хийхэд тохиромжтой заал, талбай болон тохирох хэрэглэгдэхүүнээр тоноглогдсон байх ёстойг хуульчилсан.



Онгоцны буудлын хүртээмжээс гадна нисэх буудлын ажилтан, онгоцны үйлчлэгчид нь хөгжлийн бэрхшээлийн талаар мэдлэггүй, бэлтгэлгүй байвал жинхэнэ бэрхшээл үүсгэнэ. Иймээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс спорт, чөлөөт цагаа өнгөрүүлэх, аялал жуулчлалын байгууллагуудад хүрэх, эдгээрийг зохион байгуулдаг байгууллагуудын үйлчилгээг хүртэх боломжтой байх явдлыг хангах талаар олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ төр засаг биелүүлэх ёстой. Хууль журам батлахаас гадна хэрэгжүүлж байгаа байдлыг нь хянаж, дүгнэж, сайжруулахад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрсдөө эрхээ шаардаж нөлөөлөх арга байдаг.

Хүртээмж үнэхээр чухал юм. Нийтийн тээвэр, тээврийн хэрэгсэл хүртээмжгүй байвал би чөлөөтэй зорчих, спорт соёлын арга хэмжээнд оролцох эрхээ эдэлж чадахгүйд хүрэх юм байна. Зочид буудал, зоогийн газрын шат, хаалга, ширээ сандал, ор, бие засах газар хүртээмжтэй байх ёстой. Бас тэндэхийн ажилтны хандлага, бэлтгэл миний онцлог, хэрэгцээнд нийцсэн үйлчилгээтэй байсан цагт би чөлөөтэй зорчиж болох нь. Бүх зүйл сайхан болсон цагт би зорчиж, аялна гэж хүлээж байхаар аянд гараад үзье. Миний зорчих үед уулзах хүмүүс, үйлчилгээний газрууд хүмүүсийн ялгаатай байдлыг мэдрэх нэг боломж болох ч юм билүү.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тусгай спортын төрлүүд байдаг. Би эдгээр тусгайгаас гадна бусад спортоор хичээллэж, спортын үйл ажиллагаанд оролцох, нийтийн эзэмшлийн тоглоомын талбайд тоглох болон спортын танхимд сургуулилах эрхтэй. Мөн хичээллэх танхим байрны хүртээмжийн тухай асуудал гарч ирнэ. Тэгэхээр биеийн тамир, спортын байгууламж түгээмэл загвартай байх нь надад чухал.



Спортоос гадна чөлөөт цагаараа урлаг, соёлын арга хэмжээнд оролцох хүсэлтэй байна? Мэдээж барилга байгууламж хүртээмжтэй байх талаар манай улс шийдвэр гаргасан байх. Гэхдээ урлаг соёлын бүтээлийг хүртэж мэдрэх гэдэг нь арай өөр асуудал гэж бодох юм?



Хөгжлийн бэрхшээлтэй хүн өөрийн авьяас чадвараа нээн хөгжүүлж, өөрийн оронд зохиогдох соёл, урлаг, олон нийтийн арга хэмжээнд оролцохыг дэмжинэ гэж манай улс хуульчилсан. Үүнээс гадна уран зохиол, шинжлэх ухааны ном, сонин, сэтгүүлийг хөгжлийн бэрхшээлтэй хүн ашиглах, хэрэглэх боломжтойгоор орчин үеийн арга, техник, технологи ашиглан хэвлэх, бүтээх, түүнчлэн музей, номын сан, соёл, урлагийн бүтээлийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй болгох тухай зүйл заалт байдаг.



Урлагийн чиглэлээр суралцаж, сургалтад хамрагдах гэхээр надад заах хүсэлтэй урлагийн хүн байдаг юм болов уу?



Ийм хүсэлтэй урлагийн хүнийг олон улсын төсөл хөтөлбөрийн хүрээнд бэлтгэж эхнээсээ урлаг, соёлын тоглолт, арга хэмжээ зохиодог болсон.



Мэдээлэл

Соёлын амьдралд оролцох, чөлөөт цаг, амралтаа өнгөрүүлэх

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст театр, музей, кинотеатр, номын сан, аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлдэг газруудад нэвтрэх болон, хөшөө дурсгал болон үндэсний соёлын болон түүхэн газруудад хүрэх боломжийг хангах ёстой.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зөвхөн өөрийн төдийгүй нийгмийн амьдралыг баяжуулах үүднээс урлаг, уран бүтээлийн болон оюуны чадавхаа ашиглан хөгжүүлэх эрхтэй. Өөрөөр хэлбэл хөгжлийн бэрхшээлтэй зохиолч, дуучин, зураач, хөгжимчин, эрдэмтэн, жүжигчин, бүжигчин байж болно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс урлагийн бүтээлийг хүртэхэд оюуны өмчийн эрхийг хамгаалсан хууль тогтоомж нь үндэслэлгүй, алагчлах шинжтэй саад тотгорыг үүсгэхгүй байх явдлыг хангах үүднээс урлаг соёлын бүтээл, үйл ажиллагааг хүртээмжтэй хэлбэрээр хүртэх арга хэмжээг авах, тухайлбал ном, сэтгүүл, бусад материалыг брайл үсгээр хөрвүүлэх, аудио хуурцагт хөрвүүлэх, дохионы хэлээр хүргэх, орчин үеийн технологи ашиглан хүмүүст хүргэх хэрэгтэй.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тусгайлсан спортын төрлөөс гадна нийтийн биеийн тамир, спортын үйл ажиллагаанд аль алинд нь бүрэн хэмжээгээр оролцуулахын тулд спортын байгууламж хүртээмжтэй, сургалт, бэлтгэл хэрэгслээр хангаж, олон төрлийн арга хэмжээг дэмжиж сурталчлах ёстой.

Амралт чөлөөт цаг, аялал жуулчлал, спортын арга хэмжээг зохион байгуулж байгаа байгууллагууд аливаа үйлчилгээ, үйл ажиллагаандаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулахад анхаарах ёстой. Жишээлбэл, стадион, бассейн, музей, зочид буудал, ресторан гэх мэт.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд тоглоом наадгайд оролцох, амралт чөлөөт цагаа спортын арга хэмжээ, тухайлбал сургууль дээр зохион байгуулагдаж байгаа ийм төрлийн арга хэмжээнд бусад хүүхдийн адил оролцох тэгш боломжтой байх явдлыг хангах ёстой.

Соёлын болон хэлний онцлогтой холбоотой эрх

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрсдийн соёлын болон хэлний онцлог байдлаа хүлээн зөвшөөрүүлэх эрхтэй учраас дохионы хэл ашиглах, хос хэл соёлыг дэмжсэн туслалцаа авах ёстой. Сонсголгүй хүмүүсийн эх хэл нь дохионы хэл бөгөөд казак, тува хүмүүстэй адил хэлний цөөнх гэж хэлж болно. ХБХЭК-д сонсголгүйн соёлд хамрагдаж байгаа хүмүүсийн хувьд дохионы хэл нь тэдний эх хэл бөгөөд тэд өөрсдийгөө хөгжлийн бэрхшээлтэй гэж үзэхгүй харин соёлын болон хэлний цөөнх гэж үзэж байгааг хүлээн зөвшөөрчээ⁴⁸.

48. Ненси Флауэрс, Жоел Бальф нар, Хүний эрхийн төлөө, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах үйл ажиллагаа, нөлөөлөл гарын авлага, Нээлттэй нийгэм форум, 218 дахь тал



Би ер нь өөрөө шийдвэрээ гаргаж, шийдвэрээ хүндэтгүүлж, түүнийгээ ажил хэрэг болгож үр дүнд хүрсэн тохиолдол цөөхөн санагдах юм. Үүнтэй холбоотой эрх байдаг уу?



Хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын нэгэн адил ердийн оршин суугаа газартаа амьдрах тэгш эрхийг хүлээн зөвшөөрч, тухайн оршин суугаа орчиндоо бүрэн дүүрэн хамрагдаж оролцохыг бие даан амьдрах гэж хэлнэ.



Ганцаараа амьдарч чадахгүй над шиг хүн бие даан амьдарна гэж байх уу?



Хувийн туслах үйлчилгээ, зөвлөлдөх бүлэг буюу харилцан суралцах, зөвлөгөө өгөх үйлчилгээгээр хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрах эрх нь хангагдана. Жишээлбэл, хараагүй хүнийг тухайн орчинд зөв чиг баримжаатай, саадгүй, аюулгүй зорчиход нь туслах хөтөч нохой гэж байдаг.



МЭДЭЭЛЭЛ

Бие даан амьдрах эрх гэж юу вэ?

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусдын нэгэн адил оршин суух газар болон хаана, хэнтэй амьдрах эсэхээ чөлөөтэй сонгох боломжтой байх ёстой бөгөөд тусгай нөхцөл байдалд амьдрахыг түүнээс шаардах ёсгүй. Өөрөөр хэлбэл хөгжлийн бэрхшээлтэй хүнийг тусгаарлахгүй байх ёстой.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст гэрийн, оршин суугаа газрын болон тухайн оршин суугаа бусад орчны үйлчилгээ, түүний дотор амьдрахад нь дэмжлэг болохуйц болон тухайн оршин суугаа орчиндоо нийгмийн харилцаанд оролцоход хувийн туслалцаа хүртэх боломжтой байх бөгөөд нийгмээс тусгаарлах, хөндийрүүлэхээс хамгаалагдана. Өөрөөр хэлбэл эмнэлэг сургууль үзвэр, банк зэрэг үйлчилгээ, барилга байгууламж хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд хэрэглэх боломжтой, хэрэгцээнд нь нийцсэн байна.

ХНХ-ын сайдын тушаалаар хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрахыг дэмжих үйлчилгээ нь дараах төрөлтэй байхаар заажээ. Үүнд:

- хувийн туслах үйлчилгээ
- зөвлөлдөх бүлэг буюу харилцан суралцах, зөвлөгөө өгөх үйлчилгээ.



МЭДЭЭЛЭЛ

Хувийн туслах үйлчилгээ гэж юу вэ, түүнийг хэрхэн авах вэ?

Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээний нэг төрөл нь хувийн туслах үйлчилгээ юм. Хувийн туслах үйлчилгээг авахыг хүсвэл үйлчилгээнд хамрагдахыг хүссэн өргөдөл, иргэний үнэмлэхний хуулбар, эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэрийн хуулбарыг өөрийн оршин суугаа нутаг дэвсгэрийн сум, хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэнд өгнө. Мэргэжилтэн үйлчилгээнд хамрагдах хүсэлт гаргасан иргэнд нөхцөл байдлын үнэлгээ хийж, нэг сард авах үйлчилгээний цагийг тодорхойлсон дүгнэлт гаргана.

Амьжиргааг дэмжих зөвлөлөөр хэлэлцүүлж шийдвэрлүүлэх, шийдвэрийг аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагад хүргүүлнэ. Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь энэ журмын 2.5-д заасан шийдвэр, баримт бичгийг ажлын 5 хоногт багтаан хянаж, үйлчилгээнд хамрагдах иргэнд хувийн хэрэг нээн баталгаажуулж, сум, хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэнд хүргүүлнэ. Сум, хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн үйлчилгээнд хамрагдах эрх үүссэн тухай хүсэлт гаргасан иргэнд мэдэгдэж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын талаар танилцуулж, үйлчилгээнд хамруулах арга хэмжээ авна⁴⁹.



МЭДЭЭЛЭЛ

Зөвлөлдөх бүлэг буюу харилцан суралцах, зөвлөгөө гэж юу вэ?

Хөгжлийн бэрхшээлтэй хүний тулгамдсан асуудал, бэрхшээлийг шийдвэрлэхэд хувийн туслах үйлчилгээнээс гадна зөвлөгөө,

49. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал, Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журам, 2021 он, А\187 дугаар тушаал

туслалцаа үзүүлж, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, мэдлэг хуримтлуулах, хөгжин дэвших, харилцан итгэлцэлд суурилсан дадал, чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн олон төрлийн хамтын үйл ажиллагаа байдаг. Үүнийг зөвлөлдөх бүлэг буюу харилцан суралцах, зөвлөгөө өгөх үйлчилгээ гэдэг. Эдгээр нь:

- Амьдралын итгэл үнэмшил бий болгох, бие даан амьдрах чадвар эзэмшүүлэх сургалт,
- Хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих сургалт,
- Хувь хүний өөрийгөө үнэлэх үнэлэмж, амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, тулгамдсан асуудал бэрхшээлийг даван туулахад дэмжлэг үзүүлэх чиглэлээр дараах зөвлөгөө, мэдээлэл

Энэ үйлчилгээг авснаар эерэг сэтгэлгээг хөгжүүлэх, өөдрөг хандлага ба амьдралыг үзэх үзэл, үнэлэмжээ дээшлүүлэх, харилцаа хандлага, эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэхэд өөрийгөө зөв илэрхийлж, бусадтай харилцах чадвартай болохоос гадна өдөр тутмын үйлдэл хийхэд шаардлагатай ахуйн болон тэргэнцэр, туслах хэрэгсэл, цагаан таяг, зэргийг ашиглах, эзэмшиж, дохионы хэлний анхан шатны мэдлэгтэй болно. Мөн гар урлал, сүлжмэл эдлэл, модон эдлэл, бэлэг дурсгал, оёдол, компьютерийн хэрэглээний болон цахим орчинд ажиллах анхан шатны мэдлэг, чадвар, санхүүгийн болон бизнес эрхлэх суурь мэдлэг олгох, хуримтлал үүсгэх, өрхийн төсөв хөтөлж сурна.

Үүнээс гадна нийгмийн үйлчилгээ, эдийн засаг, санхүү, сэтгэл зүй, хууль зүй, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр зөвлөгөө авна.

Амьдарч буй орчиндоо бие даан нэр төртэй амьдрахын тулд би нийтийн тээврээс эхлэн чөлөөтэй зорчих минь бас хамаарна. Өөрөөр хэлбэл хөгжлийн бэрхшээлтэй хүний хувийн хөдөлгөөнийг тэдний сонгосон аргаар, сонгосон цаг хугацаанд нь аль болох хамгийн бага зардлаар хангах явдлыг дэмжиж байж би эрхээ эдэлнэ. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй иргэн нийслэл, аймгийн төвийн нийтийн тээврийн хэрэгсэл /таксинаас бусад/-ээр орон нутгийн харьяалал харгалзахгүйгээр үнэ төлбөргүй зорчихыг хуульчилсан.



Заримдаа хөгжлийн бэрхшээлтэй хүний амьдрал бусдынхаас доогуур үнэ цэнтэй юм шиг санагдах юм. Жишээ нь газар хөдлөлтийн сургуулилт хийхэд би яаж оролцож, юу хийх, гамшиг тохиолдоход юу хийж хаашаа хандахаа мэдэхгүй. Гамшиг болоход би яахаа ч мэдэхгүй байна гэдэг аймшигтай санагдаж байна.



Байгалийн гамшиг болон онцгой байдал бий болох үед хөгжлийн бэрхшээлтэй хүнд энэ тухай хүртээмжтэйгээр мэдээлэх, тухайн үед амь нас, эрүүл мэндийг нь онцгой байдлын нөхцөлтэй уялдуулан хамгаалах ёстой. Гэхдээ яг яаж хамгаалах тухай тодорхой биш байгаа нь үнэхээр дутагдалтай. Олон улсад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст туслах, дэмжлэг үзүүлэх хүмүүсийн сүлжээг үүсгэж, бэлтгэх зэргээр ажиллаж, хүмүүсийн анхаарлыг татан дэмжлэг авч, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг тодорхой болгож байсан туршлага байдаг. Үүнээс санаа авч болох юм.

Байгалийн гамшиг тохиолдлоо гэхэд цахилгаан, ус тасарна. Бусадтай холбоо барих аргагүй, зурагт, радио ажиллахгүй. Протез, сонсголын аппарат, шил, таяг, тэргэнцэр гээд туслах хэрэгслүүд гээгдэх, эвдрэх, хоол хүнс хомсдох, орон байргүй болох, 00 орох аргагүй болох үед юу хийх талаар би гэр бүл ойр дотныхонтойгоо ярилцаж төлөвлөө. Ажил сургууль дээрх аюулгүйн гарц, цугларах цэг/байр хаана байдаг, гамшгийн үед би хаана байрлах зэргээр сургууль хийвэл тэд ч мөн тодорхой ойлголттой болж гамшгийн үеэр ажиллах төлөвлөгөөтэй болно гэж бодлоо.



МЭДЭЭЛЭЛ

Амьд явах, хүмүүнлэгийн гамшиг болон эрсдэлт нөхцөл байдал гэж юу вэ?

Хүн бүр амьд явах салшгүй эрхтэй бөгөөд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусдын нэгэн адил энэ эрхээ бүрэн дүүрэн эдлэхийн тулд эрсдэл бүхий байдал, тухайлбал зэвсэгт мөргөлдөөн, хүмүүнлэгийн гамшиг, байгалийн аюул гамшиг тохиолдсон үед хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамгаалах, аюулгүй байдлыг нь хангахад

чиглэсэн шаардлагатай бүхий л арга хэмжээг авах ёстой. Жишээлбэл мэдээллийг хүртээмжтэй хэлбэрээр авах эрх нь эрсдэлт нөхцөл байдлын үед амьд явах эрхийг хамгаална.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүнд эрүүл мэндийн үйлчилгээ, сэхээн амьдруулах эмчилгээ хүртээмжгүй бол амьд явах эрх нь зөрчигдөнө. Үүнээс гадна аюултай нөхцөлд ажиллуулах, албадан хөдөлмөр эрхлүүлэх ч амьд явах эрхтэй холбоотой.

Амьд явах эрхийг хамгаална гэдэгт хүний наслалтыг нэмэгдүүлэх, хүүхэд нярайн эндэгдлийг бууруулах өвчинтэй тэмцэх, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх, хоол хүнс, ундны ус, орон байрны хүртээмжийг хангалттай хэмжээнд хүргэх зэрэг арга хэмжээ орно. Тэгэхээр хөгжлийн бэрхшээлтэй хүний амьд явах, хүмүүнлэгийн хямралын үед хамгаалуулах эрхийг хангахын тулд хөгжлийн бэрхшээлтэйгээр амьдрах хэрэггүй гэх сөрөг хандлага үзэл бодлыг няцаахаас эхлэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст туслах тусгай аврагчдыг сургаж бэлтгэх ёстой.



Эрүүл байх гэж юу юм бэ? Эрүүл байх нь эрх мөн үү?



Эрүүл мэнд гэж зөвхөн ямар нэг өвчин, өвчлөлгүй байхыг хэлээд зогсохгүй мөн бие, сэтгэл, нийгмийн амьдралын бүрэн дүүрэн сайн сайхан байдлыг⁵⁰ хэлдэг. Боломжит хамгийн дээд түвшинд эрүүл байх эрх нь хөгжлийн бэрхшээл зэрэг хүний ялгаатай байдлаас үл хамааран хүн бүрийн хамгийн чухал суурь эрхийн нэг. Ингэхээр эрүүл байх эрх гэдгийг боломжит дээд түвшинд эрүүл байх гэж ойлгоно.



Би бусадтай адил ханиад томуу зэрэг халдварт өвчнийг хүнд, хөнгөн янз бүрээр л тусдаг. Хөгжлийн бэрхшээлтэй болохоор өвдөөд байгаа юм уу, эсвэл өвдөөд байгаа болохоор хөгжлийн бэрхшээлтэй юм уу?



Хөгжлийн бэрхшээлтэй хүн удаан хэвтсэнээс болж арьс цоорох, цаашлаад амьсгалын дутагдалд орвол нэг асуудал. Харин өвчнөөс болоод чадвар алдалт, хөгжлийн бэрхшээлтэй болвол бас өөр асуудал юм аа.

50. Дэлхийн эрүүл мэндийн байгууллын тодорхойлолт, <http://www.who.int/governance/eb/constitution/en/index.html>

Өөрөөр хэлбэл хөгжлийн бэрхшээл өөрөө өвдөх шалтгаан ч болдог, эсвэл өвдсөнөөс гарах үр дагавар ч болдог. Үүнээс болж олон хүн хөгжлийн бэрхшээлийг өвчин гэж үзээд эдгээх, эмчлэх ёстой гэж боддог. Ингэхээр хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудлыг зөвхөн анагаах ухаанд хамааруулж, эрүүл байх эрхийг зөрчигдөхөд хүргэсэн алагчлал, хүртээмжгүй байдал, нийгмийн бусад амьдралд оролцох асуудлыг орхигдуулдаг. Хөгжлийн бэрхшээлтэй ч цоо эрүүл биетэй хүн ч байдаг шүү дээ.



Тийм юм байна. 00-д ороход усны цоргыг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэйгээр хийхгүйгээс болоод ариун цэврээ сахиж чаддаггүй. Үүнээс болж намайг өвчин тусах тухай бодож тооцоолоогүй. Өвдсөн үед л эмчлэх, зөвхөн эмнэлэг л надад үйлчлэх юм шиг ханддаг болчихжээ.



МЭДЭЭЛЭЛ

Эрүүл мэндийн үйлчилгээ авах эрх гэж юу вэ?

Төрөөс хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, оношлох, үнэлэх, урьдчилансэргийлэх, эмчлэх, сувилах, сэргээн засах цогцарга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Ингэхдээ хөгжлийн бэрхшээлийг эрүүл мэндийн асуудал гэж үзэх буруу ойлголтоос болж сэргээн засах үйлчилгээг зөвхөн эрүүл мэндийн байдалтай холбож үзэх ёсгүй. Өөрөөр хэлбэл эрүүл мэндтэй холбоотой нөхөн сэргээлтийг эрүүл байх эрхийг хангаж буйн нэг хэлбэр гэж үзэхээс илүү өргөн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бие махбод, мэдрэхүй, нийгмийн амьдралын чадавхаа зохистой түвшинд хүргэж хадгалах боломжийг олгосон, улмаар амьдралаа илүү бие даасан байдал руу залж өөрчлөхөд нь туслах арга хэрэгслээр хангаж өгөх үйл явц⁵¹ гэж ойлгоно.

Жэндерийн онцлогийг харгалзсан эрүүл мэндийн болон нөхөн сэргээх үйлчилгээ гэж юу вэ?

Орлого багатай, алслагдмал нутгийн хүн ам болон үндэстний цөөнхийн хүүхэд төрүүлэх, хүүхдээ асрах эрхийг хангах ба түүнд шаардлагатай туслалцаа, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах арга хэмжээ авна⁵². Үүнийг хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хүсээгүй жирэмслэлт,

51. <http://www.ohchr.org/english/law/opportunities.htm>

52.

бэлгийн замын халдвараас урьдчилан сэргийлэх, хамгаалах эрхэд халдан хүч хэрэглэх, тулган шаардаж үр хөндүүлэхийг ятгах, шаардах, дарамтлахыг хориглоно гэж ойлгоно.

Үүнээс гадна хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нөхөн үржихүйн болон эрүүл мэндийн чиглэлийн бусад сургалт, сурталчилгаанд оролцох, үзлэг, шинжилгээнд бусадтай адил хамрагдахад дэд бүтэц, мэдээлэл зэрэг нь хүртээмжтэй байх ёстой. Тухайлбал хүний эрх, эрхэм нандин чанар, хараат бус байдал болон хөгжлийн бэрхшээлтэй хүнд боловсрол олгох тусгай хэрэгцээ, улсын болон хувийн эмнэлгийн ажилтнуудын ёс зүйн дүрмийг баримтлана.

Эрүүл мэндийн байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ тэдний онцлог хэрэгцээ, шаардлагыг хангасан хүртээмжтэй орчин, техник, тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна. Энэ нь эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж хөгжлийн бэрхшээлтэй хүн нэвтрэх боломжтой, бараа үйлчилгээ, эрүүл мэндтэй холбоотой мэдээлэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ойлгомжтой, ойр, аюулгүй хүрч болох зайд байрлана гэсэн үг.



Намайг ажил дээр орж гарахад чөлөөтэй, ажиллах орчинг бүрдүүлж өгсөн. Гэхдээ намайг туслах хэрэгслээ яаж ашиглаж, ажиллуулахыг зааж чадахгүй байна. Би яах ёстой вэ?



Үүнд чамд дэмжлэг хэрэгтэй болно. Хөгжлийн бэрхшээлийн онцлогоос хамаараад туслах техник технологи, тусгай сургалт, ур чадварыг чинь хөгжүүлэхийн тулд сэргээх ба нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлнэ.



Шинэ юм сурч байж ажиллаж, амьдрах нь ээ дээ?



Чи сэргээх, нөхөн сэргээх үйлчилгээг авч чадахгүй бол ажил хөдөлмөр эрхлэх, сургуульд сурах, соёл урлаг, спорт болон бусад олон арга хэмжээнд оролцох боломж багасаж магадгүй. Өөрөөр хэлбэл чи бусад хүнтэй адил эрх эдлэх ёстой ч чи бусдаас арай өөрөөр, тухайлбал өөртөө үйлчлэх, мэдлэг, чадвар эзэмших, бусадтай харилцах, орчиндоо дасахад суралцаж, дадлагажиж байж амьдралын зорилгоо биелүүлнэ гэсэн үг.



МЭДЭЭЛЭЛ

Сэргээн засах тусламж, үйлчилгээ гэж юу вэ?

Энэ үйлчилгээний зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй хүний хараат бус байдлыг дээд зэргээр хангах, тэднийг бие махбод, оюун санаа, нийгмийн болон мэргэжлийн бүрэн чадавхтай болгох, нийгмийн бүхий л хүрээнд бүрэн хамрагдах, оролцох боломжийг эзэмшүүлэх явдал. Өөрөөр хэлбэл хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие махбод, мэдрэхүйн, оюуны, сэтгэцийн/нийгмийн чадавхийн хамгийн дээд хэмжээнд биеэ даах чиглэлд амьдралаа залж өөрчлөх арга ухаанаар хангахад чиглэсэн үйл явц юм⁵³. Жишээ нь: хөгжлийн бэрхшээлтэй болсон, эсвэл хөгжлийн бэрхшээл нь хувьсан өөрчлөгдсний улмаас тухайн хүн хэрвээ тусгай хэрэгсэл ашигладаг бол түүнийгээ ашигладаг болгоход сургах гэж ойлгож болно.

Сэргээн засах тусламж, үйлчилгээг сэргээн засахын эмч, хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч, хэл засалч, сэтгэл засалч болон сэргээн засахын бусад мэргэжлээр мэргэшсэн эмнэлгийн мэргэжилтэн үзүүлнэ.

Хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээ гэж юу вэ?

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зорилготой өмчийн бүх хэлбэрийн байгууллагын үзүүлдэг олон төрлийн үйлчилгээ юм. Тухайлбал, өвчин, эмгэг, гэмтэл, бэртлийн улмаас үүссэн үр дагаврыг арилган хэвийн байдалд оруулахад чиглэсэн эрүүл мэндийн, бусдын адил боловсрол, мэргэжил эзэмшихийг дэмжих боловсролын чиглэл, гэр бүл, хамт олондоо эдийн засгийн хувьд хувь нэмрээ оруулахыг дэмжих хөдөлмөрийн, гэр бүл, хамт олны дунд бусдын адил үүрэг хариуцлага хүлээсэн, идэвхтэй, бие даасан гишүүн болохыг дэмжих нийгмийн, нийгмийн бүхий л харилцаанд оролцохыг дэмжих дэд бүтэц, зам тээвэр, мэдээллийн технологийн хүртээмжийн гэх зэрэг.

53. <http://www.un.org/ecosocdev/geninfo/dpi1647e.htm>

Эдгээр үйлчилгээний талаарх мэдээлэл нь хүртээмжтэй байх ёстой бөгөөд надад нэн түрүүн шаардлагатай байгаа хэрэгцээг олон талаас нь үнэлж, дүгнэсний үндсэн дээр аль болох эрт үед хэрэгжүүлж эхлэх бөгөөд хөтөлбөр боловсруулахад нь би өөрөө оролцож хүсэл сонирхлоо илэрхийлнэ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувьд эцэг эх нь хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээнд заавал хамруулах үүрэгтэй.



Тусгай хэрэглээний протез зэргээс гадна би өөрийгөө болон гэр бүлээ тэжээн тэтгэхэд ямар нэгэн дэмжлэг байдаг уу?



Хөгжлийн бэрхшээлтэй хүн хоол хүнс, хувцас, орон байр, эмчилгээ сувилгаа, нийгэм ахуйн зайлшгүй шаардлагатай үйлчилгээг оролцуулаад өөрийн болон гэр бүлийнхээ эрүүл мэнд, аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрхтэй. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн хамгааллын болон нийгмийн халамжийн хөтөлбөрт хамруулж хувийн онцлог хэрэгцээнд тохирсон тусгай хэрэглээний протез, ортопед, ариун цэвэр-эрүүл ахуйн материал, асаргаа сувилгааны болон бусад туслах хэрэгслээр хангадаг.

Бүрэн хараагүй, сонсголгүй, хэл ярианы бэрхшээлтэй хүний харилцаа холбооны зардалд хөнгөлөлт үзүүлдэг. Хараагүй хүний брайл үсгээр бичсэн захидал, ил захидал, брайл хэвлэл, 10 кг хүртэлх илгээмжийг дотоодод үнэ төлбөргүй явуулах ба, хараагүй хүн ашиглах зориулалттай техник, тоног төхөөрөмж, материал хэрэгслийг хүргэхэд дотоодод үнэ төлбөргүй байдаг. Аарцаг эрхтний үйл ажиллагаа алдагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүнд эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр зайлшгүй шаардлагатай асаргаа сувилгаа, ариун цэвэр-эрүүл ахуйн материалын дэмжлэг үзүүлдэг.



Тэтгэмжийн мөнгө амьжиргаанд хүрэлцэхгүйгээс хүүхдээ хохироох вий гэж бодох юм?



Өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлж нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэн болон тэдгээрийг асран хамгаалагчийг нийгмийн халамжийн үйлчилгээ, тусламжид хамруулна. Хүүхдээ цэцэрлэг, сургуульд нь хүргэхэд ирж, очих унааны зардлыг хөнгөлөх, эсхүл автобусаар үйлчилнэ. Байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, бүрэн хараагүй, бүрэн хэлгүй, дүлий, одой иргэн болон байнгын асаргаа шаардлагатай, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан зэрэг иргэдэд орон сууцны хөлс төлөхөд мөнгөн тусламж олгодог.



Гэрт амьдардаг бол яах вэ?



Хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад нь жилд нэг удаа мөнгөн тусламж олгодог.



Тэтгэмжийг хэдэн нас хүртлээ авдаг вэ? Тэтгэвэрт гарах гэхээр нийгмийн даатгалд хамруулах асуудлыг яаж шийдсэн байдаг юм бол?



Нийгмийн даатгалын шимтгэлийг 3-аас дээш жил төлж хөдөлмөр эрхэлж байгаад хөгжлийн бэрхшээлтэй болсон бол Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрхтэй бөгөөд энэ эрх нь үүсээгүй бол нийгмийн халамжийн сангаас тахир дутуугийн тэтгэвэр авдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн өндөр насны тэтгэвэр тогтоолгох насны болон нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байвал зохих хугацааны болзлыг хангасан тохиолдолд өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй. Харин өндөр насны тэтгэвэр нь тахир дутуугийн тэтгэврээс бага тогтоогдох тохиолдолд өөрт илүү таатай тэтгэврийн төрлийг сонгон авах боломжийг хуулиар зохицуулсан. Харин Эрүүл мэндийн даатгалыг төрөөс хариуцдаг.



МЭДЭЭЛЭЛ

Нийгмийн хамгаалал:

- Иргэн хөдөлмөрийн чадвараа алдсан;
- гэнэтийн осолд орсон;
- мөн амьдралын боломжгүй ахмад настан;
- хөгжлийн бэрхшээлтэй иргэн;
- нийгмийн эмзэг бүлэгт төрөөс үзүүлэх халамж, дэмжлэг юм.

Иргэд өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд мөнгөний тусламж авах эрхтэй⁵⁴.

Нийгмийн хамгааллыг:

- Нийгмийн даатгал
- Нийгмийн халамж гэсэн 2 төрөлд ангилдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хиймэл эрхтэн, туслах хэрэгсэл авах зардлыг Нийгмийн даатгалын, Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын, Тэтгэмжийн даатгалын, Эрүүл мэндийн даатгалын, Нийгмийн халамжийн сангаас санхүүжүүлэх юм байна. Гол нь эдгээр мэдээлэл надад хүртээмжтэй хүрч байж би ямар эрх үүссэн, эрхээ хэзээ эдлэхээ мэднэ. Мэдээлэл хүртээмжтэй байна гэдэг нь надад тохирох хэл, зураг, энгийн ойлгомжтой үг хэллэг, аудио хэлбэртэй байна гэсэн үг.



МЭДЭЭЛЭЛ

Халамжийн дараах 26 төрлийн үйлчилгээг Ehalamj.mn болон E-Mongolia системд цахимаар үзүүлж байна.

1. Ахмад настны тэтгэвэр
2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр
3. 16 насанд хүрсэн одой иргэний тэтгэвэр

54. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйл

4. Тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхдийн тэтгэмж
5. Өрх толгойлсон эцэг, эхийн тэтгэвэр
6. Бүтэн өнчин хүүхдийг үрчилж авсан болон эрсдэл бүхий нөхцөлд байгаа хүүхдийг асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа иргэний тэтгэмж
7. Гэр бүлийн тухай хуулийн 35.5-д заасан болон хүчирхийллийн улмаас сэтгэл санааны эсвэл бие махбодын хохирол хүлээж хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа иргэний тэтгэмж
8. Ахмад настныг гэртээ асрамжилж байгаа иргэний тэтгэмж
9. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг гэртээ асарч байгаа иргэний тэтгэмж
10. Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асарч байгаа иргэний тэтгэмж
11. Байнгын асаргаа шаардлагатай ахмад настныг асарч байгаа иргэний тэтгэмж
12. Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа иргэний тэтгэмж
13. Гэнэтийн аюул, осол, урьдчилан төсөөлөх боломжгүй бусад шалтгаанаар гэр оронгүй болсон, эсвэл гэр орон нь цаашид амьдрах боломжгүй болсон болон амьжиргааны эх үүсвэрээ алдсан өрхийн тэтгэмж
14. 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэний тэтгэмж
15. Хорих ангиас суллагдсан өөрийн гэсэн гэр оронгүй, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн – иргэний тэтгэмж
16. Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай, дөрөв ба түүнээс дээш 18 хүртэлх насны хүүхэдтэй, гэр оронгүй, өрх толгойлсон эцэг, эхийн тэтгэмж
17. Байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхдийн тэтгэмж
18. Байнгын асаргаа шаардлагатай 16 ба түүнээс дээш насны иргэний тэтгэмж
19. Алдарт эхийн одонгийн мөнгөн тусламж
20. Хүүхдийн мөнгөн тэтгэмж

21. Насны хишиг
22. Алдар цолтой ахмад настанд үзүүлэх нэмэгдэл, хөнгөлөлт
23. Гурав хүртэлх насны хүүхэд асарсаны тэтгэмж
24. Жирэмсэн эхийн тэтгэмж /жирэмсний 5 сартайгаас төрөх хүртэлх хугацаа/
25. Ихэр хүүхдийн тэтгэмж
26. Гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж



МЭДЭЭЛЭЛ

Хөдөлмөрлөх эрх гэж юу вэ?

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн чадавхийн тухай сөрөг хандлага, төсөөллийн улмаас ажил олгогчид хөгжлийн бэрхшээл нь хүний чадавхийг дордуулж, ажил хөдөлмөр хийж чадахгүй, бусдад аюултай, эсвэл бусад хүмүүс дургүйцнэ гэсэн дүгнэлт хийдэг. Ийм буруу ойлголттой хүмүүс хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажилд авахгүй, эсвэл түүний мэдлэг, ур чадварыг бүрэн дайчлахааргүй ажил олгодог. Мөн ажлын байранд нь нэмэлт туслах хэрэгсэл зэрэг нь өндөр үнэтэй, зардал чирэгдэл ихтэй гэж үздгээс болж зарим тохиолдолд бага цалин өгдөг. Эсвэл нэг ажилтан дургүйцвэл тусгаарласан ажлын байранд ажиллуулдаг. Эдгээр хандлага, төсөөллийн нөлөөгөөр хөгжлийн бэрхшээлтэй хүн ажилд орох, ажлын байраа хадгалах, албан тушаал дэвших зэрэг ажлын талбарт бүхий л үе шатанд хөдөлмөрлөх эрхийн зөрчилтэй учирдаг.

Хүний хөдөлмөрлөх эрхийг үгүйсгэх нь хүний өөрийгөө хүндлэх, үнэлэх мэдрэмжид сөргөөр нөлөөлөх хамгийн муу, сөрөг үр дагаврыг авчирдаг. Улмаар орлогогүй болсон хүн халамжийн мөнгөнд захирагдан амьдарч, нийгмийн бусад гишүүдээс доогуур үнэлэгдэх, сэтгэл дундуур аж төрөхөд хүргэнэ.

Тиймээс хөдөлмөрлөх эрхээ бүрэн эдлэх нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн эрх тэгш гишүүн байх, өөрийгөө үнэлэх, хүндэтгэхэд чухал нөлөө үзүүлнэ.



Би бусадтай л адил ажил хийх боломж байдаг уу? Эсвэл зөвхөн үйлчилгээний туслах ажил хийх ёстой юм уу?



Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажилд орох, албан тушаал дэвших, цалин хөлс, нөхөн олговор авах, хөдөлмөр эрхлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд бусадтай адил тэгш хамрагдах эрхтэй. Ингэхийн тулд ажил олгогч хөгжлийн бэрхшээлтэй хүний бие эрхтэн, хөгжлийн онцлогт нийцсэн ажлын байрыг бий болгож ажиллуулах үүрэгтэй.



Намайг ажилд авахаар тухайн байгууллагад хүндрэл учрах байх даа?



Харин ч эсрэгээрээ хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулж байгаа иргэн, хуулийн этгээдийг хууль тогтоомжийн дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах, тохирох хэрэглэгдэхүүн бүхий ажлын байр бий болгохыг урамшуулахаар Хөдөлмөрийн тухай хуулинд заасан. Мөн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, төсвийн хөрөнгөөр тэргүүн ээлжинд худалдан авна. Чамайг мэргэжлээрээ ажиллахад шаардагдах ажлын багаж, тоног төхөөрөмж, материал болон бусад шаардлагатай хэрэгслийг худалдан авахад нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас нэг удаа санхүүгийн дэмжлэг үзүүлэх ёстой.



Гэхдээ намайг шууд авчихгүй байх, эсвэл ерөөсөө авахгүй ч юм билүү?



Ажлын байрны нээлттэй сонгон шалгаруулалт зарлахдаа хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээг харгалзан үзэх л ёстой. Харин чи өөрийн хэрэгцээ, шаардлагын талаар хүсэлт гаргаад нээлттэй сонгон шалгаруулалтад оролцохдоо өөрийн онцлог хэрэгцээ, шаардлагад тохирох тусламж, нэмэлт цаг ашиглах эрхтэй болно.

Цалин хөлс олгож байгаа гэх шалтгаанаар хөдөлмөр эрхэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн халамжийн болон нийгмийн даатгалын аливаа тэтгэвэр, тэтгэмжийг хэн ч зогсоох ёсгүй.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн хөдөлмөрийн нээлттэй зах зээлд өрсөлдөж хувиараа хөдөлмөр эрхэлж болно. Ингэхийн тулд дангаараа болон бусадтай хамтран аж ахуй эрхэлж, татварын албанд бүртгүүлнэ. Хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлогыг албан татвараас чөлөөлдөг. Мөн ХБХХЕГ-аас зарладаг хөгжлийн бэрхшээлтэй хүний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт хамрагдах боломж байдаг.

Хөдөлмөрлөх эрхээ эдлэхгүй байх, тээврийн хэрэгсэл хүртээмжгүй бол, зөвхөн тусгай байгууламжид амьдарч тусгай эмнэлэг сургуулиар үйлчлүүлдэг бол хөгжлийн бэрхшээлтэй хүн хэзээ ч бие даан амьдарч чадахгүй. Мөн амьжиргааны хүрэлцэхүйц түвшинд хүрээгүй бол, хүмүүсийн дунд байхдаа эвгүйцэх, таагүй, аюултай мэдрэмж авдаг бол амьдарч буй орчиндоо бие даан, нэр төртэй амьдрах эрх хангагдахгүй байна гэсэн үг.

Нийгмийн амьдралаас гадна хувийн орон зай, эргэн тойронд асуудлууд байх юм. Энэ талаар тодруулж ярилцах хэрэгтэй гэж үзээд Номинтой уулзлаа.



Зарим үед надад хувийн туслах юмуу, асран хамгаалагчийн туслалцаа хэрэг болдог. Энэ үед эдгээр хүмүүс миний регистрийн дугаар, мөнгө санхүүгийн талаар мэдээлэлтэй болж, усанд орох үед миний биед хүрдэг. Тэгэхээр энэ хүмүүс ер нь миний хувийн нууцыг хадгалдаг болов уу?



Чи хувийн халдашгүй байдал, нэгдмэл байдлаа хүндлүүлэх эрхтэй. Тэгэхээр тэр хүмүүс чиний эдгээр эрхийг хүндэтгэж харилцаж, мэргэжлийн ёс зүйг мөрдөх ёстой. Хэрэв үүнийг зөрчвөл хөгжлийн бэрхшээлтэй хүний төрөлхийн нэр хүндийг гутаасан хэрэг болно.



Хувийн халдашгүй байдал, хувийн нэгдмэл байдал гэж юу вэ?



Хувийн халдашгүй байдал буюу хувийн нууц, хувийн нэгдмэл байдлаа хүндэтгүүлэх хоёр нь тусдаа боловч хоорондоо уялдаатай. Жишээ нь чиний хувийн, эрүүл мэндийн болон нөхөн сэргээлтийн талаарх нууцлалыг хамгаалахыг хувийн нууцыг хүндэтгэх гэж ойлгоно. Харин чамтай хүний ёсоор харьцаж, бие махбод, сэтгэл зүйн бүрэн бүтэн байдалд халдахгүй, хүндэтгэж харилцахыг нэгдмэл байдлаа хамгаалуулах гэнэ. Аль аль нь бусад эрхээ эдлэхэд нөлөөтэй. Шүүх хүртээмжгүй байвал чиний хувийн нууц, нэгдмэл байдлаа хүндлүүлэх эрх зөрчигдөж шүүхээр асуудлаа шийдвэрлүүлж чадахгүйд хүрнэ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хувийн мэдээлэлдээ эзэн болж чадахгүй гэж үзсэн хүмүүс бидний мэдээллийг зохих газарт нь өгөхгүй, буруу мэдээлэл тараах эсвэл мэдээллийг нь тараах, буруугаар ашиглах, хүчээр дарамт шахалтаар эмчилгээнд оруулах, эм уулгах, хэл амаар доромжлох, хүч хэрэглэх, хүчирхийлэх, сэтгэл санааны дарамтад оруулах, мөнгийг нь хулгайлах зэрэг үйлдэл гаргадаг. Ийм ёс бус үйлдлийг шалгаж арга хэмжээ авалгүй орхивол яваандаа эрүү шүүлт, хүчирхийлэл, доромжлолоос ангид байх эрхийн зөрчилд хүргэж мэдэх нь.



МЭДЭЭЛЭЛ

Хувийн нэгдмэл байдлыг хамгаалах гэж юу вэ?

Хөгжлийн бэрхшээлтэй хүн бүр бусдын нэгэн адил өөрийнхөө бие махбод болон сэтгэхүйн нэгдмэл байдлаа хүндэтгүүлэх эрхтэй⁵⁵. Энгийнээр хэлбэл хувийн нууцыг хуулиар хамгаалдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчилгээ үзүүлж байгаа аливаа этгээд хөгжлийн бэрхшээлтэй хүний нууцыг задруулахыг хориглоно⁵⁶.

Хувийн нууцаа хамгаалуулах эрх нь хувийн орчин буюу хүний орон гэр, гэр бүл, хамт амьдардаг хүмүүсээс эхлээд машин тэрэг, морь мал, хувийн өмч зэрэг бүгд хамаарна.

55. НҮБ-н конвенц, *Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай*, 17 дугаар зүйл

56. Монгол улсын хууль, *Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай*, 31 дүгээр зүйл, 31.2

Хувийн нууцыг хүндэтгэх гэж юу вэ?

Амьдран буй газар, орон байрны нөхцөл байдлаас нь үл шалтгаалан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн буюу хууль бусаар оролцох, орон байр буюу захидал харилцааных нь нууцад дур мэдэн буюу хууль бусаар халдах, эсхүл нэр төр, алдар хүндэд нь хууль бусаар халдахыг хориглоно⁵⁷.

Ингэхээр хууль бус нэгжлэг хийх, мөрдөлт явуулах ч хориотой. Амьдран буй газраас үл хамаарна гэхээр асрамжийн газарт байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ч хамгаална. Захидал харилцаа гэдэгт цахим шуудан, мессеж зэрэг орчин үеийн хэлбэр ч мөн хамаардаг бөгөөд яриаг чагнах, захидлыг унших ёсгүй гэсэн үг. Гэрлэх үед өгсөн шинжилгээний хариу нь эмнэлгийн байгууллагын нууц байхыг хуулинд заасан.

Хүн бүрийн амьдрал үнэ цэнтэй. Өөрөөр хэлбэл хүнийг хүнийх нь хувьд хүлээн зөвшөөрч хүндэтгэх ёстой. Үүнийг хүний эрхэм чанар гэдэг. Хөгжлийн бэрхшээлтэй байхаас үл шалтгаалан намайг хүнийх нь хувьд хүлээн зөвшөөрч миний хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс оролцох, нууцад дур мэдэн халдах, нэр төр, алдар хүндэд минь хэн ч халдах ёсгүй.

Амьдралын бодит үнэнтэй нүүр тулах цаг хэзээ ч юм тулгарна. Тэр үед яах ёстойг Номингоос асууя.



Хэн бүхэн хорвоогийн мөнх бусыг үзүүлдэг. Тэр үед төр ямар арга хэмжээ авдаг юм бол?



Нас барсан тухай бүртгэж гэрчилгээ өгдөг. Оршуулгын тэтгэмжийг төр өгдөг.

57. НҮБ-н конвенц, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, 22 дугаар зүйл



Гэрийнхэнд маань хүнд тусах байх даа.



Үхэл, нас барах гэх үг хэцүү хүнд ч бодит зүйл гэдгийг хүлээж аваад энэ талаар хайртай хүмүүстэйгээ ярилцах нь чухал. Хөгжлийн бэрхшээлтэй хүн болон түүний асран хамгаалагчийн хувьд “Одоо тэдэн сарын настай, ер нь удахгүй нь” гэж сонсох, түүнийг ойлгоход хэцүү. Амьдрах цаг хугацаа бага үлдэж гэж мэдэх үед хэн юу хийх нь тодорхой бус байдаг. Энэ хүндрэлийг давахын тулд өмөг түшиг болж байгаа хүмүүс гэр бүл найз нөхөдтэйгээ цагийг өнгөрөөх, ижил зовлон туулсан хүмүүстэй уулзаж урам зориг авч тайвшрах нь чухал.



МЭДЭЭЛЭЛ

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нас барсныг нас барагчийн иргэний үнэмлэх болон доор дурдсан баримт бичгийн тохирохыг бүрдүүлж аймаг, нийслэлд 3, сум, Дипломат төлөөлөгчийн газарт 7 хоногийн дотор бүртгүүлнэ:

- 13.1.1. иргэний нас барсан тухай эмнэлгийн магадлагаа;
- 13.1.2. иргэнийг нас барсан гэж зарласан шүүхийн шийдвэр;
- 13.1.3. нас барсан шалтгааны тухай шүүх эмнэлгийн дүгнэлт;
- 13.1.4. гамшгийн улмаас хүний амь нас эрсэдсэн бол Засгийн газраас байгуулсан онцгой комиссын шийдвэр.

Улсын бүртгэгч нас барсны бүртгэл хөтөлж нас барсны гэрчилгээ өгнө.

Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан оршуулгын тэтгэмж авах эрх үүсээгүй, хөгжлийн бэрхшээлтэй хүн болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нас барвал түүний оршуулгын зардалд нийгмийн даатгалын сангаас олгох оршуулгын тэтгэмжтэй тэнцүү хэмжээний мөнгөн тусламж олгоно.

- 1. Тэтгэмжийн даатгалын шимтгэлийг нийтдээ 36 сараас доошгүй хугацаагаар төлсөн даатгуулагч ердийн өвчин, ахуйн ослын улмаас нас барвал түүний оршуулгад зориулан оршуулгын тэтгэмж олгоно.

2. Даатгуулагч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас нас барсан бол оршуулгын тэтгэмжийг шимтгэл төлсөн хугацааг харгалзахгүйгээр олгоно.
3. Нийгмийн даатгалын тухай хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж авч байсан иргэн нас барвал, түүний оршуулгад зориулан оршуулгын тэтгэмж олгоно.



Хувийн амьдрал гэдэгт гэр бүл маань хамаарах уу?



Хамаарна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хувийн нууцыг зөрчихтэй нэгэн адилаар гэр бүл, орон байраа хүндлүүлэх эрхийн зөрчил их байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүн хэнтэй хаана амьдрахаа өөрөө бие даан шийдэх эрхтэй. Үүнтэй адил хүчээр үргүй болгох нь хөгжлийн бэрхшээлтэй хүний хүүхэдтэй байх эрхийг зөрчсөн хүчирхийлэл, доромжлолын нэг хэлбэр.



Хүүхэд байхаас нь ч юм уу, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бэлгийн хөгжил, харилцаа, гэр бүл төлөвлөлт, хүний эрхийн талаар мэдээллийг хүртээмжтэй өгсөн бол эрүүл мэндийн доройтол, үргүйдэл зэрэгт хүрэхгүй байсан ч байж болох



Тийм ээ. Хүний эрх хоорондоо салшгүй, уялдаатай, холбоо хамааралтай. Тиймээс л эрхийг бүрэн дүүрэн цогцоор нь хангах ёстой гээд байдаг.

Мөн л хөгжлийн бэрхшээлтэй хүнийг дурлаж, хайрлах, хувийн харилцаа тогтоох, гэрлэх, үр хүүхэдтэй болж хариуцлага хүлээх чадваргүй, бусдад хохирол учруулна гэж боддог хүмүүс хөгжлийн бэрхшээлээ хүүхдэд удамшуулна, хүүхдээ асарч өсгөж чадахгүй гэдэгтээ итгэсэн байдаг. Ийм хандлага нь хөгжлийн бэрхшээлтэй охид, хүүхэд, насанд хүрэгчдийг хүчээр үргүй болгох, хүүхэд төрүүлэхгүй байхыг зөвлөн ухуулах, гэрлэхийг хориглох, гэр бүлтэй нь амьдруулахгүй байх, хөгжлийн бэрхшээлтэй эцэг эхээс нь хүүхдийг салгах гэж шахалт үзүүлэн хүчирхийлэл, доромжлолын байдлаар илэрдэг.



МЭДЭЭЛЭЛ

Гэрлэлт гэж юу вэ?

Гэрлэлт гэж 18 нас хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёр, сайн дурын, чөлөөтэй, тэгш эрхийн үндсэн дээр гэр бүл болох зорилгоор төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэхийг хэлнэ. Эхнэр нөхөр хоёр тэгш эрх⁵⁸ эдэлж, адил үүрэг⁵⁹ хүлээнэ. Өмнөх гэрлэлт хүчинтэй байгаа, төрөл, садан,

харгалзан дэмжигч, дэмжүүлэгч, үрчлэгч, үрчлүүлэгч хоёр хоорондоо болон гэрлэгчдийн хэн нэг нь, эсхүл хоёулаа удамших хандлагатай сэтгэцийн архаг өвчтэй бол гэрлэхэд харшлах шалтгаан гэж үздэг.

Олон улсын эрх зүйд хөгжлийн бэрхшээлтэй хүн нь хүүхдийн тоо, хүүхэд төрүүлэх хоорондын зайг чөлөөтэй шийдвэрлэх, хариуцах эрхтэй бөгөөд насныхаа онцлогт тохирсон мэдээлэл, нөхөн үржихүй, гэр бүл төлөвлөлтийн боловсрол эзэмшиж, эдгээр эрхээ эдлэхэд нь шаардлагатай нөхцөл бололцоо болон үр удмаа үлдээх тэгш боломжоор хангагдах эрхийг нь хангасан байдаг.

Гэрлэгчид болон нэг гэрт цугтаа амьдарч байгаа хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд болон төрөл, садангийн хүнийг гэр бүлийн гишүүн гэх бөгөөд энэ бүх хүмүүс нэгнээ асран хамгаалах, харгалзан дэмжих үүргийг хуулинд заасан байдаг. Асран халамжлуулж байгаа хэн бүхэн бусадтай адил эрх эдэлнэ. Тухайлбал хөдөлмөрийн чадвартай хүүхэд нь төрүүлсэн, үрчлэн авсан хөдөлмөрийн чадваргүй эцэг, эх, хойт эцэг, хойт эхээ тэжээн тэтгэх үүрэгтэй.

Гэрлэх, гэрлэлт дуусгавар болох, гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцох, гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус харилцаа, хүүхэд үрчлэх, гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэх, тэжээн тэтгэх, асран хамгаалах, харгалзан дэмжихэд хэн ямар эрх, үүрэг хүлээхийг хуульчилсан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн хүүхэд үрчлэх, төрүүлж болдог болов уу? Энэ талаар Номинтой уулзаж тодруулъя.

58. Монгол улсын хууль, Гэр бүлийн тухай, 10 дугаар зүйл, 10.2 дахь заалт

59. Монгол улсын хууль, Гэр бүлийн тухай, 10 дугаар зүйл, 10.3 дахь заалт



Би хүүхэдтэй байж болох болов уу?



Хүн бүр үр удмаа үлдээх эрхтэй. Хөгжлийн бэрхшээлтэй хүн энэ эрхээ эдлэхэд шаардлагатай нөхцөл бололцоо болон үр удмаа үлдээх тэгш боломжоор хангагдах ёстой. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, хүмүүсийг хүчээр үргүй болгохыг хориглосон гэсэн үг. Ямар ч тохиолдолд эцэг эхийн аль нэг нь, эсвэл хоёулаа, эсхүл хүүхэд нь хөгжлийн бэрхшээлтэй гэх шалтгаанаар хүүхдийг эцэг эхээс нь тусгаарлаж болохгүй.



Хүүхэд үрчилж авах тухай заримдаа бодох юм, тийм боломж байдаг уу?



Үрчлэгч нь насанд хүрсэн, иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжтай, хүүхдийг тэжээн тэтгэж, өсгөн хүмүүжүүлэх зохих боломжтой хүн байна гэсэн нь өөрөө их асуудал дагуулж байгаа. Иргэний эрх зүйн бүрэн чадамж 18 нас хүрэхээр бий болдог ч хөгжлийн бэрхшээлтэй зарим хүмүүс хүүхэд үрчилж чадаагүйг би мэднэ. Сэтгэцийн өвчний улмаас өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй, өөрийгөө зөв удирдаж чадахгүй болсон этгээдийг шүүх иргэний эрх зүйн чадамжгүй гэж үзээд хүүхэд үрчлэхийг хориглосон.



Хүүхэд үрчилж авах бол хэнээс зөвшөөрөл авах вэ?



Эхнэрээс чинь гадна хүүхдээ үрчлүүлэх гэж байгаа эцэг, эх, 7 нас хүрсэн хүүхэд өөрөө зөвшөөрсөн байх ёстой. Хүүхдийн оршин суугаа сум, дүүргийн Засаг даргад хүүхэд үрчлэн авах тухай хүсэлтээ гаргана. Засаг дарга хүүхэд үрчлэн авах тухай хүсэлтийг хянан үзэж, үрчлүүлэх эсэх тухай шийдвэрийг 20 хоногт багтаан гаргана. Энэ шийдвэрийг үндэслэн иргэний гэр бүлийн бүртгэлийн ажилтан хүүхэд үрчилснийг бүртгэнэ. Үрчлэлтийн нууцыг албан тушаалтан хадгалах үүрэгтэй.

2.2. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ

Хөгжлийн бэрхшээлтэй хүн нэг талаас хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар нийгэмд уламжлагдан тогтсон жендэрийн хэвшмэл ойлголт, нөгөө талаас хөгжлийн бэрхшээлд нь төвлөрсөн нийгмийн сөрөг хандлагатай холбоотой ялгаварлан гадуурхалтад давхар өртдөг. Харин хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүд “Хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэсэн нэг цул ойлголтод хамаарч “эмэгтэй” гэж авч үзэхгүйгээс тэдний олон асуудал нь орхигдож давхар алагчлалд өртсөөр байна.

Эмэгтэй хүн учраас, хөгжлийн бэрхшээлтэй учраас гэх хандлагаар ажилд авахгүй, сургуульд явуулахгүй, гэрлэх, хүүхэд төрүүлэх, хүүхэд үрчилж авахыг нь хүлээн зөвшөөрөхгүйгээс хүчирхийлэл, доромжлолд өртөж сэтгэл зүй нь хямрах тохиолдол байдаг. Ийм сөрөг үйлдлийг нийгэм төдийгүй гэр бүлийн хүрээнд гаргасаар байна.



Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй надад зовлонгоо ярьж байсан. Хүүхдийг чинь авч явна шүү гэж гэрийнхэн нь байнга айлгадаг гэж байна билээ.



Гэр бүлийн хүрээнд сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн эмэгтэй бололтой.



Гэр бүлийнхэндээ хүчирхийлүүлж байна гэсэн үг үү?



Гэр бүлийнхнээс гадна гэр бүлийн харилцаатай байсан хүмүүс хүний сэтгэл санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодод халдсан үйлдэл, эс үйлдэхгүйг гэр бүлийн хүчирхийлэл гэдэг.

60. Монгол улсын хууль, Гэр бүлийн тухай, 57 дугаар зүйлийн 57.1 дэх заалт

61. Монгол улсын хууль, Иргэний хууль, 18-р зүйл, 18.2 дахь заалт



МЭДЭЭЛЭЛ

Гэр бүлийн хүчирхийлэл гэж юу вэ?

ГБХ-тэй тэмцэх тухай хуулийн үйлчлэлд хамаарах этгээдүүдийн нэг нь нөгөөдөө:

- Сэтгэл санааны дарамт учруулах
- Эдийн засгийн эрх чөлөө
- Бэлгийн эрх чөлөө
- Бие махбодод халдсан үйлдэл, эс үйлдэхүйг “Гэр бүлийн хүчирхийлэл” гэнэ.

ГБХ нь:

- эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүн, хамтран амьдрагч, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, тэдгээрийн асрамж, хамгаалалтад байгаа этгээд, тухайн гэр бүлд хамт амьдарч байгаа этгээд;
- Тусдаа амьдарч байгаа төрүүлсэн, үрчлэн авсан хүүхэд, төрсөн, үрчлэн авсан эцэг, эх, ах, эгч, дүү.
- Гэрлэлтээ цуцлуулсан эхнэр, нөхөр, хамтран амьдарч байсан, эсхүл хамтран амьдарч байгаагүй ч гэр бүлийн харилцаатай байсан, дундаасаа хүүхэдтэй этгээдийн хооронд үйлдэгддэг.

ГБХ-д хэн ч өртөж болно. ГБХ-ийн онцлог нь далд үйлдэгддэг, давтагддаг, даамжирдаг. Иймээс ГБХ-ийн хэлбэр, үйлдлийг таньж мэдэх, таслан зогсоох нь ирээдүйд учрах эрсдлээс өөрийгөө болон бусдыг хамгаалж буй арга юм.

ГБХ нь ЖСХ-ийн нэг хэлбэр бөгөөд дараах 4 хэлбэртэй байна. Үүнд:

- **Бие махбодын хүчирхийлэл:** хүний амь нас, эрүүл мэндэд гэм хор учруулсан, эсхүл учруулж болзошгүй аливаа үйлдэл, эс үйлдэхүйг бие махбодын хүчирхийлэл гэнэ. Хөгжлийн бэрхшээлтэй охид эмэгтэйчүүдийг хүчиндэх⁶², асаргаа үзүүлэхдээ хатуу ширүүн эсвэл тохиромжгүй байдлаар хүрэх, хувийн болон эрүүл мэндийн асаргаа сувилгааг тохиромжтой байдлаар үзүүлэхгүй байх, хөдөлгөөн хорих хэрэгслийг хэтрүүлэн ашиглах, зан үйлийг нь засаж залруулах зорилгоор зохисгүй үйлдэл хийх, хэт их эм уулгах, хорих зэрэг хэлбэрээр илэрнэ.

- **Сэтгэл санааны хүчирхийлэл:** хүний хүсэл зоригийн эсрэг тодорхой үйлдэл хийх, эсхүл хийхгүй байхыг албадах, үл хайхрах, гүтгэх, мөрдөн мөшгөх, заналхийлэх, бусадтай харилцахыг хязгаарлах, гутаан доромжлох болон бусад хэлбэрээр сэтгэл санааны шаналал үүсгэснийг сэтгэл санааны хүчирхийлэл гэнэ. Хөгжлийн бэрхшээлтэй охид эмэгтэйчүүдийг хэл амаар доромжлох, айлгах, ичээх, нийгмээс тусгаарлах, сэтгэл зүйн хүнд байдалд оруулах, гаргасан шийдвэрийг нь няцаах тухайлбал хүүхдийг нь авч явна гэж сүрдүүлэх зэрэг хэлбэрээр илэрнэ.
- **Эдийн засгийн хүчирхийлэл:** хүний цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах орлого, хуваарьт болон дундын эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдах, орлого олох боломжийг нь хязгаарлах, шаардлагатай хэрэгцээг нь хясан боогдуулах, тэжээн тэтгэхээс зайлсхийх болон бусад хэлбэрээр эдийн засгийн хараат байдалд оруулсан, эсхүл эд хөрөнгийн хохирол учруулсныг эдийн засгийн хүчирхийлэл гэнэ. Хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдийг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн зохистой орон байр, орчин, цэвэр ус, хүнс хоол, ахуйн хэрэгслээр хангахгүй байх зэрэг хэлбэрээр илэрнэ. Охид эмэгтэйчүүдэд анхаарал тавихгүй, тухайлбал хоол өгөхгүй байх, хувийн болон эрүүл мэндийн асаргаа сувилгаа огт үзүүлэхгүй юмуу, шаардлагатай хэмжээнд үзүүлэхгүй байх зэрэг
- **Бэлгийн хүчирхийлэл:** эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан хүнийг бэлгийн шинжтэй аливаа үйлдэлд албадахыг бэлгийн хүчирхийлэл гэнэ. Хөгжлийн бэрхшээлтэй охид эмэгтэйчүүдийн бэлгийн хэрэгцээг үгүйсгэх, жирэмслэлтээс хамгаалах, хүүхэд төрүүлэх зэрэг бэлгийн амьдралын талаар мэдлэг ойлголт өгөхгүй байх, хэл амаар доромжлох, хүсэхгүй байхад бэлгийн сэдлээр биед нь хүрэх, хүчиндэх, хүчээр үр хөндүүлэх, үргүй болгох зэрэг хэлбэрээр илэрнэ.


Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн, эсхүл үйлдэгдэж болзошгүй нөхцөл байдлын талаарх дуудлага, мэдээллийг ойр байгаа цагдаа, баг, сумын Засаг даргад амаар, бичгээр, утсаар, цахим хэлбэрээр ХЭН ч, ХЭЗЭЭ ч өгч болно.

Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, гэмт хэрэгт өртсөн хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд үзүүлэх эрүүл мэнд, хууль зүйн, сэтгэл зүйн болон бусад шаардлагатай үйлчилгээг тэдгээрийн сэтгэл зүй, нас бие, сэтгэхүйн онцлогт нийцүүлэн мэргэжлийн түвшинд чанартай үзүүлэх⁶³ ёстой.

Хүчирхийлэлд өртсөн нь таны буруу биш, хүн бүр хүчирхийллээс ангид байх эрхтэй.

1. Яаралтай үед холбоо барих байгууллагуудын утасны дугаар

{ Та хүчирхийлэлд өртсөн, өртөх эрсдэлтэй нөхцөлд дараах утсанд хандана уу. Таны өгсөн дуудлага, мэдээллийг үнэ төлбөргүй, харьяалал харгалзахгүй, 24 цагийн турш хүлээж авна. }



2. ГБХ/ЖСХ-ийн талаарх дуудлага мэдээлэл өгөх хэлбэрүүд

- Бичгээр,
- биечлэн,
- утсаар,
- мессежээр,
- цахимаар,
- цагдаагийн байгууллагад,
- дүүрэг, хороо, багийн засаг даргад



63. Монгол улсын хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, 29-р зүйлийн 29.1.3 дахь заалт

3. Эрүүл мэнд, амь насанд аюултай үед яаралтай хандах, холбоо барих газрууд

Оршин сууж буй сум/дүүрэг, баг/хорооны хамтарсан баг, нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байранд хандаарай. Төрөл садангийн хамгаалалтад ороорой. Тухайлбал, Гэмтэл согог судлалын үндэсний төвийн дэргэдэх Нэг цэгийн үйлчилгээ: **70180139**,

Шүүх эмнэлэгийн дэргэдэх Нэг цэгийн үйлчилгээ: **70113408**

102, 107, 108 тусгай дугаарын утсанд өгсөн таны дуудлага, мэдээллийг нууцлана. Нууцлалыг задруулсан этгээдэд хуулийн хариуцлага хүлээлгэнэ. Таныг хуулийн⁶⁴ дагуу хамгаалалтад авна. Та эсэн мэнд амьдрах, хамгаалуулах эрхтэй⁶⁵.



Зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй гэлтгүй эрэгтэй хүн гэр бүлийн хүчирхийллийн хохирогч болвол ямар тусламж, үйлчилгээ авдаг вэ?



Мэдээж хүчирхийлэлд эмэгтэйчүүдээс гадна хүүхэд, эрэгтэй хүн ч өртөнө. Хэн ч байсан гэр бүлийн хүчирхийллийн хохирогч болсон бол Түр хамгаалах байранд байрлуулж, аюулгүй байдлын хамгаалалт, эмнэлгийн тусламж, үйлчилгээ, сэтгэл зүйн үйлчилгээ, нийгмийн халамжийн үйлчилгээ, хүүхэд хамгааллын үйлчилгээ, эрх зүйн туслалцаа, холбон зуучлах үйлчилгээг авдаг. Ингэхдээ хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй болон сэтгэцийн эмгэгтэй хүн, жирэмсэн эмэгтэй, ахмад настны хэрэгцээ, шаардлагыг харгалзаж монгол хэл, бичиг мэдэхгүй, эсхүл хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй бол орчуулагч, хэлмэрчийн тусламж авах эрхээр хангана.



Тэр үед намайг, эсвэл миний хүүхдийг нөгөө хүчирхийлэл үйлдэгчтэй нүүрэлдүүлэх байх даа? Яаж дахиж тийм аймар юм хийсэн хүнтэй уулзах юм бэ? Аймаар санагдаж байна.



Ер нь өөрөө уулзахыг хүсэхгүй байгаа бол уулзуулахыг хуулиар хориглосон. Мөн сэтгэл санааны хямрал, айдастай байгаа бол, бэлгийн хүчирхийллийн хохирогч бол, хохирогч болон хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд харшлахаар бол уулзуулдаггүй.



МЭДЭЭЛЭЛ

Хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдод туслах хамгийн үр дүнтэй аргуудын нэг бол нөөцийг илүү хүртээмжтэй болгох, оролцоог тэгш хангах явдал юм. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй хохирогчтой нүүр тулж ажиллах ажилтнуудыг тусгайлан сургах талаар орон нутгийн түр хамгаалах байр, шууд утсыг ажиллуулдаг албанд дэмжлэг үзүүлэх,
- Түр хамгаалах байр, нийгмийн үйлчилгээ үзүүлдэг байгууллага, эмнэлгүүдэд тухайн орон нутагт гэр бүлийн хүчирхийлэл ба хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чиглэлээр мэргэшсэн байгууллагуудын жагсаалтыг гаргахыг санал болгох,
- Орон нутгийн эрүүл мэндийн мэргэжилтнүүд, эмнэлгийн ажилтнууд хөгжлийн бэрхшээлтэй өвчтөнүүдийг гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эсэхийг шалгаж, тогтоож байгаа байдалд анхаарч нягтлах,
- Гэр бүлийн хүчирхийллийн шинж тэмдгийг таньж, зохих хариу арга хэмжээ хэрхэн авах талаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд туслалцаа үзүүлдэг нийгмийн үйлчилгээний байгууллагуудын ажилтнуудад сургалт явуулж тэдний мэдлэг боловсролыг дээшлүүлэх,
- Нийгмийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд, эмнэлгүүд, сүм хийд болон бусад байгууллагыг хөгжлийн бэрхшээлтэй (хараагүй, сонсголгүй, хөдөлгөөний хомсдолтой, сэтгэцийн өвчтэй болон бусад төрлийн хөгжлийн ялгаатай онцлогтой хүмүүс) иргэдэд чиглэсэн гэр бүлийн хүчирхийлэлд өртвөл хэрхэх, ямар тусламж дэмжлэг авах, хэнд хандах зэрэг мэдээ мэдээлэлтэй багцыг бэлэн байлгах, нүдэнд ил, үзүүлэн маягаар байрлуулахыг санал болгох юм.

<https://ncadv.org/blog/posts/domestic-violence-and-people-with-disabilities>



МЭДЭЭЛЭЛ

Хамтарсан баг гэж юу вэ?



“Хамтарсан баг” гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдэд үйлчилгээ үзүүлэх анхдагч нэгж юм.

Хамтарсан баг нь өрхийн эмч, сум, хороо, сургуулийн, халамжийн, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн нийгмийн ажилтан, цагдаагийн алба

хаагч, энэ чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдэх бөгөөд хамтарсан багийг тухайн сум, хорооны Засаг дарга ахална.

Хамтарсан баг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Нөхцөл байдлын үнэлгээг үндэслэн хохирогчид үзүүлэх үйлчилгээг төлөвлөж, хэрэгжүүлнэ.
- Хохирогчийг хамгаалах, нөхөн сэргээх, нийгмийн халамж, үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай бусад үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулна.

Иймд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн бол та өөрт шаардлагатай тусламж, үйлчилгээг хамтарсан багийн аль ч гишүүнд, ямар ч хэлбэрээр хандан авч болно.

Түр хамгаалах байр гэж юу вэ?



Хохирогчийг насанд хүрсэн гэрч, хохирогчийг өөрийнх нь зөвшөөрснөөр, насанд хүрээгүй гэрч, хохирогчийг түүний эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсхүл хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагын зөвшөөрснөөр аюулгүй байдал

хангагдсан газарт бодит аюул, заналхийлэл арилах хүртэл хугацаанд түр байрлуулна.

Түр хамгаалах байранд хүчирхийлэл үйлдэгч нэвтрэх, аливаа хэлбэрээр хохирогчтой холбоо тогтоохоор оролдох, хохирогчид айдас, түгшүүр үүсгэх бусад үйлдэл хийх болон түр хамгаалах байрны хэвийн үйл ажиллагаанд саад учруулахыг хориглоно.

Түр хамгаалах байрны байршлын талаар мэдсэн хүн энэ тухай бусдад задруулахгүй байх үүрэгтэй.

Нэг цэгийн үйлчилгээ гэж юу вэ?



Нэгцэгийн үйлчилгээний төв нь холбогдох хуулиар үүрэг хүлээсэн байгууллага, мэргэжилтнүүдтэй хамтран хохирогчид нутаг дэвсгэрийн харьяалал харгалзахгүй 24 цагийн турш нэг цэгээс шуурхай, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлнэ.

ГБХ-ийн хохирогчид үзүүлэх үйлчилгээ дараах төрөлтэй байна:

- Аюулгүй байдлын хамгаалалт;
- Эмнэлгийн тусламж, үйлчилгээ;
- Сэтгэл зүйн үйлчилгээ;
- Нийгмийн халамжийн үйлчилгээ;
- Хүүхэд хамгааллын үйлчилгээ;
- Эрх зүйн туслалцаа;
- Холбон зуучлах үйлчилгээ;

“WHAT3WORDS”, “3 ҮГТ ХАЯГ”-ИЙГ ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ, ХҮҮХДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЛИЙН ТАЛААР ДУУДЛАГА, МЭДЭЭЛЭЛ ӨГӨХӨД АШИГЛАЖ БОЛНО.



Уг хаяг нь байршлыг тайлбарлах хамгийн энгийн арга. Монгол улсын бүх газар нутаг 3 үгт хаягтай болсноор одоо хүн бүр хүссэн газраа хялбархан олох боломжтой боллоо. Хэрхэн 3 үгт хаягаа олох вэ? Манай газрын зургийг ашиглан 3 үгт хаягаа олж болно. Find your 3 word address

Цагдаагийн байгууллагад гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар дуудлага, мэдээлэл өгөхөд өөрийн байгаа газрын хаягаа мэдэхгүй бол “what3words” буюу гурван үгт хаягийг ашиглаж болно. Харин хэрхэн ашиглах вэ?

Хэрэв та 102 тусгай дугаарт дуудлага, мэдээлэл өгөх үед байгаа газрын байршлаа мэдэхгүй бол бид тухайн иргэний утасны дугаар руу зурвасаар холбоос явуулна. Холбоос дээр дарахад 3 үг гарч ирнэ, гарч ирсэн 3 үгийг мэдээлэл хүлээн авагчид хэлэхэд системийг ашиглан

таны байршлыг тогтоож, танд хамгийн богино хугацаанд тусламж үзүүлнэ.

Иргэд холбоос явуулахад утас нь интернэттэй байх шаардлагатай бөгөөд харин 3 үгт хаягийн аппликейшн татсан бол дата шаардахгүй юм. Үүнийг гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хөдөө, орон нутаг, хаяг нь ойлгомжгүй замбараагүй гэх мэт бүх л газарт ашиглах боломжтой.

ГБХ-ЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТАСЛАН ЗОГСООХ ЗОРИЛГООР ТА ДАРААХ АРГУУДЫГ ХЭРЭГЛЭЖ, ТУРШИЖ ҮЗЭЭРЭЙ.

Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох хөндлөнгөөс нөлөөлөх 4 арга байдаг. Эдгээр аргуудыг хэрэгжүүлэхээсээ өмнө та “хөндлөнгөөс нөлөөлөгч” болох эсэхээ шийдээрэй. Хэрвээ хөндлөнгийн нөлөөлөгч болохоор шийдсэн бол дараах 3 алхмыг өөртөө хэрэгжүүлээрэй.

1. Хүчирхийллийн шинжтэй зан байдал, үйлдлийг таньж, оролцох эсэхээ шийдэх
2. Хариу үзүүлж, нөлөөлөх, аюулгүй, итгэлтэй аргуудыг мэдэж авах
3. Юу болсон талаар эргэцүүлж өөртөө тайвшрах боломж, цаг гаргах

Хөндлөнгөөс нөлөөлөх I арга буюу саатуулах арга. Хүчирхийлэл үйлдэгчийн анхаарлыг сарниулж, сэдвийг өөрчлөх зорилготой.

- Анхаарлыг болж байгаа үйл явдлаас шууд бус аргаар сарниулах
- Төөрсөн болж ямар нэг газар асуух, цаг асуух, АТМ асуух
- Дундуур нь санаадгүй орох
- Хохирогчийг таньдаг мэт жүжиглэж хүчирхийлэгчээс холдуулах
- Үймээн буужигнаан үүсгэх
- “Санамсаргүй” юм унагах, түлхэх
- Хоолой засах

Хөндлөнгөөс нөлөөлөх II арга буюу томилох арга. Ойр хавьд байгаа хүнээс тусламж эрэх зорилготой.

- Ойролцоо байгаа хүнийг дуудаж тусламж хүсэх, боломжтой бол тухайн нөхцөлд эрх мэдэл бүхий хүнээс тусламж эрэхийг хичээх,
- Хамгаалалтын ажилтан
- Баг/хорооны засаг дарга
- Автобусны жолооч
- Эмнэлгийн ажилтан
- Цагдаа (Нэн шаардлагатай бөгөөд шууд аюулд орсон бол дуудна)

Хөндлөнгөөс нөлөөлөх III арга буюу шууд оролцох арга. Дарамталж байгаа хүнтэй шууд тулах зорилготой.

Хүчирхийлэгчтэй хэрхэн тулах вэ?

- Чанга дуугаар дуудах, болихыг хүсэх
- Тэдэнд хийж байгаа, хэлж байгаа зүйл нь буруу гэдгийг ойлгуулахыг хичээх
- Яагаад гэдгийг тайлбарлах, хэрүүл маргаан үүсгэхгүй байхыг анхаарах
- Хохирогчийг орхихыг, өөр зүйлийн талаар шоглоом хийж ярих, эсвэл өөр тийшээ явахыг хүсэх
- Тэдэнд хүндэтгэлтэй хандах, эргээд өөрт тань хүндэтгэлгүй хандвал оролцохгүй байх

Ямар үед шууд оролцох вэ?

Бусад аргуудыг хэрэглээд амжилтгүй болсон үед хүчирхийлэл даамжрахаас сэргийлэх зорилгоор ашиглаж болно. Гэхдээ аюулгүй байдал хамгийн чухал бөгөөд нэгдүгээрт тавигдана.

Хохирогч байхгүй үед, хүчирхийлэгчийг таньдаг бол ашиглах нь илүү тохиромжтой бөгөөд аюулгүй байдаг.

Хөндлөнгөөс нөлөөлөх IV арга буюу шалгах арга. Хохирогчийг зүгээр эсэхийг шалгах зорилготой.

- Хохирогчийг зүгээр эсэхийг шалгах
- Одоо зүгээр, аюулгүй байгаа эсэхийг нь асуух.
- Түүнд тусламж хэрэгтэй эсэхийг асуух, холбогдох үйлчилгээнд чиглүүлж/хүргэж өгөх.
- Болсон явдал зүгээр нэг асуудал биш, мөн түүний буруу биш гэдгийг хэлж, ойлгуулах.
- Анхаарлыг өөр дээрээ биш хохирогчид хандуулах

ХОЛБОГДОХ УТАСНЫ ДУГААРУУД:



ГБХ-ийн зөвлөгөө



Хүүхэд хамгаалал



Цагдаа (шууд аюулд орсон үед)



Эмнэлгийн түргэн тусламж

ХАВСРАЛТ 1.

Хүснэгт 1. Дархлаажуулалтын үндэсний товлал

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 185 дугаар тогтоол

ЗААВАЛ ХИЙХ ДАРХЛААЖУУЛАЛТЫН ҮНДЭСНИЙ ТОВЛОЛ

Вакцины нэр	Товлол	Төрсний дараа 24 цагийн дотор	2 сартайд	3 сартайд	4 сартайд	9 сартайд	2 настайд	7 настайд	15 настайд
СҮРЬЕЗ (БЦЖ)	I тун								
В ГЕПАТИТ	I тун								
ХАЛДВАРТ САА	I тун	II тун	III тун	IV тун					
ТАВТ (САХУУ, ХӨХҮҮЛ ХАНИАД, ТАТРАН + В ГЕПАТИТ + ХЕМОФИЛУС ИНФЛЮЕНЗА В)		I тун	II тун	III тун					
УЛААНБУРХАН, ГАХАЙ ХАВДАР, УЛААНУУД (УГУ)					I тун	II тун			
САХУУ, ТАТРАН							I тун	II тун	







МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2009 ОНЫ 185 ДУГААР ТОГТООЛ



World Health Organization
Western Pacific Region



ХӨСҮТ-ийн лаалах утас
451798

IMMUNIZATION SCHEDULE

Schedule	Birth dose within the 24 hours	2 months	3 months	4 months	9 months	2 years	7 years	15 years
BCG	I dose							
Hepatitis B (HepB)	I dose							
Polio (OPV)	I dose	II dose	III dose	IV dose				
Pentavalent (DTP+HepB+Hib)		I dose	II dose	III dose				
Measles Mumps Rubella (MMR)					I dose	II dose		
Diphtheria Tetanus (DT)							I dose	II dose

Бүдүүвч 1. Хөгжлийн дэмжлэг, эрт оролцооны үйлчилгээнд хамруулах үйл явц

1. Гэр бүл, хамт олны түвшинд хүүхдийн хөгжлийг хянах

Эрүүл мэндийн байгууллага нь ягаан дэвтэр буюу Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийг жирэмсэн эхчүүдэд олгохдоо хэрхэн ашиглах талаарх мэдлэг олгох ба жирэмсэн эхчүүдийн сургалтын хөтөлбөрт тусгана. Ялангуяа эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн хөх зурвастай хуудас дахь хүүхдийн насанд тохирсон хөгжлийн үе шатны асуумжийг эцэг, эхээр тэмдэглүүлж сургана.

2. Хөгжлийн хоцрогдол бэрхшээлийн эрт илрүүлэлтийн үзлэг /Хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг

Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв нь хүүхэд бүрийг 9, 18, 36 сартай эрүүл мэнд, хөгжлийн эрт илрүүлэлтийн үзлэгт хамруулна. Үзлэгээр хөгжлийн аливаа хоцрогдол, бэрхшээлтэй байж болзошгүй хүүхдийг лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад илгээнэ.

3. Үнэлгээ, онош магадлах

Хүүхдэд тусламж, үйлчилгээ үзүүлдэг. Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага (Аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн Эрүүл мэндийн төв, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Гэмтэл согог судлалын үндэсний төв гэх мэт)-ын Төрөлжсөн мэргэжлийн баг үнэлгээ/оношилгоо хийж дүгнэлт гарган, Салбар комисст илгээнэ.

4. Хөгжлийн бэрхшээлтэй эсхийг тогтоох, хөгжлийн дэмдлэгийн төлөвлөгөө боловсруулах

Салбар комисс нь хүүхдийг хөгжлийн бэрхшээлтэй эсхийг тогтоож, хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөө боловсруулан шийдвэр гаргана. Ингэхдээ:

1. Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулах;
2. Хөгжлийн дэмжлэг, оролцооны үйлчилгээнд хамруулах заавар өгч шийдвэр гаргах;
3. Хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөө боловсруулж, уг хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөөнд тусгагдсан эмчилгээ-Сэргээн засах, боловсролын үйлчилгээнд хамруулахын тулд хүүхэд, эцэг, эхчүүдийг холбогдох байгууллагатай холбон зуучлах үүрэгтэй.

Эрт үеийн хөгжлийн дэмжлэг, оролцооны үйлчилгээ/хөтөлбөр: Кейс хэлэлцүүлэг, Портеж, Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр, хүүхэд хөгжлийн төвүүд, өдөр өнжүүлэх, хүүхэд харах үйлчилгээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв гэх мэт.

Сургуулийн өмнөх боловсрол, Ерөнхий боловсролын сургууль: ердийн болон тусгай сургууль цэцэрлэг


Нийгмийн хамгаалал: халамж тэтгэмж, асаргаа, туслах хэрэгсэл.

Эмчилгээ / сэргээн засах: хөдөлгөөн засал, хөдөлмөр засал, хэл засал гэх мэт

Хүснэгт 2. Хүүхдийг дараах насанд нэгдсэн үзлэг, шинжилгээнд хамруулна.

9 сартай хүүхэд	Хүүхэд бусдын дэмжлэггүйгээр сууж, суганаас нь дэмжиж барихад зогсох чадвартай болсон байна. Мөлхөж, тоглохдоо илүү идэвхтэй болж, хөгжмийн аяыг дагаж хөдлөх, юмыг эрж хайх, авах гэж оролдох, чадвартай болдог тул хөдөлгөөн, танин мэдэхүйн хоцрогдлыг энэ үед илрүүлж чадвал хөгжлийн дэмжлэгийг илүү эрт үзүүлэх боломж бүрдэнэ.
18 сартай хүүхэд	Харилцаа, хэл яриа, хөдөлгөөний хоцрогдол 18 сартайд илт мэдэгдэнэ. Энэ үед хөдөлгөөний хоцрогдол бэрхшээлийг сэргээн засах, хэл ярианы хөгжлийн дэмжлэг үзүүлэхэд үр дүнтэй байна.
36 сартай хүүхэд	Энэ насанд хүүхдийн хөдөлгөөн, хэл яриа, танин мэдэхүйн хөгжлийн үзүүлэлтүүдийг хэмжих хялбар байдаг. Эцэг эхэд хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр дэх тухайн насны асуумжийг заавал хариулахыг зөвлөнө. Хэрэв хүүхдэд хөгжлийн хоцрогдол илэрвэл хөгжлийн дэмжлэг, оролцооны үйлчилгээнд даруй хамруулна.

Бүдүүвч 2. Биеийн үйлдэл, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангиллын ерөнхий зарчмын дагуу үнэлэх жишээ



Хүснэгт 3. Хөгжлийн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөөний жишээ

Хүүхдийн нэр	Амар	Хүүхдийн хүсэж байгаа зүйл	Тодорхойгүй
Нас	4	Эцэг эхийн хүсэж байгаа зүйл	Цэцэрлэгт нь үргэлжлүүлэн явуулах, Нийгэмд өөрийгөө авч явж чаддаг болгон өсгөх.
Хүйс	Охин		

1 жилийн дараах зорилт		Цэцэрлэгт нь үргэлжлүүлэн явуулах			
	Жилийн дараах зорилтдоо хүрэх тулгамдсан асуудал, хэрэгцээ шаардлага (Оролцоо болон орчинд нөлөөлөхөд анхаарах)	Дэмжлэг зорилт	Хүрэх хугацаа	Дэмжлэгийн агуулга (Давтамж, цаг)	Хариуцах байгууллага/хүн
1	Халамж авдаггүй.	Халамж авдаг болгох.	2021.12	- Ээжид нь халамж авахтай холбоотой мэдээлэл өгөх - Хүсэлт бичих аргыг нь тайлбарлаж өгөх - Шаардлагатай бол хүсэлт гаргахад нь цуг явах.	ХХҮГ-ын мэргэжилтэн
2	Ээжид нь ярьж зөвлөх хүн байхгүй	Ээжийг санаа зовох зүйлгүйгээр ярьж зөвлөх хүнтэй болгох	2021.12	- Ээжид нь аутизмын холбоо, ХБХЭЭХ-ны салбар зөвлөлийг танилцуулах. - Аутизмын холбоо ээжид нь аутизмын талаар тайлбарлах, зөвлөгөө өгөх - ХБХЭЭХ-ны салбар зөвлөлийг аймгийнхаа ХБХ-үүдийн эцэг эх, асран хамгаалагчидтай харилцах боломжийг бий болгох өгөх.	ХХҮГ-ын мэргэжилтэн Аутизмын холбоо ХБХЭЭХ-ны салбар зөвлөл
3	Аавынх нь хамаатан "Хүүхдээ буруу өсгөсөн" гэж ээжийг нь буруутгадаг	Хүүхдээ өсгөхөд аавынх нь оролцоог нэмэгдүүлэх.	2022.05	- Аавд нь нөхцөл байдлыг тайлбарлан, сард нэг удаа аавыг нь байлцуулан ярилцдаг болох - Аавыг нь хөгжлийн бэрхшээлийн тухай сургалтад суулгах тал дээр анхаарах - Ааваас нь хамаатандаа талбайрлахыг хүсэх	Хорооны нийгмийн ажилтан

ХАВСРАЛТ 2.

Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй холбоотой зурагт хуудас

Хүүхэд ГБХ-д өртөж байгаа эсэхийг хэн мэдээлэх үүрэгтэй вэ?

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл гэж юу вэ?

Ямар байдлаар биед хүрч болох, ямар байдлаар биед хүрч болохгүй вэ?





Байгууллага, холбогдох утасны дугаартай зурагт хуудас

- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 10 онцлох зүйл
- Хэн нэгнийг ГБХ-д өртсөн гэж сэжиглэсэн тохиолдолд та юу хийх вэ?
- ГБХ-ийн хохирогчид сэтгэл зүйн анхан шатны тусламж өгөх байгууллагууд, утасны дугаар
- Аймаг, нийслэлийн ГБХЗХГ, утасны дугаар
- Орон нутгийн нэг цэгийн үйлчилгээний төвүүд, утасны дугаар
- Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах нэг цэгийн үйлчилгээний төвүүдийн мэдээлэл
- Нэг цэгийн үйлчилгээний талаарх мэдээлэл

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ОНЦЛОХ 10 ЗҮЙЛ

УИХ-аас баталсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль 2017 оны 2-р сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Тус хуулийн онцлох 10 зүйлийг танилцуулж байна.

Нэг: Гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэгт тооцох болсон.

- 1-6 сар хүртэл баривчлах,
- эсвэл 2 жил хүртэл хугацаагаар хорих

Хоёр: Хохирогчийг хамгаалах үйлчилгээг нэг дороос үзүүлэх хамтарсан баг бүрдсэн.

- Энэхүү багийг сум, хорооны Засаг дарга ахална.
- Өрхийн эмч, сум хорооны нийгмийн ажилтан, сургуулийн нийгмийн ажилтан, Халамж, гэр бүлийн хөгжлийн нийгмийн ажилтан, цагдаагийн алба хаагч, ТББ-ын төлөөлөл 24 цагийн турш нутаг дэвсгэрийн харьяалал харгалзахгүй үйл ажиллагаа явуулна.

Гурав: Гэр бүлийн хүчирхийллийн талаар мэдээлээгүй иргэнд Зөрчлийн хуулиар хариуцлага хүлээлгэнэ.

Дөрөв: Зөрчил ба гэмт хэргийг заагласан.

Зөрчилд: зодох, хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, мөрдөн мөшгөх, заналхийлэх, бусадтай харьцахыг хязгаарлах, гутаан доромжлох, өмчийн эрхэнд халдах.

Гэмт хэрэгт: Байнга зодох, харгис хэрцгий хандах, догшин авирлах, тарчлаах

Тав: Хэрэг шалгах явцад хүчирхийлэл үйлдэгчийн:

Тодорхой газарт очихыг хориглох, тодорхой хүнтэй харьцахыг хориглох, эд хөрөнгө захиран зарцуулах эрхийг түр хугацаагаар хязгаарлах зэрэг арга хэмжээ авна. Хохирогчтой эвлэрсэн гэсэн үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгохгүй!

Зургаа: Гэр бүлийн хүчирхийллийн талаар мэдээлэл авах албан тушаалтан байгууллагыг тодорхой заасан.

- Мэдээллийг утсаар, биеэр, факсаар, бичгээр мессежээр, цахимаар хүлээн авна.
- Харьяалал харгалзахгүй хамгийн ойр цагдаагийн байгууллагад мэдээлнэ.

- Цагдаагийн байгууллагын эзгүйд сум, хорооны Засаг даргад мэдээлнэ.

Долоо: Шаталсан, ялгамжтай хариуцлага хүлээлгэнэ.

Зөрчилд:

- 7-30 хоног баривчлах шийтгэл ногдуулна.
- Гэмт хэрэгт 2 жил хүртэл хугацаагаар хорих шийтгэл ногдуулна.

Найм: Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг тусгай хамгаалалтаар хангана.

- Цагдаагийн байгууллагын ажилтан аюулын зэргийн үнэлгээ хийнэ.
- Хэрэв аюулын зэрэг “хүнд”, “өндөр” бол эцэг эх, асран хамгаалагчийн саналыг харгалзахгүй түр хамгаалалтаар хангах арга хэмжээ авна.

Ес: Хохирогчид үзүүлэх үйлчилгээг төрөлжүүлсэн.

- Эмнэлгийн тусламж үйлчилгээ
- Нийгмийн халамжийн үйлчилгээ
- Хүүхэд хамгааллын үйлчилгээ
- Холбон зуучлах үйлчилгээ
- Аюулгүй байдлын хамгаалалт
- Сэтгэл зүйн үйлчилгээ
- Эрх зүйн туслалцаа

Арав: Цагдаагийн байгууллагын хүлээх үүрэг тодорхой болсон.

- Мэдээллийг хүлээн авч таслан зогсоох
- Орон байранд нэвтрэх, аюулгүй байдлыг шалгах
- Аюулын зэргийг үнэлэх
- Галт зэвсэг, зэвсгийн чанартай зүйлсийг хураах
- Хохирогчийг нэг цэгийн үйлчилгээний хамгаалах байранд хүргэж өгөх
- Гэрээс бичиг баримт, шаардлагатай зүйлсийг авахад туслах



Familycenter.mn
мэдээллийн сайт тун удахгүй

Хэн нэгнийг гэр бүлийн хүчирхийлэлд
өртсөн гэж сэжиглэсэн тохиолдолд

ТА ЮУ ХИЙХ ХЭРЭГТЭЙ ВЭ?

Шүүмжлэлгүйгээр
ойлгож дэмжиж
харивцах



Хохирогчийг буруутгаж
болохгүй бөгөөд эелдэг,
зөөлөн хандах.



Яриаг тасалдуулалгүй
аюулралтай
сонсох



Итгэлийг нь олж
чөлөөтэй тайван ярилцах
орчин бүрдүүлэх



Хэт хүчилж болохгүй,
хэрэв хүчирхийллийн тухай
ярихгүй байгаа тохиолдолд
тулган шаардах хэрэггүй

Хэрэв ярихаар
шийдэл хөлбоо барих
боломжтой шүү гэдгийг
хэлж, сануулан холбогдох
дугаараа өгөх



Хүчирхийллийн талаар ярьсан
тохиолдолд ямар үйлчилгээ
байгаа талаар мэдээлэл өгөх



Хэзээ ч
хохирогчийг
хүчилж
болохгүй



Хохирогчийн шийдвэрийг
хүндэтгэж түүний үйлдэлд
ямар, ямар үр дагавар гарч
болох талаар зөвлөх

Хөндлөнгийн гэрч та хэрэв хэн нэгэн
гэр бүлийн хүчирхийллийн хохирогч
байж болзошгүй хэмээн сэжиглэж
байгаа тохиолдолд холбогдох хүмүүст
мэдэгдэх хэрэгтэй. Үүнд: Хорооны
нийгмийн ажилтан, хороо багийн
засаг дарга, цагдаа зэрэг орно.



102, 107, 108 дугаарт залган
#МЭДЭЭЛЬЕ!




Canada



FAMILY CENTER
мэдээлэл, зөвлөгөө, тусламж

Сэтгэл зүйн анхан шатны тусламж өгөх байгууллагууд

Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар



Аймаг

Завхан аймаг	7046-2202
Орхон аймаг	7035-0136
Өвөрхангай аймаг	7032-3355
Өмнөговь аймаг	7053-2205
Сүхбаатар аймаг	9986-8464
Сэлэнгэ аймаг	7036-2269
Төв аймаг	7027-2484
Увс аймаг	7045-2424
Ховд аймаг	9434-6262
Хөвсгөл аймаг	8911-0122
Хэнтий аймаг	7056-3433

ГЭР БҮЛ ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР

Аймаг	Утас
Нийслэл	11 322418
Архангай	77332886
Баян-Өлгий	77422705
Баянхонгор	70444010
Булган	70343389
Говь-Алтай	94005300
Говьсүмбэр	94005300
Дархан-Уул	70370000, 70378737
Дорноговь	70522738
Дорнод	70584455, 70584150
Дундговь	70593971
Завхан	70462202, 70462339
Орхон	70350136
Өвөрхангай	70322227
Өмнөговь	70532105, 70532205
Сүхбаатар	70518979
Сэлэнгэ	70362269
Төв	70272484
Увс	70452424
Ховьд	70432017
Хөвсгөл	70382121
Хэнтий	70563533

ОРОН НУТГИЙН НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВҮҮД

Аймаг	Утас
Баян-Өлгий аймаг НЦҮТ	7042102, 94442902
Баянхонгор аймаг НЦҮТ	70442122
Говь-Алтай аймаг НЦҮТ	89829911
Дархан-Уул аймаг НЦҮТ	70378737
Дорнод аймаг НЦҮТ	70584455
Завхан аймаг НЦҮТ	80740740
Өвөрхангай аймаг НЦҮТ	70322108, 89323355
Хэнтий аймаг НЦҮТ	70563433
Хөвсгөл аймаг НЦҮТ	70382121
Өмнөговь аймаг НЦҮТ	70532005



FAMILY CENTER
мэдээлэл, зөвлөгөө, тусламж



ГЭР БҮЛИЙН БОЛОН БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ

НИЙСЛЭЛИЙН НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВҮҮД

Байгууллага	Утас
Гэмтэл Согог Судлалын Үндэсний төвийн НЦҮТ	70180139
СБД НЦҮТ	70116358
ШШҮХ НЦҮТ	93070949 <i>жижүүрийн утас</i>
ХУД НЦҮТ	88127821 88049073 89893773
БЗД НЦҮТ	70150183



Familycenter.mn
мэдээллийн сайт тун удахгүй ...

**ХҮЧИРХИЙЛЛИЙГ
102, 107, 108
ДУГААРТ МЭДЭЭЛЬЕ!**



**FAMILY CENTER**
мэдээлэл, зөвлөгөө, тусламж

Байна уу? Нэг цэгийн үйлчилгээний талаар мэдээлэл авах гэсэн юм.



102, 107, 108
мэдээллийн ажилтан



Сайн байна уу? Нэг цэгийн үйлчилгээ нь нутаг дэвсгэрийн харьяалал харгалзахгүй 24 цагийн турш

- Аюулгүй байдлын хамгаалалт
- Эмнэлгийн тусламж
- Сэтгэл зүй
- Нийгмийн халамж
- Хүүхэд хамгаалал
- Эрх зүйн туслалцаа олгох
- Холбон зуучлах зэрэг үйлчилгээг чиг үүрэг бүхий эмнэлэг, төрийн болон төрийн бус байгууллагын нэгжүүд нэг цэгээс үнэ төлбөргүй үзүүлдэг.

АШИГЛАСАН НОМ, ЭХ СУРВАЛЖ

Олон улсын эрхзүйн баримт бичгүүд:

1. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолт, 1946 он
2. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, 1976 он
3. НҮБ-ын конвенц, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, 2006 он
4. НҮБ-ын конвенц, Хүүхдийн эрхийн тухай, 1989 он.
5. НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хороо, Тэгш хамруулсан боловсрол эзэмших эрхийн талаарх 4-р Ерөнхий зөвлөмж, 2016 он
6. Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1946 он.

Хууль тогтоомжууд:

1. Монгол улсын хууль, Хөдөлмөрийн тухай, 2021 он
2. Монгол улсын хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, 2017 он
3. Монгол улсын хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, 2016 он
4. Монгол улсын хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, 2016 он
5. Монгол улсын хууль, Хүүхэд хамгааллын тухай, 2016 он
6. Монгол улсын хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай, 2013 он
7. Монгол улсын хууль, Нийгмийн халамжийн тухай, 2012 он
8. Монгол улсын хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай, 2011 он
9. Монгол улсын хууль, Иргэний хууль, 2002 он
10. Монгол улсын хууль, Дархлаажуулалтын тухай, 2000 он
11. Монгол улсын хууль, Автотээврийн тухай, 1999 он
12. Монгол улсын хууль, Гэр бүлийн тухай, 1999 он
13. Монгол улсын хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, 1994 он
14. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он

Ашигласан бусад эх сурвалжууд:

15. Бага насны хүүхдийн хөгжил, хөгжлийн бэрхшээл, асуудал дэвшүүлсэн тайлан Нээлттэй нийгэм форум, Улаанбаатар, 2015 он
16. “Бүх шатны сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирох хэрэглэгдэхүүн, сургалтын орчин бүрдүүлэх журам”, Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаал, 2020 он

17. “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар”, Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын тушаал, 2018 он
18. “Жирэмсэн эмэгтэйн үзлэг, шинжилгээний товлал”, Эрүүл мэндийн сайдын тушаал, 2020 он
19. “Жирэмсэн, төрөх, төрсний дараах үед үзүүлэх тусламж үйлчилгээний журам”, Эрүүл мэндийн сайдын тушаал, 2020 он
20. Насан туршийн боловсрол, Дээд боловсролын бодлогын өөрчлөлт, ШУТИС, 2017 он
21. “Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журам”, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал, 2021 он
22. “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх заавар”, ХНХ-ын сайд, БШУ-ны сайд, ЭМ-ийн сайдын хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралт, 2021 он
23. “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх аргачлал”, ХНХ-ын сайд, БШУ-ны сайд, ЭМ-ийн сайдын хамтарсан тушаал, 2021 он
24. Хүний эрхийн төлөө, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах үйл ажиллагаа, нөлөөлөл гарын авлага, Нээлттэй нийгэм форум, 2010 он
25. <https://apdc.mn/>
26. <https://bmcpregnancychildbirth.biomedcentral.com/articles/10.1186/1471-2393-13-174>
27. www.dsam.mn
28. <https://ncadv.org/blog/posts/domestic-violence-and-people-with-disabilities>
29. <http://www.ohchr.org/english/law/opportunities.htm>
30. <http://www.un.org/ecosocdev/geninfo/dpi1647e.htm>
31. <http://www.who.int/governance/eb/constitution/en/index.html>

[illegible]



ГЭР БҮЛИЙН ГИШҮҮН БҮР

-  ТЭГШ ЭРХТЭЙ ЭДЭЛНЭ.
-  ЭРХ ЗҮЙН МЭДЛЭГТЭЙ,
-  ЭРҮҮЛ, ЭЕРЭГ ХАРИЛЦААТАЙ,
-  ХАРИУЦЛАГАТАЙ,
-  ХҮЧИРХИЙЛЭЭС АНГИД БАЙНА



FamilyCenter.mn

ХАЙР ДҮҮРЭН АЗ ЖАРГАЛТАЙ ГЭР БҮЛ ТАНААС ЭХЛЭНЭ

